Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2025 оны ...... дүгээр сарын .....-ны өдрийн ............ дугаар захирамжийн хавсралт

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2025 оны 11 дүгээр сарын 27

| Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Хөрөнгийн эх үүсвэр | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | 2025 оны жилийн эцэс | | | Хэрэгжилтийн явц | Хэрэгжүүлэх байгууллага | | | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Батлагдсан Төсөв | Төсвийн гүйцэтгэл /сая төгрөг/ | | Хэрэгжилтийн хувь | Үндсэн | Хамтрагч | |
| **НЭГ: БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | | | | | |
| **Улаанбаатар "20 минутын хот"** | | | | | | | | | | | | | | | | |
| **1.1 Улаанбаатар "20 минутын хот" үзэл баримтлалын дагуу иргэд өөрийн оршин суух газраасаа 20 минутын зайд нийгмийн суурь үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | | |
| 1.1.1 "Сэлбэ", "Дэнжийн мянга" дэд төвүүдийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах замаар "Чингэлтэй хот"-ыг хөгжүүлнэ. | 1 | 1.1.1.1 Сэлбэ, Дэнжийн мянга дэд төвийн бүтээн байгуулалтын хүрээнд шаардлагатай судалгаа, мэдээллээр ханган хамтран ажиллана. | 2025-2028 | - | - | Санал, судалгаа, мэдээлэл | Тоо | 1 | 2 | - | - | Сэлбэ, дэнжийн мянга дэд төвийн бүтээн байгуулалтын хүрээнд газар чөлөөлөн шинээр бүтээн байгуулалтын ажил хийгдэх боломжтой 14 дүгээр хорооны 24,6 га газрын судалгааг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/3182 дугаартай албан бичгээр 2026 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар саналыг хүргүүлсэн. | 100% | ТГУХ | НОСК, НГЗБА | 90% |
| 1.1.2 Дэд төвд хүн амын хэрэгцээ шаардлагад тулгуурлан сургууль, цэцэрлэг, хүнсний зах, худалдааны болон ахуйн үйлчилгээний төвүүдийг байгуулна. | 2 | 1.1.2.1 Дэд төвд хүн амын хэрэгцээнд үндэслэн шинээр сургууль, цэцэрлэг болон үйлчилгээний төв байгуулах ажилд дэмжлэг үзүүлж ажиллана. | 2025-2028 | - | - | Санал, судалгаа, мэдээлэл | Тоо | 1 | 2 | - | - | Шинээр сургууль цэцэрлэг, үйлчилгээний төв байгуулах 9 дүгээр хорооны 2,2 га, 14 дүгээр хорооны 24,6 га газрын байршлын саналыг 2026 оны Нийслэлийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/3182, 01/3184 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлэв. | 100% | ТГУХ | НОСК, НГЗБА | 100% |
| 1.1.3 "Дэнжийн мянга дэд төвийг түшиглэн дүүргийн Төр захиргааны төв байр, Соёлын ордон, Албан хаагчдын орон сууц бүхий цогцолбор төвийг барьж байгуулна. | 3 | 1.1.3.1 "Дэнжийн мянга дэд төвийг түшиглэн дүүргийн Төр захиргааны төв байр, Ажилчдын орон сууц, Соёлын ордон барих газар чөлөөлөлтийг хийнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Чөлөөлсөн нэгж талбар | Тоо | 98 | 13 | 13,200.00 | 2,200.00 | Дүүргийн 9 дүгээр хороонд "Төр захиргааны байр" барилгын ажлын нөлөөлөлд өртсөн 112 нэгж талбараас 107 нэгж талбар бүрэн чөлөөлсөн, 3 нэгж талбар зөвшилцөх шатандаа, 2 нэгж талбар татгалзсан.<br>Мөн тус Төр захиргааны барилгын баруун хойд талд 2,2 га газар чөлөөлж сургууль, цэцэрлэг болон соёлын ордон барихаар 2026 оны Нийслэлийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/3184 дугаартай албан бичгээр хүргүүлж Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны 2026 оны төлөвлөгөөнд тусгасан. | 90% | ТГУХ | НГЗБА | 70% |
| | 4 | 1.1.3.2 Дэнжийн мянга дэд төвийг түшиглэн дүүргийн Төр захиргааны төв байр барих ажлыг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | 65,669.0 | Нийслэлийн төсөв | Хэрэгжилтийн хувь | Хувь | 10 | 30 | 19,700.0 | - | Чингэлтэй дүүргийн Нутгийн захиргааны байрны барилгын ажлыг Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/25 захирамжаар эрх шилжүүлж 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагаанаас тендер зарлан "Билгүүнмонгол" ХХК гүйцэтгэхээр сонгон шалгарсан. 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар барилгын ажил 50 хувьтай явж байгаа бөгөөд 2027 онд барилга угсралтын ажил дуусах төлөвлөгөөтэй байна. /Нийслэлийн төсвөөр хийж гүйцэтгэж байна./ | 100% | ТГУХ | НХОГ | 100% |
| | 5 | 1.1.3.3 Дэнжийн мянга дэд төвийг түшиглэн дүүргийн Ажилчдын орон сууц барих ажлыг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүрэг, төр хувийн хэвшлийн түншлэл | Хэрэгжилтийн хувь | Хувь | 0 | 10 | - | - | Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 840 айлын ажилчдын орон сууц байгуулахаар дүүргийн 9 дүгээр хорооны газар чөлөөлсөн 2,3 га газар дээр барилгын эх загвар зургийг боловсруулах шатандаа явж байгаа бөгөөд 2026 оны хавар барилгын ажлыг эхлүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. | 50% | ТГУХ | НХОГ | 30% |
| 1.1.4 Дүүргийн 7, 8, 9 дүгээр хороодын айл өрхийн газрыг байраар солих журмаар газар чөлөөлөлт хийнэ. | 6 | 1.1.4.1 Дүүргийн 7, 8, 9 дүгээр хороодын айл өрхийн газрыг байраар солих журмаар газар чөлөөлөлт хийнэ. | 2025-2028 | - | 0 | Хэрэгжилтийн хувь | Хувь | 0 | 10 | - | - | Дүүргийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/07 дугаар захирамжаар Гэр хорооллыг орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд ногоон нуур орчимд баригдаж буй 1008 айл орон сууцанд дүүргийн 7, 8, 9,10 дугаар хороо орчмын суурьшлын бүсийн газрыг орон сууцаар солих боломжтой айл, өрхтэй хэлцэл хийж газар чөлөөлөх арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Ажлын хэсгийн хүрээнд айл өрхийн судалгааг хороо бүрээр гарган, иргэдтэй уулзалт зохион байгуулж ажилласан. Тус ажил нь 2025 оны 07 дугаар сард Барилга хот байгуулалтын Яам руу шилжсэн. | 50% | ТЗУХ, Ажлын хэсэг | ЧДГЗБА | 30% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 32,900.00 | 2,200.00 | | | | | |
| **1.2 Дахин төлөвлөлтийг эрчимжүүлж, төвлөрлийг сааруулах замаар иргэдийн амьдрах орчныг сайжруулна.** | | | | | | | | | | | | | | | | |
| 1.2.1 Дүүргийн 7, 8, 9 дүгээр хороодын нутаг дэвсгэрт төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг хэрэгжүүлнэ. | 7 | 1.2.1.1 Дүүргийн 7, 8, 9 дүгээр хороодын нутаг дэвсгэрт төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | - | Нийслэлийн төсөв, Төр хувийн хэвшлийн түншлэл | Хэрэгжилт | Хувь | 0 | 10 | - | | Дүүргийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/07 дугаар захирамжаар Гэр хорооллыг орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд ногоон нуур орчимд баригдаж буй 1008 айл орон сууцанд дүүргийн 7, 8, 9,10 дугаар хороо орчмын суурьшлын бүсийн газрыг орон сууцаар солих боломжтой айл, өрхтэй хэлцэл хийж газар чөлөөлөх арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Ажлын хэсгийн хүрээнд айл өрхийн судалгааг хороо бүрээр гарган, иргэдтэй уулзалт зохион байгуулж ажилласан. Тус ажил нь 2025 оны 07 дугаар сард Барилга хот байгуулалтын Яам руу шилжсэн. | 50% | ТЗУХ, Ажлын хэсэг, ТГУХ | НОСБГ | 50% |
| 1.2.2 Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн орон сууцны оршин суугчдын саналыг үндэслэн төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дахин төлөвлөлтийн ажлыг хэрэгжүүлнэ. | 8 | 1.2.2.1 Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн орон сууцны оршин суугчдын саналыг үндэслэн төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дахин төлөвлөлтийн ажлыг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | - | Нийслэлийн төсөв, Төр хувийн хэвшлийн түншлэл | Дахин төлөвлөлтөд хамрагдсан орон сууц | Хувь | 0 | 1 | - | | Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Ашиглалтын шаардлага хангахгүй<br>нийтийн зориулалттай орон сууцыг буулган дахин барилгажуулах эрх олгох<br>тухай" А/634 дүгээр захирамжаар дүүргийн 4 дүгээр хорооны 6 дугаар байр, 6 дугаар хорооны 44 дүгээр байруудыг буулган дахин барилгажуулах үйл ажиллагааг үе шаттайгаар "Улаанбаатар орон сууцжуулалт" ХХК хэрэгжүүлж байна. Тус ажлын хүрээнд шаардлагатай мэдээ мэдээллийг тухайн хорооны Засар дарга нартай хамтран иргэд төслийн багтай барилгын ажлын эрчимжүүлэх талаар хамтарч ажиллаж байгаа бөгөөд 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар барилгын зураг төслийг боловсруулах шатандаа явж байна. 2026 онд барилга ажлыг эхлүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.<br>Мөн дүүргийн 1 дүгээр хорооны 12-р байрны оршин суугчдын дахин төлөвлөлтөд орох хүсэлтийг Нийслэлийн Орон сууцны бодлогын газарт 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 03/1860 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100% | ТГУХ | НОСБГ | 70% |
| 1.2.3 Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат, дээвэр, фасад, инженерийн шугам сүлжээг өргөтгөн шинэчилж, иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлнэ. | 9 | 1.2.3.1 Орон сууцны цахилгаан шат, дээвэр, фасад, инженерийн шугам сүлжээг өргөтгөн шинэчилнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Нийслэл, дүүргийн төсөв | Засварлаж шинэчилсэн орон сууц | Тоо | 8 | 30 | 5,432.9 | 4,739.1 | Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадын засвар, зураг төсөл, лифт засварлаж шинэчлэх хүрээнд төлөвлөсөн 92 ажлаас Бүрэн хэрэгжсэн 80, Хэрэгжиж байгаа 5 (НТХО-аар 5 дугаар хорооны 3, 4, 6, 7-р байрны фасад засварын гүйцэтгэгчээр Жаргалан хүлэмж ХХК шалгарч Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар гэрээ байгуулж 2026 онд ажлыг бүрэн дуусгахаар төлөвлөсөн. 1 дүгээр хороо 7/4 дүгээр байрны халуун, хүйтэн усны хэвтээ болон босоо шугам сольж засварлах ажилд Худалдан авах ажиллагаа зарлагдсан), Хэрэгжээгүй 7 (1, 2, 3 дугаар хорооны 7 лифт засварлах ажилд Худалдан авах ажиллагаа 4 удаа зарлаж оролцогчгүй тул амжилтгүй болсон, ажлын тоо хэмжээг хянаж 2026 оны төсвийн төсөлд саналд оруулсан.) /Санхүүжилт 2026 онд он дамжин хийгдэнэ./<br>2024,2025 онд магадлал хийгдсэн зураг, төсөвтэй Фасад засварын 44 ажлын саналыг Нийслэлийн 2026 оны төсөвт тусгуулахаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | 100% | ХСТНААХ | ТГУХ | 50% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.4 Цагдаа, түргэн тусламж, гал унтраах аврах ажиллагаа шуурхай хүрэх, нэвтрэх нөхцөл, иргэдийн зорчих боломжийг бүрдүүлж, гэр хороолол, зуслангийн бүсийн орц, гарц, орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчлийг арилгана. | 10 | 1.2.4.1 нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчлийн судалгааг гаргаж, төлөвлөгөөний дагуу шат дараатай газар чөлөөлөлтийн ажлыг эхлүүлж ажиллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Нийслэл, Дүүргийн төсөв | Арилгасан зөрчил | Тоо | 928 | 1255 | | 455.89 | 1. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, газар ашиглалтыг сайжруулах, явган хүний зам, талбайг нэмэгдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах хүрээнд газрын зөрчил арилгах НЗД-ын А/444, ДЗД-ын А/96 захирамжуудын хүрээнд 10 байршлын 720м хашаа, хайсыг чөлөөлөхөөс 9 байршлын 703м хашаа, хайсыг чөлөөлсөн ба 1 байршил нь буулгах шаардлагүй болсон. Иймд дүүргийн хэмжээнд хашаа, хайс арга хэмжээг 100% гүйцэтгэж дуусгасан.<br>2. Тус дүүргийн 24 дүгээр хорооны нутаг дэвсгэр буюу зуслангийн бүсэд 52 байршлын 316 м төмөр болон модон хашааг чөлөөлсөн ба биелэлт 100% 3. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 14 байршлын 112 гараашийн газрыг чөлөөлөхөөс 6 байршлын 50 гараашийг буулган газар чөлөөлөлтийг хийгээд байна. | 100% | ТГУХ | ДГЗБХ | 90% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 5,432.85 | 5,194.9 | | | | | |
| **1.3 Эрчим хүчний эх үүсвэр, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар тасралтгүй найдвартай байдлыг хангаж, иргэдийн амьдрах таатай орчныг сайжруулна.** | | | | | | | | | | | | | | | | |
| 1.3.1 “Дэнжийн мянга дэд төв”-ийн 50 МВт-ын хийн болон “Дамбадаржаа дэд төв”-ийн 63МВт-ын дулааны эх үүсвэрт тухайн нутаг дэвсгэрт байрлах аж ахуйн нэгж байгууллага, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төр захиргааны байр, албан хаагчдын орон сууцны хэрэглэгчдийн холбогдох нөхцөлийг бүрдүүлнэ. | 11 | 1.3.1.1 “Дэнжийн мянга дэд төв”-ийн 50 МВт-ын хийн болон “Дамбадаржаа дэд төв”-ийн 63МВт-ын дулааны эх үүсвэрт тухайн нутаг дэвсгэрт байрлах аж ахуйн нэгж байгууллага, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төр захиргааны байр, албан хаагчдын орон сууцны барилгыг холбох саналыг хүргүүлнэ. | 2025-2028 | - | - | Санал, судалгаа, мэдээлэл | Тоо | 0 | 4 | - | - | "Дэнжийн мянга дэд төв"-ийн 50 МВт-ын хийн дулааны эх үүсвэрт 10 дугаар хороонд баригдахаар төлөвлөж буй дүүргийн Нэгдсэн эмнэлгийн барилгын дулааныг холбохоор Эрчим хүчний яаманд 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 01/2865 дугаар бичгээр хандсан боловч 2024 оны 12 дугаар сарын 09 өдрийн байдлаар тус төсөл эхлэх хугацаа болоогүй байгаа тул боломжгүй гэсэн хариу ирсэн. Иймд тухайн төсөл хэрэгжих үед дулаан хангамжийн холболтын ажлыг шийдвэрлүүлэхээр саналыг хүргүүлнэ. | 100% | ТГУХ | УБДС ТӨХК | 30% |
| 1.3.2 Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг тархмал хэлбэрээр гэр хороололд суурилуулах төслийг төр-хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэлд үндэслэн хэрэгжүүлнэ. | 12 | 1.3.2.1 Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр болох нарны панелийн системийг гэр хорооллын айл өрхөд суурилуулах ажлыг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв, гадаадын зээл тусламж | Хэрэгжилт | Хувь | 0 | 20 | 1,050.00 | 1,050.00 | Гэр хорооллын айл өрхүүдэд сэргээгдэх эрчим хүчинд түшиглэсэн халаалтын шийдлийг хувийн хэвшил, олон улсын байгууллагатай хамтран үе шаттай хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн 15, 16, 17, 22 дугаар хороонд Нарны илч төслийг хэрэгжүүлж, НҮБХХ-тэй хамтран гэр хорооллын 83 хүртэлх айл өрхөд сэргээгдэх эрчим хүчинд түшиглэсэн халаалтын төхөөрөмж суурилуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>Мөн дүүргийн 17 дугаар хороодод 300 айл өрхөд монгол гэр, байшингийн нүүрс түлдэг зуухыг эрчим хүчний хэмнэлттэй агаар-агаарын дулааны насосоор сольж, байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх "Heat pump" төслийн ажлыг НҮБХХ болон Голомт банктай хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд эхний 102 айл өрхөд суурилуулах ажлыг хэрэгжүүлээд байна. | 100% | ТЗУХ, Ажлын хэсэг | Хороод | 90% |
| 1.3.3 Дүүргийн нутаг дэвсгэр дэх Таван буудал, Хайлааст, Чингэлтэй, Дэнжийн мянга орчмын газар чөлөөлөлтийг үргэлжлүүлж, орон сууцжуулах бодлого баримтлан агаар, орчны бохирдлыг бууруулна. | 13 | 1.3.3.1 Дүүргийн нутаг дэвсгэрт орон сууцжуулалт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд газар чөлөөлөлтийн ажлыг үргэлжлүүлж, агаар орчны бохирдлыг бууруулна. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Нийслэл, дүүргийн төсөв | Чөлөөлөгдсөн нэгж талбар | Тоо | 1500 | 50 | - | 8,750.0 | 2025 онд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 39 айлын газруудыг чөлөөлж ажиллав. Үүнд:<br>- Чингэлтэй дүүргийн Төр захиргааны байр (4 айл)<br>- Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалт (2 айл)<br>- 126 дугаар цэцэрлэгээс Чингэлтэй дүүргийн Түргэн тусламжийн төв хүртэлх авто зам (1 айл)<br>- СУИС-ийн баруун талд авто зам өргөтгөх (1 айл)<br>- Дүүргийн нэгдсэн эмнэлгийн бие даасан дулааны эх үүсвэрийн барилга (17 айл)<br>- Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга (2 айл)<br>- 173 дугаар цэцэрлэгийн зогсоол (4 айл)<br>- Үерийн хамгаалалтын далан суваг (1 айл)<br>- 37 дугаар сургуулийн спорт заал (6 айл)<br>- Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт "Төрийн захиргааны байгууллага" барих (6 айл)<br>Мөн Сэлбэ дэд төвийн нөлөөлөлд өртөөгүй дараагийн ээлжид барилгажуулах 14 дүгээр хорооны 24,6 га газрыг чөлөөлж барилгажуулахаар Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд 2025 оны 11 дугаар сарын 04-ний өдрийн 01/3182 дугаартай албан бичгээр саналыг хүргүүлсэн. | 80% | ТГУХ | НГЗБА | 70% |
| 1.3.4 Гэр хорооллын алслагдсан хороодод сэргээгдэх эрчим хүчний болон хэсэгчилсэн инженерийн дэд бүтцийг бий болгож, агаар, хөрсний бохирдлыг бууруулна. | 14 | 1.3.4.1 Алслагдсан гэр хороололд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр болох нарны панелын системийг суурилуулах айл өрхүүд болон иргэдийг мэдээллээр хангах зорилгоор сургалт зохион байгуулж ажиллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв, гадаадын зээл тусламж | Сургалт, уулзалтад хамрагдсан айл өрх | Тоо | 0 | 100 | | | Гэр хорооллын айл өрхүүдэд сэргээгдэх эрчим хүчинд түшиглэсэн халаалтын шийдлийг хувийн хэвшил, олон улсын байгууллагатай хамтран үе шаттай хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн 15, 16, 17, 22 дугаар хороонд Нарны илч төслийг хэрэгжүүлж, НҮБХХ-тэй хамтран гэр хорооллын 83 хүртэлх айл өрхөд сэргээгдэх эрчим хүчинд түшиглэсэн халаалтын төхөөрөмж суурилуулах ажлыг зохион байгуулж холбогдох сургалт, зааварчилгааг хүргүүлж ажилласан.<br>Мөн дүүргийн 17 дугаар хороодод 300 айл өрхөд монгол гэр, байшингийн нүүрс түлдэг зуухыг эрчим хүчний хэмнэлттэй агаар-агаарын дулааны насосоор сольж, байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх "Heat pump" төслийн ажлыг НҮБХХ болон Голомт банктай хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд эхний 102 айл өрхөд суурилуулах ажлыг хэрэгжүүлж, сургалт мэдээллээр хангаж Дүүргийн Тусгаар тогтнолын талбайд танилцуулга, өдөрлөгийг 2025 оны 09 дүгээр сарын 12,13-ны өдрүүдэд зохион байгуулж ажилласан. | 100% | ТЗУХ, Ажлын хэсэг, ХСТНААХ | Хороод | 90% |
| 1.3.5 Голуудын эргийн хамгаалалтын далан, үерийн эрсдэл бүхий байршил дахь айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх, чөлөөлөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, далан суваг, хөв цөөрөм, хөрсний усны шугам сүлжээг барьж, үерийн усны эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлнэ. | 15 | 1.3.5.1. Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөтэй уялдуулан бороо, үерийн ус болон хөрсний ус зайлуулах байгууламжийг нэмэгдүүлж үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Үерийн байгууламжийн урт | Метр | 150 | 100 | 432.60 | | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Салхит орчмын үерийн хамгаалалтын суваг хийх ажил (19 дүгээр хороо)” төсөл арга хэмжээ (Үерийн хамгаалалтын сувгийн урт 185 метр)-г “Төрөлхмөрөн” ХХК хэрэгжүүлэн ажилласан. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай, комисс ажиллуулах хүсэлтээ хүргүүлсэн. /Санхүүжилтийг 2026 онд он дамжин хийгдэнэ./<br>7-р хороо, Хувьсгалчдын “Г” 9 дүгээр гудамжинд 6 у/м ус зайлуулах суваг, 10 у/м далан барих ажлыг Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨААТҮГ-аар хийж гүйцэтгүүлсэн. | 30% | ХСТНААХ | ТГУХ | 30% |
| | 16 | 1.3.5.2. Голуудын эргийн хамгаалалтын далан, үерийн эрсдэл бүхий байршил дахь айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх, чөлөөлөх ажлыг зохион байгуулна. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Улс, нийслэл, дүүргийн төсөв | Нүүлгэн шилжүүлсэн айл өрх | Тоо | 1 | 2 | - | | Үерийн эрсдэлтэй бүсэд байршиж буй айл өрхүүдэд дүүргийн ОБХ-тэй хамтарч үерийн эрсдэлээс сэргийлэх, шаардлагыг хүргүүлж ажилласан. | 70% | ХСТНААХ | ГЗБА | 30% |
| 1.3.6 Хүчдэлийн уналттай айл өрхийг найдвартай цахилгаан эрчим хүчээр хангах, хүчдэлийн уналтыг бууруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна. | 17 | 1.3.6.1. Цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг найдвартай цахилгаан эрчим хүчинд холбох, хүчдэлийн уналтыг бууруулах ажлыг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Улс, нийслэл, дүүргийн төсөв | Айл өрх | Тоо | 81 | 81 | 19.8 | | Цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй, хүчдэлийн уналттай айл өрхүүдийн тоог бууруулахаар Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн “Дүүргийн 2025 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 16 дугаар тогтоолд “Дүүргийн нутаг дэвсгэрт айл өрхүүдийн эрчим хүчний уналттай хэсэгт цахилгааны дэд өртөө байгуулах ажлын зураг төсөл” арга хэмжээг тусгуулан дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-с техникийн нөхцөл гаргуулан авч зураг төсөл боловсруулах байгууллагатай гэрээ байгуулахаар ажиллаж байна.<br>Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд хороодын нутаг дэвсгэрт цахилгаан эрчим хүчний хүчдэл уналттай айл өрх, шугам татах, хазайлттай шонг тэгшлэх, суурилуулах, КТП дэд станцын засвар үйлчилгээний ажлын жагсаалтыг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 03/2896 тоот албан бичиг хүргүүлсэн.<br>Мөн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд цахилгаан эрчим хүчний уналттай айл өрхийн судалгаа болон шинэчлэлт, засвар үйлчилгээнд шаардагдах төсвийн саналыг гарган хүргүүлсэн. | 100% | ХСТНААХ | ТГУХ | 70% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 1,502.40 | 9,800.0 | | | | | |
| **АВТО ЗАМ** | | | | | | | | | | | | | | | | |
| **1.4 Авто замын сүлжээ төлөвлөлтийг сайжруулан, авто замын хүртээмжийг нэмэгдүүлж, түгжрэлийг бууруулна.** | | | | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4.1 Авто зам, замын гүүрэн байгууламж, үндсэн сүлжээ, тойрог болон туслах зам, замын ус зайлуулах шугам сүлжээний шинэчлэлтийн ажил, зам засварлах ажлуудыг хэрэгжүүлнэ. | 18 | 1.4.1.1. Авто зам, замын гүүрэн байгууламж, үндсэн сүлжээ, тойрог болон туслах замыг нэмэгдүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Нийслэл, Дүүргийн төсөв | Замын урт | Метр | 137,500 | 139,500 | 3,868.00 | - | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар Чингэлтэй эцсийн буудлаас Зүрх уулын фитнес хүртэлх авто зам, гэрэлтүүлгийн ажил (23 дугаар хороо) төсөл арга хэмжээ (Авто замын байгууламжийн урт 1,58км)-г хэрэгжүүлэхээр дүүргийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж авто замын байгууламжийн ажлыг “Нано экологи” ХХК, гэрэлтүүлэг, цахилгааны ажлыг “Өндрийн удам” ХХК шалгаран гэрээ байгуулж авто замын трасст өртсөн цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг шилжүүлэх ажил хийгдсэн. Авто замын байгууламжийн газар шорооны ажлыг 2026 оны 5 дугаар сард эхлүүлэхээр төлөвлөөд байна.<br>Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Бодь пропертийз" ХХК-ийн хэрэгжүүлж буй “Урт цагаан жуулчны гудамжны тохижилтын ажил (Улаанбаатар хот)” төсөл арга хэмжээний хүрээнд 3 дугаар хороонд 235 у/м авто замын ажил шинээр хийгдсэн.<br>Мөн 15 дугаар хороо, Жаргалантын 2 дугаар гудамжинд гудамж сайжруулах ажлын хүрээнд 133 у/м байгалийн чулуун хучилттай авто замын ажлыг Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨААТҮГ гүйцэтгэсэн. | 100% | ХСТНААХ | НЗХГ | 50% |
| | 19 | 1.4.1.2. Авто замын ус зайлуулах шугам сүлжээ шинээр хийх болон шинэчлэх, засварлах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Нийслэл, дүүргийн төсөв | Замын урт | Метр | 0 | 200 | 561.70 | | Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Авто замын борооны ус зайлуулах шугамын ажил (2, 4, 6 дугаар хороо)” төсөл арга хэмжээ (авто замын борооны ус зайлуулах шугамын урт 1220 метр)-ний холбогдох материалуудыг дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлж, худалдан авах ажиллагааг 5 удаа зохион байгуулсан боловч аж ахуй нэгж шалгараагүй.<br>Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Бодь пропертийз" ХХК-ийн хэрэгжүүлж буй “Урт цагаан жуулчны гудамжны тохижилтын ажил (Улаанбаатар хот)” төсөл арга хэмжээний хүрээнд 3 дугаар хороонд 235 у/м зам талбайн ус зайлуулах шугам сүлжээний ажил шинээр хийгдсэн. | 100% | ХСТНААХ | НЗХГ, ГУББГ | 30% |
| | 20 | 1.4.1.3. Дүүргийн нутаг дэвсгэр дэх авто замын засвар шинэчлэлтийн ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Нийслэл, дүүргийн төсөв | Замын урт | Метр | 0 | 1000 | 4,733.50 | 4,733.50 | Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Лааганы гудамжны авто зам (Их тойруугийн авто замаас Самбуугийн гудамж хүртэл)” төсөл арга хэмжээг “Киото хайвэй” ХХК хэрэгжүүлэн 0,6 км авто замын засвар шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэн комисс ажиллуулах хүсэлтээ хүргүүлээд байна. 736.28 сая Чингэлтэй дүүргийн 13, 15, 16, 22 дугаар хороо Чингэлтэйн өргөн чөлөөнөөс Хайлаастын эцэс хүртэлх 4 км авто замын засвар шинэчлэлтийг Нийслэлийн Замын хөгжлийн газраас гүйцэтгүүлсэн. 3,997.2 сая | 100% | ХСТНААХ | НЗХГ | 100% |
| 1.4.2 Сургууль, цэцэрлэг, эмнэлэг орчимд авто замын аюулгүй байдлыг хангасан цогц төсөл, арга хэмжээг санаачлан хэрэгжүүлнэ. | 21 | 1.4.2.1. Сургууль, цэцэрлэг, эмнэлэг орчмын авто замын аюулгүй байдлыг хангах ажлыг хотын стандартад нийцүүлэн хэрэгжүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Улс, нийслэл, дүүргийн төсөв | Төсөл, арга хэмжээ | Тоо | 0 | 1 | - | ХОББДТ | Ерөнхий боловсролын 39 дүгээр сургууль, 57 дугаар сургууль, 292 дугаар цэцэрлэг орчмын авто замуудын аюулгүй байдлыг хангаж сургууль орчмын бүсийн стандартын дагуу хурд сааруулагч, явган хүний гарцын тэмдэг тэмдэглэгээ хийх, 33 дугаар цэцэрлэгийн баруун, зүүн талд явган хүний гарцын тэмдэг тэмдэглэгээ шинээр хийх ажлыг Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ-аар хийж гүйцэтгүүлсэн.<br>Мөн дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Ерөнхий боловсролын 117 дугаар сургууль, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын 145 дугаар сургуулийн гадна орчны замын аюулгүй байдлыг хангахаар дүүргийн Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ зураг төслийг боловсруулан ажиллаж байна. | 100% | ХСТНААХ | НЗХГ | 90% |
| 1.4.3 Авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлж, газар дээрх болон доорх зогсоолыг төр-хувийн хэвшлийн хамтын санхүүжилт, менежментийн зарчмаар барьж байгуулах ажлыг эрчимжүүлнэ. | 22 | 1.4.3.1. Авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлж, газар дээрх болон доорх зогсоолыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Улс, нийслэл, дүүрэг, хувийн хэвшлийн санхүүжилт төсөв | Авто зогсоол | Тоо | 0 | 1 | - | | Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Бодь пропертийз" ХХК-ийн хэрэгжүүлж буй “Урт цагаан жуулчны гудамжны тохижилтын ажил (Улаанбаатар хот)” төсөл арга хэмжээний хүрээнд газар доорх 109 авто машины зогсоол бүхий ногоон байгууламжийн тохижилтын ажил хийгдэж, нийт ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна.<br>Мөн тус дүүргийн 4 хорооны цогцолбор барилгын ажлын хүрээнд 9 авто машины зогсоолын тохижилтын ажил хийгдсэн.<br>Дүүргийн нутаг дэвсгэр дэх ил болон далд авто зогсоол байгуулах боломжит байршлын судалгааг гаргаж Хот байгуулалт, Хотын стандартын газарт 2025 оны 03/1145 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 70% | ХСТНААХ | ТГУХ | 70% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 9,163.20 | 4,733.5 | | | | | |
| **НИЙТИЙН ТЭЭВЭР** | | | | | | | | | | | | | | | | |
| **1.5 Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | | |
| 1.5.1 Нийтийн тээврээр зорчигчдын ая тухтай байдлыг хангаж, нийтийн тээврийн дундын болон эцсийн зогсоолуудыг дулаан саравч бүхий тохилог орчинтой болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 23 | 1.5.1.1. Нийтийн тээврээр зорчигчдын ая тухтай байдлыг хангаж, нийтийн тээврийн дундын болон эцсийн зогсоолуудыг дулаан саравч бүхий тохижилттой болгох ажлыг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Улс, нийслэл, дүүргийн төсөв | Тохилог зогсоол | Тоо | 2 | 1 | 200.00 | | Дүүргийн 24 дүгээр хороо, Зунжин худалдааны төв, Жигжидийн уулзварын нийтийн тээврийн автобусны буудлуудад тус тус дулаан зогсоол бүхий тохижилтын ажлыг "Эс Би Жи глобол" ХХК гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. /Санхүүжилт 2026 онд он дамжиж хийгдэнэ./ | 100% | ХСТНААХ | ТГУХ | 90% |
| 1.5.2 Гэр хорооллын дундах авто замыг өргөтгөн шинэчилж, нийтийн тээврээр зорчих боломжийг бүрдүүлэн, иргэдэд үйлчлэх чиглэлийг нэмэгдүүлнэ. | 24 | 1.5.2.1. Гэр хорооллын дундах авто зам, автобусны буудлын зорчих хэсгийг өргөтгөн шинэчилж, нийтийн тээврээр зорчих боломжийг бүрдүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Улс, нийслэл, дүүргийн төсөв | Өргөтгөж шинэчилсэн байршил | Тоо | 0 | 1 | - | | Дүүргийн 22 дугаар хорооны нутаг дэвсгэрийн 4 байршилд авто замын зорчих хэсгийг өргөтгөх, бага оврын нийтийн тээврийн автобусны буудлын зогсоол байгуулах ажлын зураг төсөв хийлгэхээр боломжит байршлын судалгааг гаргасан. | 100% | ХСТНААХ | НЗХГ | 30% |
| | 25 | 1.5.2.2. Гэр хорооллын дунд нийтийн тээврээр иргэдэд үйлчлэх чиглэлийг нэмэгдүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Улс, нийслэл, дүүргийн төсөв | Нэмэгдүүлсэн чиглэл | Тоо | 0 | 1 | 600.00 | | Алслагдсан хороодод үйлчлэх дунд оврын 2 автобусыг дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авч, Нийтийн тээврийн бодлогын газраас ирүүлсэн богино эргэлтийн маршрутын дагуу дүүргийн 16, 22 дугаар хороодод нийтийн тээврийн үйлчилгээнд явуулахаар бэлтгэн ажил ханган ажиллаж байна. /Санхүүжилт 2026 онд он дамжиж хийгдэнэ./ | 100% | ХСТНААХ | ТГУХ | 100% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 800.00 | 0.0 | | | | | |
| **ХОЁР: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | | | | | |
| **БОЛОВСРОЛ** | | | | | | | | | | | | | | | | |
| **2.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдлагын менежментийг сайжруулж, олон улсын сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлэн сургалтын чанар, гүйцэтгэлийн зөрүүтэй байдлыг арилгана.** | | | | | | | | | | | | | | | | |
| | 26 | 2.1.1.1 Багш нарын мэдлэг ур чадварыг сайжруулах, хөгжүүлэхэд чиглэсэн олон төрөлт үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | 240.0 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагаа | Тоо | 5 | 6 | 50.00 | 30.00 | Багш нарын мэдлэг ур чадварыг сайжруулах, хөгжүүлэхэд чиглэсэн олон төрөлт үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 2025 онд нийт 36 үйл ажиллагааг зохион байгуулж, давхардсан тоогоор 15386 багшийг хамруулсан. Тухайлбал: Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарын мэдлэг ур чадварыг сайжруулах, хөгжүүлэх чиглэлээр дүүрэг, нийслэл, Боловсролын ерөнхий газар, Боловсролын яамтай хамтран 2, 7, 9 жилийн үндсэн сургалтад 25 багш удирдах ажилтанг, график сургалтад 3642 багшийг хамруулсан. Бусад байгууллагатай хамтарсан сургалтад давхардсан тоогоор 83 эрхлэгч, 92 арга зүйч, 421 бүлгийн багш, 57 хөгжмийн багш, 53 хөдөлгөөн эрүүл мэндийн багш тус тус хамрагдсан. Ажлын байран дээрх чадавхжуулах сургалтад 361 багш, удирдах ажилтан хамрагдсан бөгөөд багшийн туслах нарыг чадавхжуулах чиглэлээр "Ур авьяас 2025" уралдааныг цэцэрлэг, бүс, дүүргийн хэмжээнд 3 үе шаттайгаар зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 813 туслах багш хамрагдсан. Дүүргийн хэмжээнд сайн хичээл, үйл ажиллагааны арга зүй туршлагаа түгээн дэлгэрүүлэх зорилгоор 38 цэцэрлэгийн дунд Үзүүлэх ажлыг 9 удаа зохион байгуулж, Боловсролын Ерөнхий газраас зохион байгуулсан "Цахим аялал" интерактив контентыг таниулах, хэрэглээ болгох онлайн сургалтад сургуулийн өмнөх боловсролын 38 байгууллагын 392 багш ажилтныг хамруулсан. "Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн карьер хөгжлийг дэмжих, төрийн албан дахь удирдах түвшний жендэр" сургалт, зөвлөгөөнд СӨББ, ЕБС-ийн 42 удирдах албан хаагч, "Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, шийдвэр гаргалт" сэдэвт сургалтад Ерөнхий боловсролын суургууль цэцэрлэгийн захирал, эрхлэгч, сургалтын менежер зэрэг 78 удуирдах албан тушаалтан хамрагдсан. Мөн усан спортын сургалтад сурагчдаа бэлтгэх зорилгоор 18 сургуулийн 32 багшийг чадавхжуулах сургалтад хамруулсан. | 100% | НХХ | БХ | 100% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.1 Боловсролын байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, боловсролын ялгааг арилгах зорилгоор "Чингэлтэйн боловсрол-2028" арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ. | 27 | 2.1.1.2 Удирдлагын менежмент, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулахад чиглэсэн олон төрөлт үйл ажиллагааг зохион байгуулна. | 2025-2028 | 130.0 | Дүүргийн төсөв | Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний дундаж | Хувь | СӨБ- 89.84<br>ЕБС- 79.43 | СӨБ- 89.9<br>ЕБС- 79.5 | 25.00 | 10.00 | Удирдлагын менежмент, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулахад чиглэсэн олон төрөлт үйл ажиллагааг зохион байгуулах, байгууллага, багшийн гүйцэтгэлийн үнэлгээ, элсэлтийн шалгалтын чанарыг дээшлүүлэх зорилгоор төрийн өмчийн 19 сургуульд зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, нийслэл, Боловсролын ерөнхий газраас зохион байгуулсан СӨББ-ын багш, удирдах ажилтны цахим болон танхимын 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1311 багш, 340 удирдах ажилтанг хамруулсан. Сургуулийн өмнөх боловсролын үндэсний сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулга, арга зүйг хэрэгжүүлэх арга замыг бүсийн түвшний сургагч багш нарт танилцуулж, орон нутгийн багш, удирдах ажилтантай хамтран хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих мэдлэг, чадварыг эзэмшүүлэх зорилгоор дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарын дунд “Сургуулийн өмнөх боловсролын үндэсний сургалтын хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх сургалт”-ыг зохион байгуулж, 400 гаруй багшийг хамруулсан. 2025-2026 оны хичээлийн жилд Англи хэлний Pearson хөтөлбөр хэрэгжүүлэх сургагч багш бэлтгэх сургалтад 4 багш, Eduten цахим системийн суурь боловсрол олгох сургалтад 17 математикийн багш, 17 менежер оролцсон. Мөн Mozaik цахим системийн сургалтад ахлах ангийн сургалтын менежерүүдийг онлайнаар, захирлуудыг танхимаар 100 хувь хамруулсан. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд 38 цэцэрлэгийн 310 багш хамрагдсан бөгөөд хүүхдийн хөгжлийн үнэлгээний үр дүнгээр 91,35%-тай үнэлэгдсэн. Ерөнхий боловсролын сургуулийн байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 19 сургуулийн 1084 багш шалгагдаж, давхардсан тоогоор 19586 суралцагч, эцэг эх асран хамгаалагч санал асуулгад хамрагдсан. 2024-2025 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний улсын дундаж-83.92%-тай, харин дүүргийн дундаж-80.71 хувьтай үнэлэгдсэн нь өмнөх жилийн дүүргийн дунджаас 1.28%-аар өссөн үзүүлэлттэй байна. | 100% | НХХ | БХ | 100% |
| | 28 | 2.1.1.3 Насан туршийн суралцахуйг дэмжин, хөгжих боломжийг хангах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. | 2025-2028 | 600.0 | Орон нутгийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 0 | 30 | 150.00 | - | Төмөр замын дээд сургуультай хамтран мэргэжил сурталчлах өдөрлөгийг зохион байгуулж, Ерөнхий боловсролын 37, 50, 61, 72, 117 дугаар сургуулийн нийт 450 сурагчийг оролцуулсан. Мөн Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад мэргэжлээ зөв сонгоход нь туслах, дэмжлэг үзүүлэх зорилгоор 2025 оны 5 дугаар сарын 9-ний өдрөөс 11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Ulaanbaatar Edu Expo-2025" арга хэмжээнд дүүргийн 11, 12 дугаар ангийн 3487 сурагчийг хамруулсан. Нийслэлийн Боловсролын газраас нийслэлийн хэмжээний зорилтот 20 сургуулийн багш, сурагчдад зориулсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, үнэлгээ өгөх сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд зохион байгуулсан ба уг сургалтад ерөнхий боловсролын 37 дугаар сургуулийн 42 багш, 39 дүгээр сургуулийн 38 багш хамрагдсан. Боловсролын яамнаас зохион байгуулсан сайн дурын оролцоотой хүүхдийн хөгжил, сурлагын хоцрогдлыг арилгахад дэмжлэг үзүүлэх "EDU-VOLUNTEER" хөтөлбөрт 40 багш, зорилтот 40 сурагчийг хамруулсан. | 100% | НХХ | НТСТ, БХ | 100% |
| 2.1.2 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад Олон улсын I'm brick, Steam, Montessori зэрэг хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 29 | 2.1.2.1 Олон улсын хөтөлбөр болон цахим технологийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулна | 2025-2028 | 165.0 | Дүүргийн төсөв | Олон усын хөтөлбөртэй байгууллага | Тоо | Монтессори-7<br>Стийм-21<br>Айм брийк-10 | Монтессори-14<br>Стийм-21<br>Айм брийк-17 | 30.00 | 16.00 | Чингэлтэй дүүргийн хэмжээнд “I’m brick”, "Стеам" хөтөлбөр хэрэгжүүлэгч цэцэрлэгүүдийн дунд жил бүр зохион байгуулдаг “Зохион бүтээгч хүүхэд" ур чадварын тэмцээнд 31 цэцэрлэгийн 155 хүүхэд хамрагдсан. "ШИМТ" хөтөлбөрийн "STEAM" хэрэглэгдэхүүнээр сургуулийн өмнөх боловсролын 21 байгууллагыг бүрэн хангаж, сурч боловсрох орчин нөхцөлийг сайжруулах, сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх замаар 2-5 настай хүүхдийн бүтээлч сэтгэлгээ, зохион бүтээх ур чадварыг хөгжүүлэхэд анхааран ажиллалаа. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг "STEAM" хэрэглэгдэхүүнээр хангаснаар олон улсын болон улсын чанартай инженерчлэл ур чадварын тэмцээн, багш нарын дундах илтгэлийн уралдаануудад амжилттай оролцож, сайн туршлага, ололт амжилтаа түгээн ажиллаж байна. Олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч цэцэрлэгүүдийн дунд зохион байгуулдаг "I GREEN MECH CHINGELTEI 2025" тэмцээнийг зохион байгуулж, 20 цэцэрлэгийн 80 хүүхэд, 20 багшийг оролцуулсан. Уг тэмцээний дүүргийн шатанд шалгарсан 173, 37 дугаар цэцэрлэгийн багш, суралцагчид дараагийн шатны улсын хэмжээний тэмцээнд оролцсон ба 37 дугаар цэцэрлэг шалгарч, Олон улсын тэмцээнээс "Тусгай байр"-нд шалгарсан. Олон улсын тэмцээнд оролцоход шаардагдах зардалд дүүргийн ЗДТГ-аас 16 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. | 100% | НХХ | БХ | 100% |
| 2.1.3 Боловсролын салбарт олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, сайн туршлагаас суралцан түгээх чиглэлээр багш, сурагч солилцооны хөтөлбөрийг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. | 30 | 2.1.3.1 Хамтын ажиллагаатай улс орнуудын талаарх сургалт сурталчилгааны ажил зохион байгуулж, багш сурагчдыг тус орны талаарх мэдлэг дээр түшиглэн уралдаан тэмцээн зохион байгуулна. | 2025-2028 | 90.0 | Дүүргийн төсөв | Зохион байгуулсан арга хэмжээ | Тоо | 2 | 3 | 15.00 | - | Хамтын ажиллагааг эрчимжүүлэх, сайн туршлагаа түгээх чиглэлээр "Адина" ТББ-тай хамтран "Тэгш хамрах боловсролын төсөл"-ийг Ерөнхий боловсролын 117 дугаар сургуульд хэрэгжүүлж, нийт 1542 сурагчийг хамруулсан. Японы Хүүхдийг Ивээх сантай хамтран "Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийг хэрэгжүүлж, төсөлд дүүргийн 18, 83 дугаар цэцэрлэгүүд хамрагдаж байна. Япон улсын Эрүүл хотуудыг дэмжигч байгууллагатай хамтран Ерөнхий боловсролын 50, 37 дугаар сургуулиудад шүдний төслийг хэрэгжүүлж, ирэх оноос Ерөнхий боловсролын 39 дүгээр сургуулийг хамруулахаар бэлтгэл ажлыг хангаан ажиллаж байна. БНСУ-ын ”Бүтээлчээр хөгжүүлье” Олон улсын I’m world хөтөлбөр, Боловсролын үзэсгэлэн, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын тэгш хамруулах боловсролын хөтөлбөрт 7 удирдах ажилтанг, Ерөнхий боловсролын сургуулийн Багшийн хөгжил хариуцсан менежерүүдийн сургалтад 19 менежерийг тус тус хамруулсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас “Хамтдаа гэрэлтэх оюунлаг ирээдүй” ТББ-тай хамтран зохион байгуулсан Ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтан, багш нарт зориулсан “Шинэ цагийн багш” сургалтад 50 багшийг хамруулж ажилласан. | 100% | НХХ | БХ | 90% |
| | 31 | 2.1.3.2 Хувь хүний хөгжил, мэргэжлийн чиглэл, хүсэл сонирхолыг тодорхойлон хөгжүүлэх чиглэлээр багш, сурагч солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | 280.0 | Дүүргийн төсөв | Хамрагдсан багш, сурагчид | Тоо | 20 | 25 | 50.00 | 12.00 | Чингэлтэй дүүрэг, Турк улсын Пендик хотын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн сурагч солилцооны хөтөлбөрт Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн Англи хэлний багш С.Батчимэг ахлагчтай Ерөнхий боловсролын 117, 61, 57, 37 дугаар сургуулийн сурагчдын бүрэлдэхүүн 2025 оны 06 дугаар сарын 29-ний өдрөөс 07 дугаар сарын 06-ны өдөр хүртэлх хугацаанд хамрагдсан. Чингэлтэй дүүрэг Япон улсын Шизүока мужийн Яйзү хотын хамтын ажиллагааны хүрээнд “Сурагч солилцоо”-ны хөтөлбөрт Ерөнхий боловсролын 39, 49, 72, 149 дүгээр сургуулийн 6 сурагч 10 дугаар сарын 23-ны өдрөөс 27-ны өдрийн хооронд хамрагдсан. БНХАУ-ын боловсролын олон улсын солилцооны нийгэмлэгээс санаачлан зохион байгуулдаг Хятадын олон улсын боловсролын үзэсгэлэн Чэнду мужид зохион байгуулагдсан ба дүүргийн Ерөнхий боловсролын 5, 23, 49, 50 61 дүгээр сургуулийн захирлууд оролцож, туршлага солилцсон. Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 2025-2026 оны хичээлийн жилд гадаад улсад англи хэлний түвшин ахиулах богино хугацааны (30 хоног) сургалтад хамруулах сонгон шалгаруулалтад бага ангийн 1 багш, англи хэлний 6 багш, 2 мэргэжилтнийг хамруулахаар Нийслэлийн Боловсролын газарт санал хүргүүлсэн. | 100% | НХХ | БХ | 100% |
| 2.1.4 Багш нарын мэдлэг ур чадварыг сайжруулахад чиглэсэн олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлж, дотоод гадаадын урт болон богино хугацааны сургалтад хамрагдахыг дэмжинэ. | 32 | 2.1.4.1 Багш нарын цахим сургалтын арга зүй, чадварыг нэмэгдүүлэх цахим, танхим хосолсон сургалтуудад хамруулна. | 2025-2028 | 65.0 | Дүүргийн төсөв | Зохион байгуулсан арга хэмжээ | Тоо | - | 5 | 10.00 | - | Боловсролын Ерөнхий газраас "Цахим аялал" интерактив контентыг таниулах, хэрэглээ болгох онлайн сургалтад Сургуулийн өмнөх боловсролын 38 байгууллагын 392 багш, ажилтныг хамруулсан. Сургуулийн өмнөх боловсролын үндэсний сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулга, арга зүйг хэрэгжүүлэх арга замыг бүсийн түвшний сургагч багш нарт танилцуулж, орон нутгийн багш, удирдах ажилтантай хамтран хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих мэдлэг, чадварыг эзэмшүүлэх зорилгоор дүүргийн Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарын дунд “Сургуулийн өмнөх боловсролын үндэсний сургалтын хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх сургалт”-ыг зохион байгуулж, 400 гаруй багшийг хамруулсан. Дүүрэг, Нийслэл, Боловсролын ерөнхий газраас зохион байгуулсан СӨББ-ын багш, удирдах ажилтны цахим болон танхимын 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1311 багш, 340 удирдах ажилтан хамрагдсан. Боловсролын ерөнхий газраас зохион байгуулсан Ерөнхий боловсролын сургуулийн анги танхим, лабораторийн цахим MLab-ийн сургалтад төрийн өмчийн 20, төрийн бус өмчийн 3 сургуулийн нийт 31 менежер хамрагдсан. Англи хэлний Pearson хөтөлбөр хэрэгжүүлэх сургагч багш бэлтгэх сургалтад 4 багш, Eduten цахим системийн суурь боловсрол олгох сургалтад 17 математикийн багш, 17 менежер тус тус хамрагдсан. Мөн Mozaik цахим системийн сургалтыг ахлах ангийн сургалтын менежерүүдийг онлайнаар, захирлуудыг танхимаар хамруулсан. | 100% | НХХ | БХ | 100% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 33 | 2.1.4.2 СӨББ, Ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг мэдлэг ур чадварыг сайжруулахад чиглэсэн олон төрөлт сургалтуудад хамруулна. | 2025-2028 | 65.0 | Дүүргийн төсөв | Зохион байгуулсан арга хэмжээ | Тоо | 4 | 5 | 10.0 | | БНСУ-ын" Бага насны хүүхдийн сургалт судалгааны хүрээлэн", "Уран" боловсрол хөгжлийн холбоо, СӨББ-ын удирдах ажилтнуудтай хамтран бага насны хүүхдийн боловсролын үзэсгэлэнг дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суралцагч хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтэд 2 өдөр танилцуулан сурталчилж ажилласан. Нийслэлийн Боловсролын газраас зохион байгуулсан үнэлгээ болон багшийн хөгжил хариуцсан менежерүүдийн чадавхжуулах сургалтад дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн 54 менежерийг, Монгол Улсын Багшийн Их сургуулиас зохион байгуулсан Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан менежерүүдийн сургалтад 21 менежерийг, ЕБС-ийн зорилтот үндсэн сургалтад 149 багш, 13 удирдах ажилтныг, Тусгаар тогтнолын ордонд зохион байгуулсан “Шинэ цагийн багш” сургалтад дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн нийт 750 багшийг тус тус хамруулсан. | 100% | НХХ | БХ | 100% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 340.00 | 68.00 | | | | | |
| **2.2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт шаардлагатай засвар үйлчилгээг хийж, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэн сургалтын таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | | |
| 2.2.1 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарыг зөөврийн компьютероор бүрэн хангаж, цахим хичээл, алсын зайн сургалт явуулах нөхцөл боломжийг нэмэгдүүлнэ. | 34 | 2.2.1.1 Сургууль, цэцэрлэгийн багш нарыг зөөврийн компьютероор бүрэн хангаж ашиглалтыг нэмэгдүүлнэ. | 2025-2028 | 1,080.0 | Нийслэл, Дүүргийн төсөв | Компьютер олгосон багш | Тоо | 1050 | 50 | - | - | Сургууль, цэцэрлэгийн багш нарыг зөөврийн компьютероор бүрэн хангаж, ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийг ухаалаг самбараар хангах зорилт тавьж, шаардагдах төсвийг 2026 оны дүүргийн төсөвт тусгуулахаар судалгаанд нэгтгэсэн. | 30% | НХХ | БХ | 0% |
| 2.2.2 Ерөнхий боловсролын сургуулиудад орчин үеийн стандартын шаардлага хангасан “Усан бассейн бүхий спорт сургалтын цогцолбор”-ыг үе шаттайгаар байгуулна. | 35 | 2.2.2.1 Хичээлийн жилд 1-2 сургуулийг стандартын дагуу усан бассейн бүхий спорт сургалтын цогцолбортой болгоно. | 2025-2028 | 58,000.0 | Улс, нийслэлийн төсөв | Усан бассейн бүхий спорт цогцолбор | Тоо | 0 | 2 | 22,200.00 | - | Нийслэлийн хөрөнгө оруулалтаар дараах сургуулиудад усан бассейн бүхий спорт заалны шинэчлэл, барилгын ажил хийгдэж байна.<br>Үүнд:<br>- 23 дугаар сургуулийн спорт заалыг буулгаж, усан бассейн бүхий шинэ спорт заал баригдаж байгаа бөгөөд гүйцэтгэл 96%,<br>- 37 дугаар сургуулийн усан бассейн бүхий спорт заалны барилгын ажлын гүйцэтгэл 70%<br>- 39 дүгээр сургуулийн хос биеийн тамирын заал, усан бассейн бүхий спорт заалны барилгын ажлын гүйцэтгэл 20%-тай байна. | 70% | НХХ | БХ | 70% |
| 2.2.3 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд шаардлагатай засвар үйлчилгээ, тохижилтыг хийж, сургалтын таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ. | 36 | 2.2.3.1 Засвар үйлчилгээ хийх шаардлагатай цэцэрлэг, сургуулийн асуудлыг эрэмбэлж, шийдвэрлэнэ. | 2025-2028 | 10,100.0 | Нийслэлийн төсөв, Дүүргийн төсөв | Засвар үйлчилгээ хийсэн байгууллага | Тоо | СӨББ-38<br>ЕБС-19 | 16 | 4,500 | 4,500 | 2025 оны дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар боловсролын салбарын 26 их засварын зураг төслийг 387,600 сая төгрөгт хийж гүйцэтгүүлсэн. Мөн 19 их засварын ажлуудаас 5 ажлыг бүрэн дуусгаж, 14 ажил 50-70 хувийн гүйцэтгэлтэй явж байгаа бөгөөд үлдэгдэл санхүүжилтийг 2026 оны төсөвт тусгуулан тухайн ажлуудыг дуусгахаар ажиллаж байна.<br>Хэрэгжиж дууссан:<br>- 56 дугаар цэцэрлэгийн дээвэр, фасадны засварын ажил<br>- 173 дугаар цэцэрлэгийн дээвэр, фасад засварын ажил<br>- 17 дугаар сургуулийн спорт заалны засварын ажил<br>- 23 дугаар сургуулийн халаалт, цэвэр бохир усны шугам сүлжээний засварын ажил<br>- 140 дүгээр сургууль, 222 дугаар цэцэрлэгийн цогцолбор барилгын гадна болон дотор сан - бохирын хоолойн засварын ажил (23 дугаар хороо)<br>Хэрэгжиж байгаа:<br>- 49 дүгээр сургуулийн сантехникийн их засварын ажил (50%)<br>- 70 дугаар цэцэрлэгийн цахилгааны монтаж, бохирын шугамын засварын ажил (85%)<br>- 72 дугаар сургуулийн А байрны сантехникийн их засварын ажил (60%)<br>- 117 дугаар сургуулийн дээвэр, сантехникийн их засварын ажил (70%)<br>- 154 дүгээр цэцэрлэгийн сантехник, цахилгааны их засварын ажил (70%)<br>- 258 дугаар цэцэрлэгийн фасад, дулаалгын ажил (90%)<br>- 103 дугаар цэцэрлэгийн сантехник, бохирын шугамын засварын ажил (50%)<br>- 126 дугаар цэцэрлэгийн дээвэр, фасад, дулааны шугамын засварын ажил (50%)<br>2026 онд хэрэгжих:<br>- 5 дугаар сургуулийн гадна дулааны шугамын засварын ажил<br>- 24-р сургуулийн сантехник, цахилгааны их засварын ажил<br>- 139 дүгээр бага сургууль, 221 дүгээр цэцэрлэгийн цогцолборын суурь, тулц ханын засварын ажил<br>- 174 дүгээр цэцэрлэгийн дээвэр, фасад, шугам хоолойн засварын ажил<br>- 39 дүгээр сургуулийн хичээлийн А байрны дээврийн болон сантехник, барилгын дотор их засварын ажил | 100% | НХХ | БХ | 80% |
| 2.2.4 Сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, судлагдахууны жишиг төрөлжсөн кабинет байгуулах ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ. | 37 | 2.2.4.1 Дүүрэг, нийслэлд жишиг болохуйц судлагдахуунаар төрөлжсөн кабинетийг хичээлийн жилд хоёроос доошгүйг байгуулж, ашиглалтыг нэмэгдүүлнэ. | 2025-2028 | 600.0 | Дүүргийн төсөв | Байгуулсан кабинет | Тоо | 571 | 2 | 150.0 | - | Чингэлтэй дүүргийн ИТХ-аас санаачлан зохион байгуулсан боловсролын салбарын удирдах ажилтнуудтай уулзах "Өглөөний уулзалт" хэлэлцүүлгийн үеэр дүүргийн ИТХ-ын даргын өгсөн үүрэг чиглэлийн дагуу дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд шаардлагатай ухаалаг самбар, дэлгэц, тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг судалж, холбогдох зардлыг дүүргийн 2026 оны төсөвт тусгасан. Дүүрэг, нийслэлд жишиг болохуйц судлагдахууны төрөлжсөн кабинетийг шинээр байгуулах ажлыг 2025-2026 оны хичээлийн жилд хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна. | 70% | НХХ | БХ | 30% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 18,650.00 | 4,500.00 | | | | | |
| **2.3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, төрийн байгууллага, эцэг эх, олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | | |
| 2.3.1 Хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, хоол үйлдвэрлэлийг бие даан гүйцэтгэх сургуулийн тоог нэмэгдүүлнэ. | 38 | 2.3.1.1 Хоол үйлдвэрлэлийн тоног, төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, хоол үйлдвэрлэлийг бие даан гүйцэтгэх сургуулийн тоог нэмэгдүүлнэ. | 2025-2028 | 660.0 | Улс, нийслэлийн төсөв | Бие даан хоол үйлдвэрлэдэг сургууль | Тоо | 12 | 3 | 200.0 | | Хоол үйлдвэрлэлийн тоног, төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, хоол үйлдвэрлэлийг бие даан гүйцэтгэх сургуулийн тоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын 13 сургуулийг бие даан халуун хоолоор үйлчлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн бөгөөд Ерөнхий боловсролын 50 дугаар сургууль "Койка"-ийн төслийн санхүүжилтээр шинээр гал тогоо суурилуулсан. Ерөнхий боловсролын 17, 37, 39, 117 дугаар сургуулиуд түрээсийн хоолны газраар дамжуулан үйлчилгээ үзүүлж байна. | 100% | НХХ | БХ | 90% |
| 2.3.2 Хоол үйлдвэрлэлд төрийн байгууллага, эцэг эх, олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлнэ. | 39 | 2.3.2.1 Цэцэрлэгийн хүүхдийн хоолны менежментийг сайжруулж, хүүхэд бүрийг эрүүл хүнсээр хангах эцэг, эх, асран хамгаалагчдын оролцоотой хяналтын системийг бий болгоно. | 2025-2028 | 170.0 | Улс, нийслэлийн төсөв | Цахим системтэй цэцэрлэгийн ашиглалт | Хувь | 38 | 100 | 40.0 | | Цэцэрлэгийн хүүхдийн хоолны менежментийг сайжруулж, хүүхэд бүрийг эрүүл хүнсээр хангах эцэг, эх, асран хамгаалагчдын оролцоотой хяналтын системийг бий болгох ажлыг Боловсролын Ерөнхий газраас улс орон даяар нэвтрүүлэн хэрэгжүүлж байна. Дүүргийн сургуулийн өмнөх боловсролын 38 байгууллага LMS-системээр дамжуулан эцэг эхчүүдийн төлөх хоолны мөнгө, хоолны меню, илчлэгийн мэдээллийг харах боломжийг 100 хувь бүрдүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолын 3-т заасны дагуу эцэг эх, асран хамгаалагчаас хоногт 1000 төгрөг, нэг хүүхдэд ноогдох түүхий эдийн зардлыг 3000 төгрөгөөр тооцож, улсаас зардлыг хариуцсанаар эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хоногт авч байгаа хүүхдийн илчлэг, шим тэжээлийн үзүүлэлтэд тавих хяналтын систем сайжирсан. | 100% | НХХ | БХ | 100% |
| | 40 | 2.3.2.2 Сургуулийн үдийн хоолны менежментийг сайжруулж, хүүхэд бүрийг эрүүл хүнсээр хангах эцэг, эх, асран хамгаалагчдын оролцоотой хяналтын зөвлөлийн ажлыг сайжруулна. | 2025-2028 | 50.0 | Улс, нийслэлийн төсөв | Хэрэглэгчдийн сэтгэл ханамж | Хувь | 50 | 60 | 10.0 | | Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 2500 төгрөгөөр, 1-12 дугаар ангид суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 3400 төгрөгөөр тооцох болсонтой холбогдуулан дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын Хоол зүйч нартай хамтран нэгдсэн нэг цэс боловсруулж, дүүргийн хэмжээний бүх сургуулиуд нэгдсэн нэг цэсээр хүүхдийн хоолыг үйлдвэрлэж, сурагчдад олгож байна. Нэгдсэн нэг цэсээр хоол үйлдвэрлэлийн үйлчилгээг үзүүлснээр түрээсийн гал тогоотой сургуулиудын хоолны чанар сайжирсан. | 100% | НХХ | БХ | 100% |
| 2.3.3 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүн нэмэлтээр олгож, хүүхдийн ясны бүтэц, өсөлт хөгжлийг дэмжих "Сүү" хөтөлбөрийг хамтын санхүүжилтээр хэрэгжүүлнэ. | 41 | 2.3.3.1 Ерөнхий боловсролын сургуульд "Сүү" зорилтот төслийг 6-р ангийн суралцагчдад хэрэгжүүлж хүүхдийн ясны бүтэц, өсөлт хөгжлийг дэмжинэ. | 2025-2028 | 1,486.0 | Дүүргийн төсөв | Хамрагдах сургууль | Тоо | 2 | 38 | 136.0 | | Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/559 дугаар захирамжийн дагуу нийслэлийн төсвийн зардлаар Ерөнхий боловсролын 17, 57 дугаар сургуулийн 6-12 дугаар ангийн 1766 сурагч "Сүү" төсөлд хамрагдан сүү ууж байна. Дүүргийн Ерөнхий боловсролын 17 дугаар сургууль 2025 оны 9 дүгээр сараас эхлэн “Сүү хөтөлбөр”-ийн хүрээнд “Сүү” ХК-тай гэрээ байгуулан бага, дунд ангийн нийт 1374 хүүхдэд 7 хоногт 2 өдөр сүү олгож байна. Нэг өдрийн сүүний зардлыг эцэг эх, асран хамгаалагчаар төлүүлж, эцэг эхийн оролцоог хангах тал дээр анхааран ажиллаж байна. Дүүргийн Ерөнхий боловсролын 57 дугаар сургуулийн 1-9 дүгээр ангийн нийт 1136 хүүхдийг "Сүү хөтөлбөр"-т хамруулж, долоо хоногт 3 удаа сүү олгож, хүүхдийн ясны бүтэц, өсөлт хөгжлийг дэмжих чиглэлд анхааран ажиллаж байна. | 100% | НХХ | БХ | 100% |
| | | | | | Дүүргийн төсөв | Хамрагдах сурагч | Тоо | 2907 | 2725 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 386.0 | | | | | | |
| **ЭРҮҮЛ МЭНД** | | | | | | | | | | | | | | | | |
| **2.4. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадлыг хэвшүүлэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулна.** | | | | | | | | | | | | | | | | |
| 2.4.1 Дүүрэгт Нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулна. | 42 | 2.4.1.1 "Нийгмийн эрүүл мэндийн төв" байгуулна. | 2025-2028 | 6,000.0 | Улс, нийслэл, дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 0 | 10 | 1,000.00 | 600.00 | Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн хүрээнд Нийгмийн эрүүл мэндийн төвийг дүүрэгт байгуулах хэрэгцээ шаардлага байгаа бөгөөд дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийг 13 дугаар хороонд баригдаж буй Хайлааст салбар амбулаторид байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Хайлааст салбар амбулаторийн барилгын ажлын явц 75%-ийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 2026 оны 02 дугаар улиралд багтаан ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. | 100% | НХХ | ЧДЗДТГ, НЭМГ | 70% |
| | 43 | 2.4.1.1 "Нийгмийн эрүүл мэндийн төв"-ийн ажиллагааг тогтмолжуулна. | 2025-2028 | 120.0 | Улс, нийслэл, дүүргийн төсөв | ЭМ-ийн статистик үзүүлэлт | Хувь | 75 | 80 | 30.00 | - | Эрүүл мэндийн яам болон Нийслэлийн Эрүүл мэндийн газраас Чингэлтэй дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах тухай эрх зүйн баримт бичиг гарсан тохиолдолд Чингэлтэй нэгдсэн эмнэлгийн зүгээс Нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтэц, орон тоо, хүний нөөц, тоног төхөөрөмжийн судалгааг боловсруулан бэлтгэж, бэлтгэл ажлыг ханган ажиллах төлөвлөгөөтэй байна. | 50% | НХХ | ЧДЗДТГ, НЭМГ | 30% |
| 2.4.2 "Эрт илрүүлэг оношилгооны төв"-ийн барилгыг ашиглалтад оруулж, эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлгийн ажлыг тасралтгүй зохион байгуулна. | 44 | 2.4.2.1 Эрт илрүүлэг, оношилгооны төв байгуулна. | 2025-2028 | 4,000.0 | Улс, нийслэлийн төсөв | Эрт илрүүлэг оношилгооны төв | Тоо | 0 | 1 | 4,000.00 | 4,000.00 | Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй "Эрт илрүүлэг оношилгооны төв"-ийн барилгыг "Монхауз" ХХК, цахилгаан, дулаан, цэвэр бохир усны инженерийн дэд бүтцийг "Эс энд Эй трейд" ХХК гүйцэтгэсэн Улсын комисс хүлээж авсан. Одоогоор уг төв рүү орох, гарах автомашины талбайн хаалгыг суурилуулах ажил хийгдэж байна. Тоног төхөөрөмж, эд хогшлыг зөөх суурилуулах ажлуудыг гүйцэтгэхээр бэлтгэл ажлуудыг ханган ажиллаж байна. | 100% | НХХ | ЧДЗДТГ, НЭМГ | 90% |
| | 45 | 2.4.2.2 Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэн үзлэг, шинжилгээг эрчимжүүлнэ. | 2025-2028 | 4.000.0 | Улс, нийслэлийн төсөв | Эрт илрүүлэг үзлэг | Хувь | 39 | 45 | 1,000.00 | 700.00 | Дүүргийн хэмжээнд эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээнд нийт 133,044 хүн хамрагдахаас 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 61916 иргэнийг хамруулж, 46,5%-тай байна. Эрт илрүүлэгт хамрагдсан иргэдийг насны бүтцээр ангилбал: 0-5 насны хамрагдвал зохих 15615 хүүхдүүдээс хамрагдсан 9758 /62,5%/, 6-17 насны үзлэгт хамрагдвал зохих 32304 хүүхдүүдээс хамрагдсан 20631 /63,9%/, 18-30 насны хамрагдвал зохих 21305 иргэдээс хамрагдсан 4618/21,7%, 31-45 насны хамрагдвал зохих 31817 иргэдээс хамрагдсан 9384/29,5%, 45-60 насны хамрагдвал зохих 22558 иргэдээс хамрагдсан 10542/46,7%, 61-ээс дээш насны хамрагдвал зохих 12681 иргэдээс хамрагдсан 6983/55,1% иргэн байна. Чингэлтэй нэгдсэн эмнэлэг "Эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ"-г зохион байгуулж, "Хортой болон хоргүй хавдрын батлагдсан тохиолдол" оношоор "Умайн хүзүүний хавдар- 24", "Ходоодны хавдар- 44", "Элэгний хавдар-91", "Улаан хоолойн хавдар-10", "Хөхний хавдар-16" нийт 185 хортой, хоргүй хавдар илрүүлж, дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад шилжүүлж эмчилгээнд хамруулсан.. Мөн эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоо шинжилгээг эрчимжүүлэх зорилгоор Улсын нэгдүгээр эмнэлэг, Анагаахын шинжлэх ухааны салбар эмнэлэгүүдтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. | 100% | НХХ | ЧДЗДТГ, НЭМГ | 100% |
| 2.4.3 "Эрүүл, спортлог Чингэлтэйчүүд-2028" арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ. | 46 | 2.4.3.1 Эрүүл мэндийн төвийн амбулатори, нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төв болон өрхийн эрүүл мэндийн төвийн стандартын шаардлага хангасан эмнэлгийн зориулалтын барилга, байгууламжийн асуудлыг шийдвэрлэн ажиллана. | 2025-2028 | Төслийн санхүүжилт | Улс, нийслэлийн төсөв | ЭМТ-ийн шинэ эмнэлгийн тоо, ӨЭМТ | Тоо | ЭМТ- 0<br>ӨЭМТ -7 | ЭМТ- 2<br>ӨЭМТ -8 | Төслийн санхүүжилт | 4,000.00 | Дүүргийн 4 дүгээр хорооны цогцолбор байр ашиглалтад орсонтой холбогдуулан 4-5 дугаар хорооны "Энэрэнгүй үйлс" ӨЭМТ шинэ байранд орж, иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж байна. | 100% | НХХ | ЭМЯ, ЧДЗДТГ, НЭМГ | 70% |
| | 47 | 2.4.3.2 Эрүүл мэндийн салбарын барилга байгууламжид шаардлагатай засвар үйлчилгээг хийнэ. | 2025-2028 | 2,000.0 | Улс, нийслэлийн төсөв | Засвар үйлчилгээ хийсэн эмнэлэг | Тоо | 1 | 1 | 1,304.00 | - | Чингэлтэй нэгдсэн эмнэлгийн долоон давхар барилгыг 2026 онд амбулатори болгон засвар хийхээр төлөвлөсөн ба барилгыг амбулаторийн зориулалтаар засварлаж, нэг, хоёрдугаар амбулаторийг нүүлгэн шилжүүлж ажиллуулахаар төлөвлөсөн. Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн зүүн талд байрлах хоёрдугаар амбулаторийн барилгад БЗДХ, халдварт, Сүрьеэ, микробиологийн лаборатори, серологийн лабораторийг шилжүүлэхээр төлөвлөж байна. Эдгээр амбулаторуудын давхрын төлөвлөлтийг гаргасан бөгөөд холбогдох саналыг "Пико инженеринг" ХХК-д хүргүүлж, барилгын ажлын засварын зургийн даалгаврыг хийлгүүлэхээр хүлээгдэж байна. | 70% | НХХ | ЧДЗДТГ, НЭМГ | 50% |
| | 48 | 2.4.3.3 Эрүүл мэндийн салбарт шаардлагатай багаж, тоног, төхөөрөмжийг шинэчлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ. | 2025-2028 | 28.0 | Улс, нийслэлийн төсөв | Тоног төхөөрөмж | Хувь | 30 | 40 | 10.00 | 4.60 | Эрүүл мэндийн салбарт шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд нийт 6 төсөл, арга хэмжээний 4,687,964,942 төгрөгийн төсөвт өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Үүнд:<br>1. ЧДЗДТГ-ын хөрөнгө оруулалтаар нийт 574,761,000 төгрөгийн өртөг бүхий Бөөр шээсний замын дурангийн мэс заслын багаж, тоног төхөөрөмж, Roche Cobas B221 Цусны хийн анализатор, Ургийн гажигийн хэт авиан эхо аппарат нийлүүлэгдсэн.<br>2. НЗДТГ-ын хөрөнгө оруулалтаар нийт 352,250,000 төгрөгийн өртөг бүхий диализ эмчилгээний аппарат 3 ширхэг, диализийн ус цэвэршүүлэгч төхөөрөмж 1, дуслын автомат шахуурга 5, тариурын автомат шахуурга 7, шээсний бүрэн автомат анализатор нийлүүлэгдсэн.<br>3. Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар "Эрт илрүүлэг оношилгооны төв"-ийн үйл ажиллагаанд шаардлагатай 2,384,300,000 төгрөгийн төсөвт өртөг бүхий эмнэлгийн болон мэдээллийн технологийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.<br>4. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 450,000,000 төгрөгийн өртөг бүхий дижитал рентген аппарат, зөөврийн эхо аппарат, шүдний үзлэгийн кресло, хүүхдийн шүдний үзлэгийн кресло, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, зүрхний холтер монитор зэрэг тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.<br>5. Чингэлтэй дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 898,493,000 төгрөгийн төсөвт өртөг бүхий ходоодны уян дуран, өвчтөний хяналтын монитор, дефибриллятор, өвчтөний хяналтын нэгдсэн систем (CMS), унтуулгын аппарат нийлүүлэгдсэн.<br>6. МУЗГ болон Люксембургийн Их Гүнт улсын Засгийн газар хоорондын буцалтгүй тусламжийн гэрээгээр хэрэгжиж буй "Монгол улс дахь зүрх судлал, зүрхний мэс засал ба телемедицин" MOH/007 төслийн хүрээнд нийт 28,160,942 төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. | 100% | НХХ | ЧДЗДТГ, НЭМГ | 100% |
| | 49 | 2.4.3.4 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадлыг хэвшүүлэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулна. | 2025-2028 | 60.0 | Улс, нийслэлийн төсөв | Хамрагдсан хүн | Тоо | 500 | 500 | 15.00 | 13.00 | Дүүргийн харьяа төр, хувийн хэвшлийн 8 СӨББ, 15 ЕБС-иудад "Шүдээ зөв угаах", "Гар угаах, амьсгал, хоол хүнс, усаар дамжих халдварт болон халдварт бус өвчин, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх" чиглэлээр 23 удаагийн үзлэг, зөвлөгөө, сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 15000 гаруй хүнийг хамруулж, 5 төрлийн 5000ш гарын авлага, сурталчилгааны материалыг түгээсэн. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Боловсролын хэлтэс, Чингэлтэй нэгдсэн эмнэлэг хамтран "Шүд угаалтын аварга" шалгаруулах тэмцээнийг дүүргийн хэмжээнд зохион байгуулж ажилласан. Эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд өдөрлөг, үйл ажиллагаа, аянуудыг үе шаттайгаар зохион байгуулж, нийт 22644 иргэнийг хамруулж, 8000ш гарын авлагыг түгээж ажилласан. Үүнд:<br>Аян-13:<br>□ "Харилцан хүндэтгэе" Жендэрийн аян<br>□ Шүдээ зөв угаая-"24/3" шүдний аян<br>□ "Амны хаалтаа зүүцгээе" аян<br>□ "Хорт зуршлаас татгалзъя" аян<br>□ "Эрүүл чийрэг өсвөр үе"- Папилома аян<br>□ "Өсвөр үеийнхнийг ойлгоё, сонсоё" аян<br>□ "Хариуцлагатай сонголт" аян<br>□ "Тамхины үнэнг илчилье" уриатай –"Хүүхдийн төлөө миний сонголт" нөлөөллийн аян<br>□ "Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд чухал" цахим аяны 7 хоног<br>□ "Аюулгүй скүүтер- Аюулгүй хот" аян<br>□ "Эрүүл эрсдэлгүй наадья" аян<br>□ "Ахмадын сар"ын аян<br>□ Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аян<br>Өдөрлөг арга хэмжээ-9:<br>□ 6 настны үзлэг<br>□ Дархлаажуулалтын үйл явцад дэмжлэгт хяналт хийх<br>□ Хариуцлагатай сонголт аянаар 1-24 дүгээр хороодын эрсдэлт бүлгийн эмэгтэйчүүдийн үзлэг<br>□ Хавдрын хяналтын үзлэг<br>□ Эрэгтэйчүүдийн үзлэг<br>□ Гепатиттай тэмцэх дэлхийн өдөр<br>□ Хаалга бүхэнд хүрч, хүүхэд бүрийг хамгаалъя<br>□ Хөхөөр хооллолтыг дэмжих өдөр<br>□ Автомашингүй өдөр<br>Цахим мэдээ мэдээлэл:<br>ПОСТ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ -180 гаруй<br>ВИДЕО: 21 төрлийн ярилцлага видео<br>СТОРИ: Постер тус бүрээр 2-4 цаг тутамд мэдээлэл, сэрэмжлүүлэг зөвлөгөө байршуулж ажилласан. Нэгдсэн эмнэлэг, Төв | 100% | НХХ | ЧДЗДТГ, НЭМГ | 100% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 50 | 2.4.3.5 Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр дотоод, гадаадын урт болон богино хугацааны сургалтад хамруулна. | 2025-2028 | 60.0 | Улс, нийслэлийн төсөв | Гадаад, дотоодын сургалтад хамрагдсан эмч, ажилчид | Тоо | 2 | 8 | 15.00 | 38.70 | Хамтын ажиллагааны хүрээнд олон улсын бусад байгууллагуудтай хамтран эрүүл мэндийн үзлэг, арга хэмжээ зохион байгуулах, нэн шаардлагатай мэргэжлийн чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэнг мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтад хамруулах хүрээнд БНХАУ-ын Шинжень хотод Sonoscape P11 эхо аппаратын аппликешны сургалтад дүрс оношилгооны тасгийн дурангийн 1 эмч, Бүгд Найрамдах Солонгос улсын Гэдэсний өвчин судлалын нийгэмлэгийн залуу дурангийн эмч нарт зориулсан “Go Imkasid дадлага 9 хоногийн сургалтад 1 эмч, Бүгд Найрамдах Хятад ард улсын Өвөр монголын өөртөө засах орны Олон улсын Монгол эмнэлэгт 5 хоногийн сургалтад сэргээн засах, уламжлалт эмчилгээний тасгийн 1 эмч, хавдрын 1 их эмч, 10 хоногийн сургалтад нүдний 1 эмч, 5 хоногийн сургалтад 2 сувилагч, Ухань хотын "Шуудан, харилцаа холбооны судалгааны институт" ХХК /Fiberhome Technolohy Group/-аас зохион байгуулсан Бүс ба Зам санаачилгын түнш орнуудад зориулсан 4G гар утасны холбооны сүлжээний төлөвлөлт ба оновчлол 14 хоногийн семинарт мэдээллийн технологич 1 ажилтан тус тус хамрагдсан. Эмч мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад 8 эмч, сувилагч, 1 эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, нийт 9 ажилтан хамрагдсан ба дээрх сургалтад хамруулах зардалд нийт 38,790,400 төгрөгийг зарцуулсан. | 100% | НХХ | ЧДЗДТГ, НЭМГ | 100% |
| 2.4.4 Хүүхдэд бага наснаас нь эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, нөхөн үржихүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана. | 51 | ЧД-ийн харьяа төр, хувийн хэвшлийн СӨБ, ЕБС-иудтай хамтарч сургалт зохион байгуулна. | 2025-2028 | 60.0 | Улс, нийслэлийн төсөв | Хамрагдсан хүүхэд | Тоо | 200 | 200 | 15.00 | 13.00 | Хүүхдэд бага наснаас нь эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, нөхөн үржихүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр дүүргийн Ерөнхий боловсролын 12 сургуулийн ахлах ангийн сурагчдад “Утаат болон электрон тамхины хор уршиг түүнээс урьдчилан сэргийлэх нь”, “Дэлгэцийн донтолт ба өөрийгөө хянах арга зам” сэдэвт сургалтыг сургууль тус бүр дээр зохион байгуулж, 15 удаагийн сургалтад 1873 хүүхэд, “Утаат болон электрон тамхины хор уршиг”, ”Дэлгэцийн донтолт” сэдвүүдээр сургалт зохион байгуулж, Ерөнхий боловсролын 3640 сурагчийг хамруулж, гарын авлагыг түгээж ажилласан. Мөн “Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх нь”, “Өсвөр үеийн кабинетын танилцуулга, хаяг байршил, цахим хаяг”, Нөхөн үржихүйн эрүүл мэнд, Охидын сарын тэмдэг, Бэлгийн бойжилт, бэлгийн эрүүл ахуй, Жирэмслэлтээс сэргийлэх арга зэрэг сэдвүүдийн хүрээнд эрүүл мэндийн байгууллага, боловсролын байгууллагуудтай хамтран Ерөнхий боловсролын 14 сургуулийн 3500 гаруй сурагчдыг сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд хамруулж, 4200 ш гарын авлага түгээсэн. Дүүргийн харьяа төр, хувийн хэвшлийн СӨБ, ЕБС-иудад “Шүдээ зөв угаах”, “Гар угаах, амьсгал, хоол хүнс, усаар дамжих халдварт болон халдварт бус өвчин, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр 6 удаагийн аян, 8 удаагийн өдөрлөг зохион байгуулж, давхардсан тоогоор 8000 гаруй хүнийг хамруулж, 5 төрлийн 3000 ш гарын авлага, сурталчилгааны материалыг түгээсэн. | 100% | НХХ | ЧДЗДТГ, НЭМГ, 16 ӨЭМТ | 100% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 7,389.0 | 9,369.3 | | | | | |
| **2.5.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, нэр төрөл, үйлчилгээний чанарыг сайжруулна.** | | | | | | | | | | | | | | | | |
| 2.5.1 Олон улсын стандартад нийцсэн дүүргийн Нэгдсэн эмнэлгийн барилгыг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр барьж, ашиглалтад оруулна. | 52 | 2.5.1.1 Дүүргийн 10 дугаар хороонд баригдах олон улсын жишигт нийцсэн дүүргийн Нэгдсэн эмнэлгийн барилгыг ашиглалтанд оруулна. | 2025-2028 | 36 | Төслийн санхүүжилт | Стандартын шаардлага хангасан жишиг эмнэлэг | Хувь | 0 | 10 | 3.60 | 3,100.00 | МУЗГ, АХБ-аас хэрэгжүүлж буй “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслөөр Чингэлтэй дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт олон улсын жишигт нийцсэн дүүргийн нэгдсэн эмнэлэг баригдах бэлтгэл ажил хийгдэж байна. “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4” төслөөр СХД-т баригдсан жишиг эмнэлгийн архитектур зурагт үндэслэж, барилгын зургийн өөрчлөлтийн саналыг төслийн зөвлөх Интермед эмнэлгийн багтай хамтран боловсруулж, ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн газарт хэлэлцүүлж дэмжигдсэн. Уг барилгын архитектур зургийг Барилгын хөгжлийн төвд магадлангаар орж шинжээчдийн дүгнэлт гарсан ба шинжээчдийн гаргасан дүгнэлтэд үндэслэн засаж засварлахтай холбоотой зардлыг шийдвэрлэх нэгдсэн дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна. Эмнэлгийн барилгын дэд бүтцийн сүлжээ цахилгаан, дулаан, бохир усны инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний зургийг "Ричвелл" ХХК боловсруулж батлуулсан. Төслийн зүгээс эмнэлгийн барилгын дулааныг асуудлыг байгаль экологид хоргүй эх үүсвэрээр шийдсэн байх шаардлагын дагуу Нийслэл болон Чингэлтэй дүүргийн түвшинд хэлэлцэж, хийн түлшээр дулааны асуудлыг шийдвэрлэсэн ба эдгээр бэлтгэл ажлууд бүрэн хэрэгжиж дууссаны дараа 2026 онд эмнэлэг барих олон улсын тендер зарлагдах юм. | 100% | НХХ | ЭМЯ, ЧДЗДТГ, НЭМГ | 50% |
| 2.5.2 Хайлааст салбарын Амбулаторийн барилгыг ашиглалтад бүрэн оруулж, үйл ажиллагааг тогтмолжуулна. | 53 | 2.5.2.1 Хайлааст салбар амбулаторийн барилгыг ашиглалтанд оруулна. | 2025-2028 | 6,500.0 | Улсын төсөв | Барилгын ажлын хэрэгжилт | Хувь | 50 | - | - | - | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 13 дугаар хороонд Дүүргийн эрүүл мэндийн төвийн амбулаторийн барилгын өргөтгөл /Хайлааст салбар/ барилгын ажлыг Мандал голомт ХХКгүйцэтгэж байна. 2026 оны хагас жилээр комисс хүлээлгэж өгөхөөр төлөвлөн ажиллаж байна. | 70% | НХХ | ЭМЯ, НЭМГ | 70% |
| 2.5.3 Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр дотоод, гадаадын урт болон богино хугацааны сургалтад хамруулах, туршлага судлуулах ажлыг зохион байгуулж, сайн туршлагыг нутагшуулна. | 54 | 2.5.3.1 Гадаад хамтын ажиллагааны хүрээнд эмнэлэгийн туршлага судлах болон эмч, сувилагч нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулна. | 2025-2028 | 36.0 | Улс, нийслэл, дүүргийн төсөв | Үйл ажиллагаа | Тоо | 0 | 8 | 12.00 | 11.00 | Дүүргийн Нэгдсэн эмнэлгийн Эх барих эмэгтэйчүүдийн 2 эмч 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдрийн хооронд БНХАУ-ын Шенжень хотод Эмнэлгийн тоног төхөөрөмж үйлдвэрлэлийн Sonoscape компани төв оффисед Sonoscape P11 эхо аппаратны аппликешны сургалтад, Дүрс оношилгооны тасгийн дурангийн 1 эмч Бүгд Найрамдах Солонгос улсын Гэдэсний өвчин судлалын нийгэмлэгийн залуу дурангийн эмч нарт зориулсан “Go Imkasid дадлага сургалтад 9 хоног, Сэргээн засах, уламжлалт эмчилгээний тасгийн 1 эмч Бүгд Найрамдах Хятад ард улсын Өвөр монголын өөртөө засах орны Олон улсын Монгол эмнэлэгт сургалтад 5 хоног, Хавдрын 1 их эмч, нүдний 1 эмч Бүгд Найрамдах Хятад ард улсын Өвөр Монголын өөртөө засах орны Олон улсын Монгол эмнэлэгт сургалтад ажлын 10 хоног, Мэдээллийн технологи, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны мэдээллийн технологич Ухань хотын "Шуудан, Харилцаа Холбооны Судалгааны институт" ХХК /Fiberhome Technolohy Group/-аас зохион байгуулсан Бүс ба Зам санаачлагын түнш орнуудад зориулсан 4G гар утасны холбооны сүлжээний төлөвлөлт ба оновчлол семинарт ажлын 14 хоног богино хугацааны сургалтад тус тус хамрагдсан. | 100% | НХХ | ЧДЭМТ | 30% |
| 2.5.4 “Эрүүл шүд” арга хэмжээг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж, шүд, амны хөндийн өвчлөлийг бууруулна. | 55 | 2.5.4.1 ЕБС, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд амны хөндийн өвчлөлийг бууруулах урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулна. | 2025-2028 | 320.0 | Улс, нийслэл, дүүргийн төсөв | Амны хөндийн өвчлөлийн статистик үзүүлэлт | тоо | 95 | 91 | 80.00 | 70.00 | Дүүргийн ЕБС-ийн нэгдүгээр ангийн 2392 сурагч шүд, амны хөндийн төлөвлөгөөт үзлэгт 100% хамрагдсан ба дунджаар нэг хүүхдийн 3-4 шүдийг эмчилж эрүүлжүүлсэн. Шүдний эмчилгээг хувийн хэвшлийн 8 эмнэлэг, Нэгдсэн эмнэлгийн шүдний кабинетаар зохион байгуулж, ховилын хамгаалалтын ломбыг 835 (43,8%) хүүхдийн 1516 шүдэнд, эмчилгээний ломбо эмчилгээг 577(44%), хүүхдийн 1864 шүдэнд хийж, эрүүлжилт 87,8%-тай байна. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны А/119 дүгээр тушаалын дагуу 8 цэцэрлэг, 12 ЕБС-ийг түшиглэн шүдний үзлэг эмчилгээг зохион байгуулсан ба дүүргийн 19, 39, 277, 280, 102, 43, 224, 293 дугаар цэцэрлэгийн нийт 72 бүлгийн 1928 хүүхэд үзлэгт хамрагдахаас 1206 хүүхэд (62,5%) хамрагдаж, 155 хүүхэд буюу (12,8%) эрүүл, 1050 (87%) хүүхдийн шүд цооролтой, цооролтой шүдний тоо 6473, цоорлын эрчим 6,5, эмчилсэн шүдний тоо 1121(17,3%) байна. Мөн Ерөнхий боловсролын 50, 57, 61, 37, 49, 117, 5, 23, 24, 72, 17, 39 дугаар сургуулийн 6 дугаар ангийн 61 бүлгийн нийт 2399 сурагч үзлэгт хамрагдахаас хамрагдсан 2188 (91.2%), 514 хүүхэд буюу (23.4%) эрүүл, 1718(78,5%) хүүхдийн шүд цооролтой, нийт цооролтой шүдний тоо 5183 цоорлын тархалт 77%, эрчим 4,1; эмчилсэн шүдний тоо 2763 (53.3%) байна. БНСУ-ын Грийн эмнэлэгтэй хамтран дүүргийн эмзэг бүлгийн 1417 хүүхдэд шүдний үзлэг хийж, 809 (57%) хүүхдийн шүдэнд фтор түрхэж, 306 (21,5%) хүүхдэд шүдний ломбо эмчилгээ хийсэн. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Боловсролын хэлтэс, Чингэлтэй нэгдсэн эмнэлэгтэй хамтран “Шүд угаалтын аварга” шалгаруулах тэмцээнийг дүүргийн хэмжээнд зохион байгуулж ажилласан. | 100% | НХХ | ЭМЯ, НЭМГ, ЧДЗДТГ, ӨЭМТ | 100% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5.5 Ахмад настны эрүүл мэндийг дэмжиж, дүүргийн Нэгдсэн эмнэлэгт “Сэргээн засалт, уламжлалт эмчилгээний төв”, “Ахмадын тасаг”-ийг байгуулна. | 56 | 2.5.5.1 Сэргээн засах, уламжлалт эмчилгээний тасаг байгуулна. | 2025-2028 | 35.0 | Улс, нийслэл, дүүргийн төсөв | Сэргээн засах тасаг, Уламжлалт эмчилгээний тасаг | Тоо | 0 | 1 | 18.00 | - | Чингэлтэй Нэгдсэн эмнэлгийн Сэргээн засах, уламжлалт эмчилгээний тасаг нь 7 ортойгоор хэвтүүлэн эмчлэх үйлчилгээг үзүүлж байгаа ба нэг болон гуравдугаар амбулаторийн сэргээх засах уламжлалт эмчилгээний кабинетад өдрийн эмчилгээг үзүүлж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар 389 хүн хүн хэвтэн эмчлүүлж, орны фонд ашилалт 162,5, дундаж ор хоног 6.7 байна. Амбулаториор давхардсан тоогоор 416844 хүнд сэргээн засах, 3212 хүнд уламжлалт анагаах ухааны эмчилгээг тус тус хүргэсэн.Ахмад настанд зориулсан Сэргээн засах, уламжлалт эмчилгээний тасаг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 10 ортойгоор үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд давхардсан тоогоор 2831 үйлчлүүлэгч үйлчилгээ авсан. Сэргээн засах эмчилгээний кабинетаар 1163, уламжлалт эмчилгээний кабинетаар 1684 ахмад настан үйлчлүүлж, тусламж үйлчилгээнд хамрагдсан байна. | 100% | НХХ | 16 ӨЭМТ АШУҮИС-ийн НАСС | 100% |
| 2.5.6 Эрүүл мэндийн салбарын барилга байгууламжид шаардлагатай засвар үйлчилгээг хийж, багаж, тоног, төхөөрөмжийг шинэчлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлэн, үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулна. | 57 | 2.5.6.1 Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгыг ашиглалтад хүлээн авна. | 2025-2028 | #VALUE! | Улсын төсөв | Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга | Хувь | 55 | 100 | 8,960.20 | - | Чингэлтэй Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгыг "Солармед Монгол" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд барилгын ажлын гүйцэтгэл 70 хувьтай. Одоогоор "Дөлгөөн нуур" болон "Чингисийн музей"-ээс цахилгааны кабель, дэд өртөө татах, гадна тохижилтын ажлууд хүлээгдэж байна. | 100% | НХХ | ЭМЯ, ЧДЗДТГ, НЭМГ | 70% |
| | 58 | 2.5.6.2 Нэгдсэн эмнэлгийн 7 давхар эмнэлгийн барилгад их засвар хийнэ. | 2025-2028 | 1,305.0 | Улсын төсөв | Их засварын ажлын явц | Хувь | 0 | - | - | - | Дүүргийн Нэгдсэн эмнэлгийн долоон давхар барилгын засварын ажлыг Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга ашиглалтанд орж хэвтэн эмчлүүлэх хэсэг нүүж орсны дараа хийхээр төлөвлөж байна. Долоон давхар барилгад Сангийн яамны дэргэд байрлах нэгдүгээр амбулатори, 5 дугаар сургуулийн дэргэд байрлах хоёрдугаар амбулаториос гэмтэл, мэс заслын хагалгааны хэсэг, хэвтэн эмчлүүлэх тасаг нь нэгдсэн эмнэлгийн өргөтгөлд нүүн орж, амбулатори нь долоон давхар барилгад нүүж оруулахаар төлөвлөсөн. Одоогоор "Пико инженеринг" ХХК нь 7 давхар барилгыг амбулатори болгох чиглэлээр давхруудын төлөвлөлтийг хийж, төлөвлөлтөд үндэслэж засварын ажлын даалгаварыг боловсруулахаар ажиллаж байна. | 70% | НХХ | ЭМЯ, НЭМГ, ЧДЗДТГ | 30% |
| | 59 | 2.5.6.3 Нэгдсэн эмнэлгээр үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ. | 2025-2028 | 80.0 | Дүүргийн төсөв | Сэтгэл ханамжийн судалгааны үзүүлэлт | Хувь | 75 | 85 | 20.00 | - | Чингэлтэй нэгдсэн эмнэлэг болон өрхийн Эрүүл мэндийн төвүүдэд ирсэн өргөдөл, гомдолд санал 2.36 хувь, хүсэлт 2.36 хувь, талархал 26.77 хувь, гомдол 68.5 хувийг эзэлж байна. Ирсэн 127 өргөдөл гомдлын 125 нь 11-11 төвд, 2 нь 1800-1200 дугаарт ирсэн байна. Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг хандалтаар авч үзвэл 2 дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний тухай 49 буюу 38.59%, Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай 33 буюу 25.99%, Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны тухай 30 буюу 23.63%, Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчийн ёс зүйн тухай 6 буюу 4.73%, Яаралтай тусламж, үйлчилгээний тухай 3 буюу 2.36%-тай байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 19 цаг, дундаж хувь 99% байна. Өргөдөл гомдлын 68,29 хувийг 5 хоногт, 17,89 хувийг 10 хоногт, 4.88 хувийг 15 хоногт, 9,6 хувийг 30 хоногт, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй. Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг судлан байгууллагын удирдлага, холбогдох тасаг нэгж, албан тушаалтанд танилцуулан шийдвэрлэж, хариуг бичгээр, амаар болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэнд эргэн мэдээлэл өгөн ажиллаж байна. Ажилтан, албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой гомдлыг судла,н холбогдох эмч ажилтанд анхааруулж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байна. | 50% | НХХ | ЧДЗДТГ | 50% |
| 2.5.7 Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна. | 60 | 2.5.7.1 Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр шаардлагатай тоног төхөөрөмжийг шинэчилнэ. | 2025-2028 | 1,200.0 | Улс, нийслэл, орон нутгийн төсөв | Тоног төхөөрөмж суурилуулах ажлын хэрэгжилт | Хувь | 40 | 60 | 300.00 | 120.00 | Дүүргийн төсвийн хөрөнгөөр /130 сая/ жирэмсний гажгийн эхо аппаратыг дүүргийн Чингэлтэй Нэгдсэн эмнэлэгт 2025 оны 05 дугаар сард хүлээлгэн өгсөн ба 112,761,000 төгрөгийн өртөг бүхий хиймэл оюун ухаанд суурилсан Vinno R300 загварын ургийн гажигийн хэт авиан багаж, тоног төхөөрөмжийг жирэмсний тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн. Ингэснээр AI технологид суурилсан тооцооллын тусламжайгаар эмчийн нэг үйлчлүүлэгчид зарцуулах хугацаа 12%-аар буурсан эерэг үзүүлэлттэй байна. | 100% | НХХ | ЭМЯ, НЭМГ, ЧДЗДТГ | 100% |
| | 61 | 2.5.7.2 Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чанар хүрээмжийг нэмэгдүүлэх, эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах сургалт, аян зохион байгуулна. | 2025-2028 | 170.0 | Улс, нийслэл, орон нутгийн төсөв | Сургалтад хамрагдсан хүн | Тоо | 165 | 6,000 | 40.00 | - | “Жирэмсний хяналт ба цус багадалт” сэдвээр 40 эмчид сургалт зохион байгуулсан ба Монголын эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын холбооноос зохион байгуулсан “Жирэмсний хяналт, эрсдэл, жирэмсэн үед зонхилон тохиолдох асуудлуудын оношилгоо, эмчилгээ, авах арга хэмжээ” танхимын сургалтад дүүргийн Нэгдсэн эмнэлгийн хяналтын эмч нар, эх барих эмэгтэйчүүдийн 9 эмч, Өрхийн эрүүл мэндийн төвийн 54 эмчийг ажлын байрны сургалтад хамруулсан. "Жирэмсний хяналтын тусламж”-ийн чанарыг сайжруулах, Өрхийн болон жирэмсний хяналтын эмч, дотрын эмч нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, стандарт, удирдамж, жишгийг мөрдүүлэх зорилгоор “Эх барихын шалтгаант үжил халдвар оношлогоо эмчилгээ” сэдэвт сургалтыг АШУҮИС-Эх барихын тэнхимтэй хамтран зохион байгуулж, эх барих эмэгтэйчүүдийн эмч нар, Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, дотрын эмч, бусад нарийн мэргэшлийн 35 эмчийг хамруулсан. Чингэлтэй нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүдийн кабинатаар үйлчлүүлсэн нөхөн үржихүйн насны 1560 эмэгтэйд гэр бүл, төлөвлөлт, жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн талаарх мэдээллийг хүргэж, зөвлөгөө өгсөн. | 100% | НХХ | ЭМЯ, НЭМГ, ЧДЗДТГ, ӨЭМТ-үүд | 100% |
| | Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | 9,433.00 | 3,301.00 | | | | | |
| **БИЕИЙН ТАМИР, СПОРТ** | | | | | | | | | | | | | | | | |
| **2.6.Иргэдийн биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөнөөр хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж, нийтийн биеийн тамираар хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | | |
| 2.6.1 Спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөл боломжийг сайжруулна. | 62 | 2.6.1.1. Иргэд, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийн төв 3 спорт цогцолборыг барьж ашиглалтанд оруулна. | 2025-2028 | 2,628.0 | Дүүргийн төсөв | Барилгын ажлын хэрэгжилт | Хувь | 70 | 100 | 1,605.30 | 1,605.30 | Дүүргийн 14 дүгээр хороонд байрлах "Хайрхан хөгжлийн төв-3” спорт цогцолборын барилгын ажлын гүйцэтгэл бүрэн хэрэгжиж, 2025 оны 10 дугаар сард ашиглалтад орсон ба үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. | 100% | ТГУХ | БТСХ | 100% |
| | 63 | 2.6.1.2. Иргэд, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийн төв 4 спорт цогцолборыг барьж ашиглалтанд оруулна. | 2025-2028 | 3,000.0 | Улсын төсөв | Барилгын ажлын хэрэгжилт | Хувь | 10 | 50 | 1,000.00 | - | Иргэд, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийн төв 4 спорт цогцолборын барилгыг дүүргийн 4 дүгээр хорооны 30а байрны баруун талд байрлах дүүргийн Засаг даргын Тамгын газрын эзэмшлийн 1772 м2 газар дээр бариулахаар 2024/00-729 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар гаргуулан барилгын эх загвар зургийг батлуулсан боловч 30а байрны оршин суугчдаас удаа дараа гомдол ирүүлсний дагуу тус ажил зогсоод байна. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 03/3341 дүгээр албан бичгээр Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт төлөвлөлтийн байршлыг өөрчлүүлэх хүсэлтийг хүргүүлсэн. | 10% | ТГУХ | БТСХ | 30% |
| 2.6.2 Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ баг, 1-24 дүгээр хороодын Спорт хамтлагийн үйл ажиллагааг өргөжүүлэн, бэлтгэл сургуулилтыг тогтмолжуулж, уралдаан тэмцээнд амжилттай оролцох, чансаа ахиулах нөхцөл боломжоор хангаж ажиллана. | 64 | 2.6.2.1 Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн төрлийг нэмэгдүүлэн үйл ажиллагааг өргөжүүлэх, бэлтгэл сургуулилтыг чанаржуулах, уралдаан тэмцээнд оролцох нөхцөл дэмжлэг үзүүлнэ. | 2025-2028 | 1,200.0 | Дүүргийн төсөв | Олон улсын болон улс, нийслэл, дүүргийн чанартай тэмцээн, уралдаанаас хүртсэн медаль | Тоо | 200 | 250 | 300.00 | 145.00 | Дүүргийн Засаг даргын 2025 оны А/65 дугаар захирамжийн хүрээнд жүдо бөх, таеквондо, чөлөөт бөх, хөнгөн атлетик, волейбол, сагсан бөмбөг, усан спорт, хоккей, үндэсний бөх, шатар, спортын гимнастик, ширээний теннис, тэшүүр, хөл бөмбөг, бокс, холимог тулаан, хүндийн өргөлт зэрэг спортын 17 төрлийг хичээллүүлж, Өсвөрийн шигшээ багийн багш дасгалжуулагч нартай “Хамтран ажиллах гэрээ” байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд өсвөрийн шигшээ багийн тамирчид тив дэлхий, олон улс болон улсын чанартай 87 удаагийн тэмцээн уралдаанд оролцож, нийт 522 медаль хүрсэн. Үүнд: Тив дэлхийн тэмцээнээс 1 мөнгөн медаль, 2 хүрэл медаль, Олон улсын тэмцээнээс 16 алтан медаль, 17 мөнгөн медаль, 36 хүрэл медаль, Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 75 алтан медаль, 43 мөнгөн медаль, 65 хүрэл медаль, Нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнээс 32 алтан медаль, 31 мөнгөн медаль, 24 хүрэл медаль Нэрэмжит тэмцээнээс 71 алтан медаль, 51 мөнгөн медаль, 58 хүрэл медаль тус тус хүртсэн амжилтыг үзүүлсэн. | 100% | БТСХ | ЧДЗДТГ | 100% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6.3 Усан спортын боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, багш дасгалжуулагчдыг чадваржуулан, мэргэжлийн баг бүрэлдэхүүн бэлтгэнэ. | 65 | 2.6.3.1 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, биеийн тамирын багш нарын дунд усан спортын онол практикийн сургалт зохион байгуулж, усан сэлэлтийн спортоор хичээллэдэг иргэд, хүүхэд, залуучуудын тоог нэмэгдүүлнэ. | 2025-2028 | 20.0 | Дүүргийн төсөв | Усан сэлэлтийн спортоор хичээллэдэг хүн | Тоо | 100 | 2000 | 5.00 | 67.90 | Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/48 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын усан сэлэлтийн анхан шатны сургалтыг зохион байгуулсан ба сургалтад дүүргийн Ерөнхий боловсролын 19 сургуулийн 1600 сурагчид хамрагдсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар Биеийн тамир, спорт хорооны Усан бассейнаар нийт 2,882 иргэд, хүүхэд, залуучууд үйчлүүлсэн байна. | 100% | НХХ | | 100% |
| | 66 | 2.6.3.2 Багш дасгалжуулагчдыг чадавхжуулж, улс, олон улсын сургалтад хамруулна. | 2025-2028 | 80.0 | Дүүргийн төсөв | Хамрагдсан хүн | Тоо | 0 | 2 | 20.00 | 15.00 | Багш дасгалжуулагчдыг олон улсын сургалтад хамруулж, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Солонгос улсад зохион байгуулагдсан олон улсын сургалтад дүүргийн Биеийн тамир, спортын хорооны арга зүйч С.Нарангэрэл хамрагдсан. Япон улсын Яйзу хотын хамтын ажиллагааны хүрээнд дүүргийн Засаг даргын дэргэдэх "Ширээний теннис"-ний өсвөрийн шигшээ багийн дасгалжуулагч ОУХМ С.Галбадрах, дүүргийн Биеийн тамир, спортын хорооны арга зүйч С.Ууганжаргал болон өсвөрийн шигшээ багийн 12 тамирчдаас бүрдсэн баг бүрэлдэхүүн 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс 08-ны өдрүүдэд хамтарсан бэлтгэл сургуулилт, нөхөрсөг тоглолтод хамрагдсан. | 100% | НХХ | ЗДТГ | 50% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 2,930.00 | 1,833.2 | | | | | |
| **НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ** | | | | | | | | | | | | | | | | |
| **2.7.Орон нутгийн хэмжээнд зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэнэ.** | | | | | | | | | | | | | | | | |
| 2.7.1 Залуучуудын бизнес эрхлэх боломжийг бүрдүүлж, гарааны бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх бодлого баримтлан ажиллана. | 67 | 2.7.1.1 Шилдэг Стартап залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох уралдааныг зохион байгуулж, хамрагдах залуучуудыг үе шаттай модуль сургалтыг зохион байгуулна. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Суралцагчдын тоо | Тоо | 50 | 50 | - | 30.00 | "Шилдэг Стартап" залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагааны хүрээнд залуучуудад сургалт зохион байгуулахаар "Хөгжлийн шийдэл" ТББ-тай гэрээ байгуулан ажилласан. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн дагуу "Шилдэг старт-ап" санхүүгийн дэмжлэг олгох шалгаруулалтад "Старт-ап" бизнесээ эхлүүлж буй 15-34 насны 13 баг оролцсоноос шинэ технологи, инновац бүхий шинэлэг санал, санаачилга гаргасан "Step Up", "Анара" багууд шалгарч, тус бүр 15,000,000 төгрөгийн дэмжлэг авсан. | 100% | НХХ | ЧДХХҮХ | 100% |
| 2.7.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд тэгш оролцох нөхцөл боломжийг нэмэгдүүлж, идэвх санаачилгыг нь дээшлүүлэх чиглэлээр олон улсын болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохио, замын гарц, тэмдэг тэмдэглэгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй, хүртээмжтэй байхаар төлөвлөн хэрэгжүүлнэ. | 68 | 2.7.2.1 ОНОТХҮ-ний нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнийг нийгэмшүүлэх хамт олны бүлэг бүрдүүлэх орлогын эх үүсвэртэй болох төсөл хэрэгжүүлэх амьдрах ухаанд сургана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Суралцагчдын тоо | Тоо | 36 | 30 | - | - | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бараа бүтээгдэхүүнийг үнэ төлбөргүйгээр борлуулах, түрээсийн хөнгөлөлт үзүүлэн ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн 1 дүгээр давхарт "Чингэлтэйд үйлдвэрлэв төв "Нарлаг дэнж" худалдааны төвийн 3 дугаар давхарт "Чингэлтэйд үйлдвэрлэв төв", Алтжин бөмбөгөр худалдааны төвд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах борлуулалтын төвүүдийг ажиллуулж байна. "Чингэлтэйд үйлдвэрлэв" борлуулалтын төвийн 3 салбарт нийт 38,8 сая төгрөгийн борлуулалт хийгдсэнээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн 16,3 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна. | 100% | НХХ | ЧДХХҮХ | 100% |
| | 69 | 2.7.2.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөтөч хавтантай явган зам, налуу зам, шатны хүртээмжийг нэмэгдүүлэх | 2025-2028 | 192.0 | Улс, нийслэл, дүүргийн төсөв | Талбайн хэмжээ | м2 | 46500 | 400м2 | 48.00 | - | Их тойруугийн гудамжны баруун тал буюу Баянбүрдийн тойргоос Гэсэр сүмийн уулзвар хүртэлх 3500м2 явган хүний замыг шинэчлэх ажил, Энхтайвны өргөн чөлөөнд 10,000 м2 явган хүний замын шинэчлэлтийн ажлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөтөч хавтантайгаар хийж гүйцэтгүүлсэн.<br>Мөн дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй иргэдэд үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж байгууллагуудад Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийн хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор тэргэнцэртэй хүн орж гарахад хүндрэлгүй, стандартын шаардлага хангасан зам талбайн орц гарц, хаалга, ариун цэврийн өрөөний стандартуудын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллах талаар 1-24 дүгээр хороодод албан бичиг хүргүүлэн аж ахуйн нэгж байгууллагуудад хугацаатай үүрэг даалгавар хүргүүлсэн. | 100% | ХСТНААХ | НЗХГ | 100% |
| | 70 | 2.7.2.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамруулна. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хамрагдсан иргэд | Тоо | 113 | 113 | - | 180.00 | Дүүргийн хэмжээнд бүртгэлтэй 3307 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагаас хөдөлмөр эрхэлдэг-249, албан бус хөдөлмөр эрхэлдэг-558, ажилд зуучлуулсан 40, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдсан 23 иргэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй 23 иргэнд 180 сая төгрөгийн зээл тусламж олгож, 40 иргэний ажлын байрыг шинээр бий болгосон. Дүүргийн ЗДТГ-аас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах, нийгмийн амьдралд татан оролцуулах хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэнтэй "Хамтран ажиллах гэрээ" байгуулж, дүүргийн 1-24 дүгээр хороодын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хариуцуулан ажиллуулж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр урамшуулал олгон ажиллуулж байна.<br>Нийслэл, дүүргээс зохион байгуулсан 3 удаагийн үзэсгэлэн худалдаанд хөгжлийн бэрхшээлтэй 17 иргэнийг оролцуулж, өөрсдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ сурталчлан борлуулах боломжоор хангаж ажилласан. | 100% | НХХ | ЧДХХҮХ | 100% |
| 2.7.3 "Ахмад настны хөгжлийн төв"-ийг бүсчилсэн хэлбэрээр байгуулж, ахмад настны эрхийг хангах, эрүүл мэндийг хамгаалах, идэвхтэй хөдөлгөөнийг сурталчлах, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх, нийгмийн оролцоо идэвхийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, амьдралын чанарыг дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр "Чингэлтэйн ахмадууд-2028" арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ. | 71 | 2.7.3.1 "Чингэлтэйн ахмадууд-2028" арга хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хөтөлбөрийн хэрэгжилт | Хувь | 100 | 100 | - | 210.00 | "Чингэлтэй ахмадууд-2028" арга хэмжээг 4 зорилтын хүрээнд нийт 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.<br>Зорилт 1-ийн хүрээнд дүүргийн 3 дугаар хороонд "Ахмадын танхим, 5 дугаар хороонд "Чийрэгжүүлэлтийн танхим", 9, 19 дүгээр хороонд "Ахмадын хөгжлийн төв" нээн ажиллуулж байна. Дүүргийн 3, 5, 9, 19 дүгээр хороодын ахмадын хөгжлийн төвийн өдөр тутмын үйл ажиллагааг тухайн хороодын Ахмадын зөвлөлийн дарга хариуцан ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд 3, 5, 19 дүгээр хороодын "Ахмадын хөгжлийн төв"-өөр нийт 2200 гаруй ахмад настан үйлчлүүлсэн байна.<br>Зорилт 2-ын хүрээнд Чингэлтэй нэгдсэн эмнэлэгтэй хамтран Ахмадын урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, нүд, чих, бөөр, дотоод шүүрэл, хавдар зэрэг 13 нэр төрлийн үзлэг, биохими, рентген, ЭХҮ, ЭКГ зэрэг 6 төрлийн оношилгоо, шинжилгээ хийж, хяналтад 214 ахмад настныг хамруулж, 97 ахмадыг төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт лавлагаа шинжилгээнд хамруулахаар илгээсэн. Мөн уламжлалт, европ анагаах ухаан хосолсон "Найрамдал" эмнэлэгтэй хамтран 1-24 дүгээр хорооны ахмадуудыг 6 төрлийн шинжилгээ, үзлэгт үнэ төлбөргүй хамруулахаар төлөвлөж хамтран ажиллаж эхлээд байна. Чингэлтэй Нэгдсэн эмнэлгийн Гуравдугаар амбулаторийн сэргээн засах болон уламжлалт эмчилгээний кабинетыг түшиглэн Ахмад настны эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг явуулж, сэргээн засах эмчилгээний кабинетаар 200 орчим, уламжлалт эмчилгээний кабинетаар давхардсан тоогоор 150 орчим ахмад настан үйлчлүүлж, тусламж үйлчилгээнд хамрагдсан. Чингэлтэй Нэгдсэн эмнэлгийн Нэгдүгээр амбулатори, "IVCO" эмийн компанитай хамтран 2025 оны 10 дугаар сард "Эрүүл, идэвхитэй насжилт" өдөрлөгийг зохион байгуулж, ахмад настнуудыг ясны сийрэгжилт, эрдэс амин дэмийн дутагдал тодорхойлох, глюкозын хэмжээ тодорхойлох шинжилгээнд 102 ахмадыг хамруулсан. Дүүргийн 1-24 дүгээр хороодын өрхийн эмнэлэгүүдэд ахмадын эмч ажиллуулах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгаа ба одоогоор дүүргийн 16 Өрхийн эмнэлэг 100% ахмадын эмчтэй болж, зөвхөн ахмадуудад эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.<br>Зорилт 3-ын хүрээнд Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох ажлын хүрээнд дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран 1-24 дүгээр хороодын ахмадуудад мэдээ, мэдээлэл хүргэж, төсөл бичих аргачлалд сургаснаар сүүлийн 3 жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт 147 ахмад настныг хамруулж, 821.000.000 төгрөгийн санхүүжилт олгосон. 2025 онд төсөлд хамрагдахаар 42 ахмад настан төсөл, хөтөлбөрөө ирүүлснээс 39 ахмад настанг шалгаруулж, 390.000.000 төгрөгийн дэмжлэг олгосон. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд сүүлийн 3 жилд 109 ахмад настан хамрагдаж 117.720.000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан бөгөөд энэ онд 46 ахмад настан Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр саналаа ирүүлснээс 32 ахмад настны төсөл шалгарч, 34.560.000 төгрөгийн санхүүжилт олгосон.<br>Зорилт 4-ын хүрээнд 2025 онд төрсөн үр хүүхэдгүй, бие амьдрах чадваргүй 3 ахмад настныг улсын "Ахмад настны үндэсний төв" асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулж хяналт тавин ажиллаж байна. Дүүргийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/345 дугаар захирамжаар Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх "Орон нутгийн мэргэжлийн хамтарсан баг"-ийг 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Чингэлтэй нэгдсэн эмнэлэг, Ахмадын хороо, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, 1-24 дүгээр хороод, Өрхийн эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан ахмад настнуудын бие бялдар, танин мэдэхүй, сэтгэл зүйг үнэлэн цогц тусламж үйлчилгээг үзүүлэх ажлыг эхлүүлэн хэрэгжүүлэн, нийт ахмадын 10 гаруй хувийг хамруулан ажиллалаа. | 100% | НХХ | АХ | 84% |
| 2.7.4 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хөгжил хамгааллыг сайжруулах чиглэлээр гадаад, дотоодын төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 72 | 2.7.4.1 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлагад нийцсэн ажиллах хүчнийг хөдөлмөр эрхлэлтийн сургалтаар дамжуулан бэлтгэнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хамрагдсан иргэд | Тоо | 50 | 50 | - | 8.00 | Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс Чадамжид суурилсан мэргэжил олгох сургалтад хамрагдах хүсэлтэй 114 иргэнийг бүртгэлжүүлж, холбогдох мэдээллийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлсэн. "Жи Эс Эй Эс" ХХК, "Эм эс девелопмент" сургалтын төвүүдтэй хамтран суурь ур чадвар олгох сургалтад 225 иргэнийг хамруулсан. Мөн "Хөгжлийн шийдэл" ТББ, "Алтан алхам" ТББ, "Жи-Эс-Эй-Эс" ХХК, "Мэргэшсэн мэргэжил" ТББ, "Астра залуус" ХХК-тай хамтран нийт 629 иргэнийг аж ахуй эрхлэлт, бизнес эрхлэх ур чадварын сургалтад хамруулсан. | 100% | НХХ | ЧДХХҮХ | 100% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 48.00 | 428.00 | | | | | |

## СОЁЛ УРЛАГ

**2.8.Иргэд, олон нийтэд үндэсний өв соёлоо сурталчлан таниулах, өвлүүлэн үлдээх, тэднийг соёл урлагаар дамжуулан соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж, иргэдэд хотын соёлыг төлөвшүүлнэ.**

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.8.1 Дүүргийн иргэдийн авьяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, хотын соёлыг бий болгох, соёл урлагийн үйл ажиллагааг идэвхтэй дэмжих, соёлын биет болон биет бус өвийг өргөжүүлэн хөгжүүлэх хүрээнд "Соёлтой иргэн-2028" арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ. | 73 | 2.8.1.1 "Соёлтой иргэн- 2028' арга хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хөтөлбөрийн хэрэгжилт | Хувь | 100 | 100 | - | 510.00 | "Соёлтой иргэн-2028" арга хэмжээний хүрээнд 4 зорилт, 14 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Зорилт 1-ийн хүрээнд нийт 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба дүүргийн иргэдэд соёл, урлагаар үйлчлэх зориулалт бүхий "Соёлын ордон"-ыг байгуулах зураг төсөл хийлгэх зардлыг дүүргийн 2026 оны төсөвт тусгуулахаар төсвийн саналд нэгтгэж ажилласан. Соёлын төвийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, соёл урлагийн үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор дүүргийн 14 дүгээр хороонд шинээр ашиглалтад орсон "Чингэлтэй цогцолбор-3" байранд Соёлын төвийг нүүлгэн шилжүүлж, 200 сая төгрөгийн зардлаар урлаг заалланд акустик доторлогоо хийлгэж, албан хаагчдын өрөө тасалгааг тохижуулж, иргэд, олон нийт ая тухтай үйлчлүүлэх 100% боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Соёл урлагийн үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд зохион байгуулж, иргэд, олон нийтэд соёлын урлагийн үйл ажиллагааг сурталчлан таниулах чиглэлээр 19 үйл ажиллагаа зохион байгуулж, нийт 58 байгууллагын 6500 гаруй иргэнийг хамруулан ажилласан. Зорилт 2-ын хүрээнд нийт 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба дүүргийн Соёлын төвийн дэргэд 9 төрлийн дугуйлан секцийг хичээллүүлж, давхардсан тоогоор 120 гаруй хүүхэд, багачуудыг хамруудсан.. Соёл урлагийн тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээний хүрээнд "Чингэлтэйн Фестиваль 2025", "Монгол нүүдэлчин өвлийн фестиваль-2025", "Дээлтэй монгол наадам-2025", "Иргэдийн баяр-Хүрээ цам дашиг наадам-2025, Тахилга, "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль-2025 зэрэг 7 арга хэмжээг тус тус зохион байгуулж, нийт 15000 гаруй иргэдийг хамруулсан. "Бахархалт Монгол хэл, бичиг" видео бичлэгийн уралдааныг зарлаж, бичлэгийг дүүргийн албан ёсны цахим хуудсанд байршуулсан бөгөөд нийт 13 сургуулийн 4000 гаруй сурагчид хамрагдаж, 20,000 гаруй иргэний хандалт авсан байна. Зорилт 3-ын хүрээнд нийт 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба иргэд, олон нийтийн эрх зөрчигдөж буй соёлгүй зан үйлүүдийн хэвшил, дадал зуршлыг арилгах зорилгоор дүүргийн Соёлын төвийн уран бүтээлчид видео бичлэг, рийл, подкастыг бэлтгэн дүүргийн албан ёсны фэйж хуудас болон 1-24 дүгээр хороодын цахим хуудсаар дамжуулан сурталчилж, 32,698 үзэлт, 1034 лайк хандалт авч ажилласан. Аяны хүрээнд нийслэлийн 9 дүүргийн хэмжээний анхан шатны шалгаруулалтад дүүргийн нэгдсэн тайланг хүргүүлж "Тэргүүн байр"-т шалгарч, нийслэлийн Соёл Урлагийн газрын харьяа байгууллагуудын анхан шатны шалгаруулалтад дүүргийн Соёлын төвийн нэгдсэн тайланг хүргүүлж, "Тэргүүн байр"-т шалгарч, улсын хэмжээний хоёрдугаар шатны шалгаруулалтад тус тус оролцож байна. Зорилт 4-ийн хүрээнд нийт 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба "Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг тохиолдуулан дүүргийн 1-24 дүгээр хорооны ажилтан, албан хаагчдад "Монгол бичгийн анхан шатны сургалт"-ыг 3 удаа зохион байгуулж, 200 гаруй албан хаагчид хамрагдсан. Эх хэл, бичиг үсэг, соёл, өв уламжлал, зан заншил, үнэт зүйлийг хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх, үндэсний монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, таниулан сурталчлах зорилгоор "Бахархалт Монгол бичиг" уралдааныг 4 төрлөөр зохион байгуулж, нийт 13 сургуулийн дунд, ахлах ангийн 10,000 гаруй хүүхэд, багачууд хамрагдсан. "Соёлын орон зай - Бидний орчин" бүтээлч аяны хүрээнд дүүргийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагын гадна болон дотор хаягжилтыг кирилл болон үндэсний бичгийн стандартад нийцүүлж, шинэчлэх уриалгыг гаргаж, нийт 157 байгууллагын гадна болон дотор /500 гаруй/ хаягжилтыг кирилл болон үндэсний бичгийн стандартад нийцүүлж, шинэчлэн тогтоон байршуулсан. "Монгол үндэстэн ястан" сургалтыг үе шаттай зохион байгуулж, 200 гаруй дүүргийн хүүхэд багачууд, "Монгол хантааз урлах" сургалтыг 3 удаагийн давтамжтай зохион байгуулж 80 гаруй хүүхэд багачууд хамрагдсан. | 100% | Соёлын төв | НХХ | 100% |
| | 74 | 2.8.1.2 Дүүргийн иргэдийг "Хотын соёл"-д сургах зөв хандлага, зөв дадлыг төлөвшүүлэх нөлөөллийн ажил, видео контент бэлтгэн иргэдэд хүргэнэ. | 2025-2028 | 80.0 | Дүүргийн төсөв | Нөлөөллийн ажил, контент | Тоо | 0 | 5 | 20.00 | 12.00 | Иргэд, олон нийтийн эрх зөрчигдөж буй соёлгүй зан үйлүүдийн хэвшил, дадал зуршлыг арилгах зорилгоор дүүргийн Соёлын төвийн уран бүтээлчид видео бичлэг, рийл, подкастыг бэлтгэн дүүргийн албан ёсны фэйж хуудас болон 1-24 дүгээр хороодын цахим хуудсаар дамжуулан сурталчилж, 32,698 үзэлт, 1034 лайк хандалт авч ажилласан. "Соёл түгээе" уриан дор орон даяар өрнөж буй "Соёлын орон зай - Бидний орчин" бүтээлч аяны хүрээнд эерэг нийгмийг хамтдаа бүтээх, нийтийн соёлыг иргэдэд сурталчлан таниулах зорилгоор 80 гаруй цахим уриалга, постер, рийл, подкастыг бэлтгэн дүүргийн албан ёсны фэйж хуудас болон 1-24 дүгээр хороодын цахим хуудсаар дамжуулан сурталчилсан ба 5,900 гаруй иргэдийн хандалт, 80,550 иргэдийн үзэлт авсан. Аяны фрэймийг байгууллагын хэмжээнд хэвлүүлж, Засаг даргын Тамгын газрын 50 албан хаагч, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, дүүргийн 1-24 хороодын 80 гаруй албан хаагчид тус фрэймийг ашиглаж, дүүргийн албан ёсны фэйс хуудас болон холбогдох байгууллагын фэйж хуудас болон албан хаагчид хувийн цахим хаягаар дамжуулан аяныг сурталчилж ажилласан. "Нийгмийн салбар"-ын чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааг албан байгууллага, иргэд олон нийтэд танилцуулах зорилгоор "Үйл ажиллагааг сурталчлах самбар"-ыг 20 ширхэгийг хэвлүүлж, дүүргээс зохион байгуулсан ажил, арга хэмжээний үеэр байршуулж, ажилтан, албан хаагч, иргэдэд танилцуулан сурталчилж ажилласан. Аяны хүрээнд нийслэлийн 9 дүүргийн хэмжээний анхан шатны шалгаруулалтад дүүргийн нэгдсэн тайланг хүргүүлсэн нь "Тэргүүн байр"-т шалгарч, улсын хэмжээний хоёрдугаар шатны шалгаруулалтад оролцож байна. Уг аяны хүрээнд Нийслэлийн Соёл Урлагийн газрын харьяа байгууллагуудын анхан шатны шалгаруулалтад дүүргийн Соёлын төвийн нэгдсэн тайланг НСУГ-т хүргүүлсэн нь "Тэргүүн байр"-т шалгарч, улсын хэмжээний хоёрдугаар шатны шалгаруулалтад оролцож байна. Мөн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагын шалгаруулалтад дүүргийн Хүүхэд хөгжлийн цогцолборын нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг Соёл Урлагийн газарт хүргүүлж, улсын хэмжээний шалгаруулалтад оролцож байна. Дүүргийн Соёлын төвийн ахмадын "Дөрвөн цаг" хамтлагийн уран бүтээлчдийн "Монгол нутгийн | 100% | Соёлын төв | НХХ | 30% |
| 2.8.2 Хороодын "Иргэний танхим"-ыг иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх жишиг танхим болгон тохижуулж, иргэдийг хөгжүүлэх олон талт үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна. | 75 | 2.8.2.1 Хороодод "Угийн бичгийн танхим" байгуулж, иргэдэд үндэсний өв уламжлал, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх аргазүйг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана. | 2025-2028 | 240.0 | | Үйл ажиллагаа | Тоо | 25 | 6 | - | - | Иргэд, олон нийтийн үндэсний өв уламжлал, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх аргазүйг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг нийт 10 удаа зохион байгуулж, дүүргийн 1-24 дүгээр хороодын 620 гаруй иргэдийг сургалтад хамруулж, хамрагдсан иргэдэд гарын авлага, зөвлөмжийг олгож ажилласан. | 100% | НХХ | Соёлын төв | 100% |
| | 76 | 2.8.2.2 Үндэсний шагайн харвааны спортыг хөгжүүлэх олон төрөлт үйл ажиллагааг хэрэгжүүлж, "Шагайн харвааны танхим", клубтэй болоход нь дэмжлэг үзүүлнэ. | 2025-2028 | 176.0 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагаа | Тоо | 0 | 10 | 44.00 | 4.00 | ЮНЕСКО-гийн соёлын биет өвийн жагсаалтад бүртгэгдсэн Монголын өв соёлын нэгэн чухал бүрдэл болсон шагайн харвааны спортыг хөгжүүлэх, залуу хойч үед өвлүүлэн үлдээх, иргэд, хүүхэд залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор дүүргийн 12 дугаар хороонд "Шагайн харвааны танхим"-ыг байгуулж, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр танхимын нээлтийг хийсэн. Монголын түүх соёлын өв, дэлхийн биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн шагайн харвааг хөгжүүлэх чиглэлээр Чингэлтэй дүүргийн хороо бүрд шагайн харвааны танхимыг үе шаттайгаар байгуулах бөгөөд энэ онд дүүргийн 1, 13, 14 дүгээр хороодод шагайн харвааны хэрэгслийг гардуулж өгсөн. | 100% | НХХ | "Чингэлтэй хайрхан шагайн харвааны клуб" | 70% |
| 2.8.3 Үндэсний түүх, соёл, зан заншил, биет болон биет бус өв, нүүдлийн соёлыг иргэдэд сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлнэ. | 77 | 2.8.3.1 Үндэсний түүх , соёл, зан заншил, соёлын биет ба биет бус соёлыг түгээх дэлгэрүүлэх олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлж дүүргийн иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлнэ. | 2025-2028 | 640.0 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагаа | Тоо | 15 | 8 | 160.00 | 10.00 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын дагуу "Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг тохиолдуулан дүүргийн 1-24 дүгээр хорооны ажилтан, албан хаагчдад "Монгол бичгийн анхан шатны сургалт"-ыг 3 удаа зохион байгуулж, 200 гаруй албан хаагчид хамрагдсан. "Бахархалт монгол бичиг" уралдааныг 4 төрлөөр зохион байгуулж, нийт 13 сургуулийн дунд, ахлах ангийн 10,000 гаруй хүүхэд, багачууд хамрагдсан. Дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын урлагийн боловсролыг дээшлүүлэх, соёлын биет бус өв Уртын дуу, Бие биелгээг сурталчлан таниулах, дэлгэрүүлэх, өвлөн уламжлуулах, харилцан суралцах, урлаг зан заншлаараа бахархах үзлийг төлөвшүүлэх зорилгоор "Завсарлагааны дуу, бүжиг" аяныг 2 сарын хугацаанд зохион байгуулж, 2000 хүүхэд, багачууд хамрагдсан бөгөөд 4 видео контентыг бэлтгэн сошиал сувгуудаар түгээн сурталчилж 18000 хандалт авсан. Монголын орчин үеийн утга зохиолыг үндэслэгчдийн нэг XX зууны манлай Монголч эрдэмтэн, билгүүн номч Б.Ренчингийн мэндэлсний 120 насны ойг тохиолдуулан дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын дунд "Бахархалт Монгол хэл, бичиг" видео бичлэгийн уралдааныг зарлаж, бичлэгийг дүүргийн албан ёсны цахим хуудсанд байршуулсан бөгөөд нийт 13 сургуулийн 4000 гаруй сурагчид хамрагдаж, 20,000 гаруй иргэний хандалт авсан байна. Дүүргийн Засаг даргын 2024-2028 үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дүүргийн ахмад настны урлагийн авьяасыг нээн хөгжүүлэх, хөгжмийн ур чадварыг соёл урлагаар дамжуулан олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх зорилготой "Мандолин хөгжмийн хамтлаг"-ийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, нийт 60 гаруй ахмад хамрагдсан. Монгол Улсад хэдэн үндэстэн ястан байдаг, тэдний хувцас хэрэглэл, аж амьдралын онцлог, оршин суугаа нутаг дэвсгэр нь хаагуур тухай мэдлэгийг олгох зорилгоор "Монгол үндэстэн ястан" сургалтыг үе шаттай зохион байгуулж, 200 гаруй дүүргийн хүүхэд багачууд хамрагдсан. Монгол өв уламжлалын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, таниулах, өвлүүлэн үлдээх, уламжлалт ёс, заншил, хувцас эдлэл, соёлын өвийг орчин үеийн их хотын соёлтой хослуулах зорилгоор "Монгол хантааз урлах" сургалтыг 3 удаагийн давтамжтай зохион байгуулсан. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас үндэсний бахархал, эв нэгдлийг иргэн бүрд төлөвшүүлэх, өв соёлоо түгээн дэлгэрүүлж, сурталчлах зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд, төр захиргааны байгууллага, албан хаагчид, хамт олныг долоо хоног бүрийн Даваа гарагийг "Үндэсний хувцас"-тай өдөр болгон баталсан тогтоолын хэрэгжилтийг хангаж, үндэсний хувцасаа өмсөж хэвшсэн. | 100% | НХХ | Соёлын төв | 100% |
| | 78 | 2.8.4.1 Дүүргийн Соёлын биет бус тээгчийн үйл ажиллагааг сурталчлан таниулах, дотоод гадаадын уралдаан тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлнэ. | 2025-2028 | 80.0 | Дүүргийн төсөв | үйл ажиллагаа | тоо | 2 | 2 | 20.00 | 5.00 | БНСУ-ын Гванжу хотод зохион байгуулагдсан соёлын фестивальд дүүргийн Соёлын төвийн уран бүтээлч Т.Оюунболд үндэсний болон орчин үеийн урлагийн тоглолтод оролцсон. Оросын нэрт хөгжмийн зохиолч Исаак Дунаевскийн нэрэмжит Олон Улсын дуулаачдын XV дахь уралдаан ОХУ-ын Москва хотод зохион байгуулагдаж, дүүргийн Соёлын төвийн дууны багш МУСТА П.Баярмагнай Дуурийн дуулаачийн төрөлд тэргүүн байр, Эстрад дууны төрөлд тэргүүн байр, Үндэсний дууны төрөлд мөн тэргүүн байр эзэлсэн. БНСУ-ын Ёндунгүн хотын Ёндунг сумын 57 дахь олон улсын соёлын фестивальд дүүргийн соёлын төвийн 7 уран бүтээлч ардын болон орчин үеийн урлагийн тоглолтоо толилуулж, соёлын биет бус өвийг сурталчилж ажилласан ба тус фестивальд 35 орны уран бүтээлчид оролцсон. БНСУ-ын Гванжу хотод 10 дугаар сард зохион байгуулагдсан Олон улсын соёлын фестивальд дүүргийн Соёлын төвийн морин хуурын багш Хөсөгтөн хамтлагийн гишүүн В.Батзориг, хөөмийн багш О.Чулуунбаатар нар амжилттай оролцсон. | 100% | НХХ | ЗДТГ | 100% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.8.4 Олон үндэстэн угсаатны ардын язгуур урлагийг түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ. | 79 | 2.8.4.2 Дүүргийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг түшиглэн урлаг, соёлын үйл ажиллагаа, үзэсгэлэн худалдаа зохион байгуулж иргэд, жуулчдад таниулан сурталчилна. | 2025-2028 | 40.0 | Дүүргийн төсөв | үйл ажиллагаа | тоо | 2 | 6 | 10.00 | 4.40 | Нийслэлийн Засаг даргын санаачилгаар хоёр дахь жилдээ Сар шинийн баярыг угтан зохион байгуулсан "Амар байна уу-2025" үзэсгэлэн худалдааны нээлтэд дүүргийн 54 уран бүтээлчдийн бүрэлдэхүүнтэй ардын урлагийн тоглолтыг толилуулсан. Улсын драмын эрдмийн театр, Монголын зохиолчдын эвлэлтэй хамтран зохион байгуулсан “Утга зохиолын 7 хоног” аянд дүүргийн Соёлын төвийн уран бүтээлчид, ахмадын “Дөрвөн цаг хамтлаг” оролцож, УДЭТ-ын тайзнаа урлагийн тоглолтыг толилуулсан. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ойн хүрээнд нийслэл болон 21 аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад орон нутгийн сайн туршлагыг танилцуулах, түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий “Бүтээмж ба инновац UB 2025” арга хэмжээг зохион байгуулж, дүүргийн “Чингэлтэй цогцолбор”, “Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны мэдээллийн төв, 14 дүгээр хорооны үйл ажиллагааг тус тус танилцуулж ажилласан. Дүүргийн Соёлын төвийн уран бүтээлчид Бүгд Найрамдах Солонгос Улсын Гванжу (соёлын) хотын “Дурсамж-2025” фестивальд оролцож, үндэсний урлагаа сурталчлан таниулах ажлыг хэрэгжүүлсэн. Яруу найрагч Б.Явуухулангийн мэндэлсэн өдрийг угтан дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Би хаана төрөө вэ”, “Тэхийн зогсоол” найраглалын уран уншлагын тэмцээнийг зохион байгуулж, мөн “Их хэл -Дурсамж өдөрлөг” арга хэмжээг Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулж, нийт 250 гаруй иргэн, “Аугаа эх орны ялалтын 80 жил”-ийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд “Өдөрлөг” арга хэмжээг Тусгаар тогтнолын талбайд зохион байгуулж, нийт 500 гаруй иргэд, хүүхэд багачууд хамрагдсан. | 100% | НХХ | | 100% |
| 2.8.5 “Залуучуудын хөгжлийн төв”, “Гэрлэх ёслолын танхим” бүхий дүүргийн “Соёлын ордон”-г байгуулж, соёл урлагийн салбарыг бүх талаар дэмжин, бие даасан чадамжтай болгоно. | 80 | 2.8.5.1 Дүүргийн иргэдэд соёл, урлагаар үйлчлэх Соёлын ордон барих ажлыг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | 60,900.0 | Дүүргийн төсөв | Барилгын ажлын хэрэгжилт | Хувь | 0 | 10 | 450.00 | 13.00 | Дүүргийн иргэдэд соёл, урлагаар үйлчлэх зориулалт бүхий “Соёлын ордон”-г байгуулах зураг төсөл хийлгэх зардлыг тооцоолж, дүүргийн 2026 оны төсөвт тусгуулахаар төсвийн саналд нэгтгэж ажилласан. | 70% | НХХ | Соёлын төв | 30% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 704.00 | 558.40 | | | | | |
| ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД | | | | | | | | | | | | | | | | |
| **2.9.Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулж, гэр бүлд эрүүл, эерэг харилцаа хандлага төлөвшүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | | |
| 2.9.1 Хүүхэд, залуучуудад чиглэсэн хөгжлийн цогц бодлогыг баримталж, “Хүүхэд залуучуудын хөгжил, хамгаалал-2028” арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ. | 81 | 2.9.1.1 “Хүүхэд залуучуудын хөгжил, хамгаалал-2028” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | | Дүүргийн төсөв | Хөтөлбөрийн хэрэгжилт | Хувь | 100 | 100 | - | 83.00 | "Хүүхэд залуучуудын хөгжил, хамгаалал-2028" арга хэмужээг боловсруулан Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлуулж, 3 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг хэрэгжүүлж байна. | 100% | НХХ | ЗДТГ ГБХХХ | 84% |
| 2.9.2 “Хүүхэд хөгжлийн цогцолбор”-ыг өргөтгөх ажлын хүрээнд “Хүүхдийн зуслан”-г шинээр байгуулна. | 82 | 2.9.2.1 Хүүхдийн зуслангийн зураг төсвийг батлуулж, барилгын ажлыг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 0 | 5 | 750.00 | - | Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2022 оны А/400 дугаар захирамжийн дагуу 10 га газрыг Хүүхдийн зуслан сургалтын зориулалтаар олгож нэгдсэн санд бүртгээгүй байсныг мэдээллийн санд нөхөн бүрдүүлсэн. Үүний дагуу “Ди эм Ти инженеринг” ХХК-аар байр зүйн дэвсгэр зургийг хийлгэсэн. Хүүхдийн зуслангийн зураг төсөв боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд техникийн нөхцөлүүдийг гаргуулахаар холбогдох байгууллагуудад дүүргийн Засаг даргын орлогчийн албан бичгийг хүргүүлсэн. Нийслэлийн ерөнхий архитекторын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 2025/00-156 тоот архитектор төлөвлөлтийн даалгавар батлагдаж ирсэн ба нийт 40010.8 мкв газар төлөвлөлт хийгдсэн. "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн Дугаар А-U2025/151 тоот техникийн нөхцөл гаргуулж, нийслэлийн Байгаль орчны газраас худаг гаргах зөвшөөрлийг авсан. Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн дүүргийн 2025 оны төсвийн тодотголоор Хүүхдийн зуслангийн зураг төсөлд шаардлагатай 750,000,000 /долоон зуун тавин сая/ төгрөгийг тусгуулсан. | 70% | НХХ | ЗДТГ, ХХЦ УТҮГ | 50% |
| 2.9.3 Оюутан, залуусын хөгжлийг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүний нөөцийн зохистой бодлогыг баримтална. | 83 | 2.9.3.1 Оюутан, залуусын хөгжлийг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүний нөөцийн зохистой бодлогыг баримтална. | 2025-2028 | | Дүүргийн төсөв | Хамрагдсан залуус | Тоо | 40 | 10 | 35.00 | 30.00 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн "Шилдэг старт-ап" санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулж, нийт 52 залууг хамруулсан. Дүүргийн шинэ технологи, инновац бүхий шинэлэг санал, санаачилга гаргасан шилдэг 9 багаас Шилдэг Старт-апаар “Step Up” баг, “Анара” баг тус тус шалгарч, тус бүр 15,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан. Оюутан, залуучуудыг цагаар хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын 23 дугаар сургууль болон 33 дугаар цэцэрлэгт ногоон байгууламжийг арчлах, цэвэрлэх, насжилт өндөртэй модыг тайрах, хэлбэржүүлэх ажлыг зохион байгуулж, ажил хайгч 46 иргэн, Шинэ иргэншил политехникийн коллежийн 6 оюутан, нийт 52 иргэнийг түр ажлын байраар хангаж ажилласан.Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг "Монгол Холт" хүүхдийн халамжийн байгууллагатай хамтран залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийг хэрэгжүүлж, 45 залууг мэргэжил олгох сургалтад хамруулсан. | 100% | НХХ | ЗДТГ, ХХЦ | 100% |
| 2.9.4 Дүүргийн харьяат хүүхэд, гэр бүл, иргэнд тусламж үйлчилгээ, сургалт нөлөөллийн үйл ажиллагаа үзүүлж буй төрийн болон төрийн бус байгууллага, Олон улсын байгууллагын бүртгэл мэдээллийг нэгтгэж, хяналт тавин хамтран ажиллана. | 84 | 2.9.4.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон тэдний эцэг, эх гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, идэвхжүүлэх, нийгмийн харилцаанд татан оролцуулах чиглэлээр оролцооны байгууллагуудыг дэмжинэ. | 2025-2028 | 84.0 | Улсын төсөв | Үйл ажиллагаа | Тоо | 13 | 16 | 21.00 | 21.00 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ гэртээ асардаг эцэг эх, асран хамгаалагчдад сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, амьдралынх нь чанарыг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тэдний амьжиргаанд эерэг нөлөө үзүүлэх нэмэлт орлого олох боломжийг бүрдүүлэх зорилгоор Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран “Хамтдаа хөгжье” сургалтыг зохион байгуулсан ба сургалтаар давсан урлал, эко саван урлахуйн хичээл, эцэг эх асран хамгаалагчдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлгийн уулзалт сургалтыг зохион байгуулж, нийт 86 иргэнийг хамруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон тэдний эцэг, эх гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд төсөлд хамрагдсан 70 гаруй иргэний үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүнийг борлуулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн 1 дүгээр давхарт “Чингэлтэйд үйлдвэрлэв-3“, “Нарлаг дэнж” худалдааны төвийн 3 давхарт “Чингэлтэйд үйлдвэрлэв-3” борлуулалтын төвийг тус тус ажиллуулж 16,3 сая төгрөгийн борлуулалтын дэмжлэг үзүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ гэртээ асардаг эцэг эх, асран хамгаалагчдад сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, амьдралынх нь чанарыг сайжруулах зорилгоор “Сэтгэл хөдлөл мэдрэмжээ илэрхийлцгээе” сэдвийн хүрээнд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлгийн сургалтыг 2 удаа зохион байгуулсан. | 100% | НХХ | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс | 100% |
| 2.9.5 Гэр бүлийн хүчирхийллийн гэрч хохирогчийг хамгаалах “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг олон улсын стандартад нийцүүлэн засварлаж, тохижуулна. | 85 | 2.9.5.1 Гэр бүлийн хүчирхийллийн гэрч хохирогчийг хамгаалах “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг олон улсын стандартад нийцүүлэн засварлаж, тохижуулах ажлыг эхлүүлнэ. | 2025-2028 | 230.0 | Улсын төсөв | Засварын ажлын хэрэгжилт | Хувь | 0 | 10 | 57.50 | - | Чингэлтэй дүүргийн гэрч хохирогчийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв нь 2020 оноос тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс өөрийн нөөц боломжиндоо тулгуурлан урсгал засварын ажлыг гүйцэтгэсэн. | 30% | НХХ | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс | 30% |
| | 86 | 2.9.5.2 Гэр бүлийн хүчирхийллийн гэрч, хохирогчийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг олон улсын стандартад ойртуулж, хүүхэд хөгжил, хамгааллын чиглэлээр олон талт үйл ажиллагаа зохион байгуулна. | 2025-2028 | | Улсын төсөв | Үйл ажиллагаа | Тоо | 2 | 3 | - | - | Гэр бүлийн хүчирхийллийн гэрч хохирогчийг хамгаалах Нэг цэгийн үйлчилгээний төвд 2025 онд нийт 221 үйлчлүүлэгч хүлээн авснаас 208 хүүхэд, 13 насанд хүрсэн иргэдэд үйлчилгээ үзүүлж ажилласан. Хамгааллын үйлчилгээ авч байгаа хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийг 5 нас, 6-10 нас, 11-18 насаар ангилан хөтөлбөрийн дагуу боловсролын үйлчилгээг тасралтгүй олгож, насны ангиллаар эрүүл мэнд, танин мэдэхүйн мэдлэг олгох, амьдрах ухааны чадварт суралцуулах, сэтгэл заслын үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн боловсрол (хөдөлгөөнт дасгал, шүдний эрүүл ахуй, анхны тусламжийн анхан шатны мэдлэг), Харилцааны ур чадвар олгох хичээл, дүрст тоглоом эвлүүлэх болон зургийн хичээл (хүүхдийн баруун зүүн тархи хөгжүүлэх), сэтгэл зүйн боловсрол (өөрийгөө ойлгож танин мэдэх), дуу сонсох, дуулах (өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх зорилготой), үлгэрийн цаг (хүүхдийн хэл ярианы чадварыг дээшлүүлж, унших сурах хүсэл эрмэлзлийг нь нэмэгдүүлэх зорилготой) гэх мэт 7 төрлийн агуулгын | 100% | НХХ | ЗДТГ ГБХХХ | 100% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.9.6 Хүүхэд багачууд, өсвөр үе, залуучуудад эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлж, уламжлалт ёс заншил, өв уламжлалыг сурталчлах, соёлын биет ба биет бус өвийг өвлөн уламжлах чиглэлээр олон талт арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. | 87 | 2.9.6.1 Хүүхэд багачууд, өсвөр үе, залуучуудад эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлж, уламжлалт ёс заншил, өв уламжлалыг сурталчлах, соёлын биет ба биет бус өвийг өвлөн уламжлах чиглэлээр олон талт арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. | 2025-2028 | 42.0 | Улсын төсөв | Үйл ажиллагаа | Тоо | 3 | 4 | 10.50 | 250.00 | Үндэсний соёл, өв уламжлал, үнэт зүйлсийг соёл урлагаар дамжуулан иргэдэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Чингэлтэйн Фестиваль-2025” арга хэмжээг “Иргэдийн баяр - Гэр бүлээрээ баярлая” уриан дор зохион байгуулсан бөгөөд иргэд, олон нийтэд зориулсан урлагийн тоглолт, бүжгийн баттле, хоол хүнс, худалдаа үйлчилгээ, хүүхэд багачуудад зориулсан тоглоом, спортын тэмцээн уралдаан, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үзэсгэлэнг гаргаж, орчин нөхцөлийг бүрдүүлэн 3 байршилд соёл урлагийн үйл ажиллагааг зохион байгуулж, 5000 гаруй иргэд, олон  нийтийг хамруулсан. Монголын орчин үеийн утга зохиолыг үндэслэгчдийн нэг XX зууны манлай Монголч эрдэмтэн,  билгүүн номч Б.Ренчингийн мэндэлсний 120 насны ойг тохиолдуулан дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Бахархалт Монгол хэл, бичиг” видео бичлэгийн уралдааныг зарлаж, бичлэгийг дүүргийн албан ёсны цахим хуудсанд байршуулсан бөгөөд нийт 13 сургуулийн 17000 гаруй сурагчид хамрагдаж, 800,000 гаруй иргэний хандалт авсан байна. Дүүргийн шалгаруулалтыг 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж, шагналт байранд шалгарсан сургуулиудад шагнал гардуулах үйл ажиллагааг зохион байгуулсан.Дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын урлагийн боловсролыг дээшлүүлэх, соёлын биет бус өв Уртын дуу, Бие биелгээг сурталчлан таниулах, дэлгэрүүлэх, өвлөн уламжлуулах, харилцан суралцах, урлаг зан заншлаараа бахархах үзлийг төлөвшүүлэх зорилгоор “Завсарлагааны дуу, бүжиг” аяныг 2 сарын хугацаанд зохион байгуулж, 2000 хүүхэд, багачууд хамрагдсан бөгөөд 4 видео контентыг бэлтгэн сошиал сувгуудаар түгээн сурталчилж 18000 хандалт авсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын дагуу “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг тохиолдуулан дүүргийн 1-24 дүгээр хорооны ажилтан, албан хаагчдад “Монгол бичгийн анхан шатны сургалт”-ыг 3 удаа зохион байгуулж, 200 гаруй албан хаагчид хамрагдсан. Эх хэл, бичиг үсэг, соёл, өв уламжлал, зан заншил, үнэт зүйлийг хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх, үндэсний монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, таниулан сурталчлах зорилгоор “Бахархалт монгол бичиг” уралдааныг 4 төрлөөр зохион байгуулж,  нийт 13 сургуулийн дунд, ахлах ангийн 10,000 гаруй хүүхэд, багачууд хамрагдсан. | 100% | НХХ | ЗДТГ ГБХХХ | 100% |
| | 88 | 2.9.6.2 Өсвөр үе, хүүхэд багачуудыг цахим дээрэлхэлт, цахим гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагаар үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2025-2028 | 679.0 | Улсын төсөв | Үйл ажиллагаа | тоо | 2 | 3 | 169.00 | 33.00 | Өсвөр насны хөвгүүдэд гэмт хэрэг, зөрчлийн талаар болон түүнээс урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээллийг өгөх, анхан шатны хууль зүйн мэдлэг олгох зорилгоор “Элд Мори Консалтинг” хууль зүйн фирмтэй хамтран “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сургалт, “Үе тэнгийн дарамт дээрэлхэлт”, ”Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлье”, “Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт” сэдэвт өртөөчилсөн сургалтыг 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 24-ний өдрүүдэд зохион байгуулж, 2100 орчим хүүхдийг хамруулсан. “Охидоо хамгаалъя” өдөрлөгийг зохион байгуулж, дүүргийн нийт 8 сургуулийн өсвөр насны охидын төлөөлөл оролцож, охидын эрүүл мэнд, хүүхдийн эсрэг гэмт хэргийн тухай ойлголт, цахим орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийн эрхийн тусламж үйлчилгээ авч болох байгууллагуудын мэдээлэл зэрэг өсвөр насныханд тулгарч буй эрүүл мэнд, нийгмийн асуудлуудын талаар мэдлэг мэдээллийг хүргэсэн. Дүүргийн иргэд олон нийтийг хамарсан арга хэмжээнүүдэд хүүхдийг хүчирхийлэл, осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сэтгэл зүйн анхан шатны оношилгоо, зөвлөгөө, хууль зүйн болон гэр бүлийн зөвлөгөө мэдээлэл, брошур танилцуулга, бага насны 500 орчим хүүхдэд эцэг эхээсээ төөрхөөс сэргийлсэн бугуйвч зүүх зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулж, нийт 1000 гаруй хүнийг хамруулсан. Соёл урлагийн их сургуулийн харьяа Бадмаараг ахлах сургуулийн сурагчдад ”Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж, 11-12 дугаар ангийн 180 хүүхдийг, дүүргийн 17, 18, 23 дугаар хорооны Хамтарсан баг, Ерөнхий боловсролын 37 дугаар сургуулийн Хүүхэд хамгааллын багтай хамтран “Үе тэнгийн дээрэлхэлт сэдвээр сургалт зохион байгуулж, 700 гаруй хүүхдийг хамруулсан. Олон улсын Гэр бүлийн өдрөөр хүүхдийг хүчирхийлэл, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Сурагчийн аюулгүй байдал” ном 250 ширхэг, Хүүхдийн эрхийн тухай хууль, | 100% | НХХ | ЗДТГ ГБХХХ ЦГ | 100% |
| 2.9.7 Өсвөр үе, хүүхэд багачуудыг цахим дээрэлхэлт, цахим гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагаар үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 89 | 2.9.7.1 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, тогтвортой гэр бүлийг бий болгох замаар хүүхэд залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, дээшлүүлэхэд   дэмжлэг үзүүлнэ. | 2025-2028 | 28.0 | Улсын төсөв | Үйл ажиллагаа | тоо | 2 | 3 | 6.00 | 5.00 | Эцэг эх, асран хамгаалагч нарт хүүхдийн нас, сэтгэхүй, хөгжлийн онцлогт тохируулан харилцах, хүмүүжүүлэх боловсролыг олгох зорилгоор “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сургалтыг зохион байгуулж, 200 гаруй хүнийг хамруулсан. Хүүхдийн зодож шийтгэхийн эсрэг Олон улсын өдрийг олон нийтэд таниулах, хүмүүжлийн эерэг аргын талаар зөвлөгөө өгөх зорилгоор постер, зөвлөмжийг бэлтгэн цахим хаягт байршуулж, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах салбар зөвлөлтэй хамтран 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Тусгаар тогтнолын талбайд “Шийтгэл бол Шийдэл биш” аяны хаалтын арга хэмжээг зохион байгуулсан. Энэ үеэр Хүүхдийг зодож шийтгэхгүй байх “Уриалга” арга хэмжээг зохион байгуулж, 1500 орчим иргэдийг хамруулсан. Цагдаагийн ерөнхий газар, дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтэс, дүүргийн 9 дүгээр хорооны хүүхэд хамгааллын хамтарсан багтай хамтран гэр бүлийн хүчирхийллийг бууруулах зорилгоор зохион байгуулсан  “Аз жаргалтай гэр бүл” нөлөөллийн үйл ажиллагаанд 45 гэр бүлийг хамруулсан. Гэр бүлийн боловсрол олгох зорилгоор хосын харилцаа, гэр бүлд эзлэх гишүүдийн үүрэг оролцоо, стрессийг даван туулах, ажил амьдралын тэнцвэр гэх зэрэг агуулгын хүрээнд Модуль сургалтыг Г.Занабазарын нэрэмжит "Дүрслэх урлагийн музей", “УБТЗ ашиглалтын цех” гэсэн байгууллагуудын 100 орчим албан хаагчдыг хамруулсан. Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газартай хамтран “Ажилтай өрх-Аз жаргалтай гэр бүл” өдөрлөгийг Сүхбаатарын талбайд зохион байгуулж, гэр бүлийн эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, хүүхдийн эрхийн тухай ойлголт, хууль эрх зүйн мэдлэг олгох зорилгоор 100 орчим иргэнд зөвлөгөө, мэдээлэл, өгч ажилласан. | 100% | НХХ | ЗДТГ ГБХХХ | 100% |
| | Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | 1,049.00 | 422.00 | | | | | |
| **ГУРАВ: ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | | | | | |
| **САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО** | | | | | | | | | | | | | | | | |
| **3.1. Дүүргийн эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд төсвийн оновчтой бодлогыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | | |
| 3.1.1 Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын төсвийн зардлыг эдийн засгийн нөөц, улирлын онцлогт нийцүүлэн төлөвлөх замаар төсвийн урсгал зардлын тэлэлтийг хязгаарлаж, төсвийн зардлын үр ашгийг нэмэгдүүлнэ. | 90 | 3.1.1.1 Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зардлын үр ашгийг нэмэгдүүлнэ. | 2025-2028 | - | Дүүргийн төсөв | | Хувь | 100 | 100 | 327,488.70 | 238,758.63 | Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны “Дүүргийн 2025 оны төсөв батлах тухай” 14 дүгээр тогтоолоор баталсан төсвийг Төрийн хэмнэлтийн тухай хууль, Дүүргийн Засаг даргын  2022 оны “Төсвийн үр өгөөж, сахилга хариуцлагыг сайжруулах” тухай А/45 дугаар захирамжийн дагуу орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрууд, харьяа алба, хэлтэс, тасгууд, боловсрол, эрүүл мэндийн салбарын 2025 оны төсвийн зарлага, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг, ОНХС, төсвийн орлогын сарын хуваарийг боловсруулан Засаг даргын 2025 оны А/13, А/102, А/172 дугаар захирамжаар тус тус батлуулан төсвийн хуваарьт зохицуулалт хийж ажилласан. Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны "Дүүргийн 2025 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 16 дугаар тогтоолоор дүүргийн төсвийг тодотгож, тодотголын дагуу Засаг даргын А/199 дүгээр захирамжаар төсвийн хуваарьт зохицуулалт хийж ажилласан. Төсвийг үр ашигтай зарцуулж ажилласан. | 100% | СТСХ | | 100% |
| 3.1.2 Дүүргийн хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх санхүүжилтийн шинэ эх үүсвэрийг нэмэгдүүлж, татварын бааз суурийг бэхжүүлнэ. | 91 | 3.1.2.1 Дүүргийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжиж байгаа болон он дамжин санхүүжигдэх төсөл, арга хэмжээний уялдааг хангаж, санхүүжилтийг олгож, гүйцэтгэлийг хянан удирдлагыг мэдээллээр хангах | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв, ОНХС | | Хувь | | 100% | 64,600.00 | 28,663.79 | 1. Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 16 дугаар тогтоолоор Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024-2025 он дамжин хэрэгжүүлэх 42 төсөл, арга хэмжээ батлагдсанаас бүрэн хэрэгжсэн 22 төсөл, арга хэмжээний 9,902,175.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон.<br>- Бүрэн хэрэгжсэн 22,<br>- Гэрээ байгуулан ажил үргэлжилж байгаа 15,<br>- Огт хэрэгжээгүй 5 төсөл, арга хэмжээ байна. 2. Төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжүүлэх 171 төсөл, арга хэмжээ батлагдсанаас бүрэн хэрэгжсэн 58 төсөл, арга хэмжээний 16,633,805.2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон.<br>- Бүрэн хэрэгжсэн 58,<br>- Гэрээ байгуулан ажил үргэлжилж байгаа 89,<br>- Огт хэрэгжээгүй 24 төсөл, арга хэмжээ байна.<br>3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024-2025 он дамжин хэрэгжүүлэх 8 төсөл, арга хэмжээ батлагдсанаас бүрэн хэрэгжсэн 3 төсөл, арга хэмжээний 382,008.9 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон.<br>- Бүрэн хэрэгжсэн 3,<br>- Огт хэрэгжээгүй байгаа 1,<br>- "Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв" ОНӨААТҮГ рүү эрх шилжүүлсэн 4 төсөл, арга хэмжээ байна.<br>4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд шинээр хэрэгжүүлэх 9 төсөл, арга хэмжээ батлагдсан. Үүнээс:<br>- Бүрэн хэрэгжсэн 0,<br>- Огт хэрэгжээгүй байгаа 1,<br>- "Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв" ОНӨААТҮГ рүү эрх шилжүүлсэн 8 төсөл, арга хэмжээ байна. "Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв" ОНӨААТҮГ рүү эрх шилжүүлсэн нийт 12 төсөл, арга хэмжээний 1,745,799.8 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна. | 80% | СТСХ | ХААА, ТГУХ | 70% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 92 | 3.1.2.2 Дүүргийн татварын хэлтсийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, санхүү, төсөв, татварын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, нийслэл, дүүргийн төсөвт төвлөрүүлэх төсвийн орлогын бүрдүүлэлтийг хангах ажлыг зохион байгуулна. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | | Хувь | 100% | 100% | 301,400.00 | 283,300.00 | Монгол улсын Төсвийн тухай хуулийн 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн 23 дугаар зүйл буюу Төсвийн орлогын бүрдэлд өөрчлөлт орж тус өөрчлөлтийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж ажиллаж байна.<br>Дүүргийн 2025 оны төсвийн орлого 301.1 тэрбум төгрөг төлөвлөгдсөн. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар /ХБГ/ өссөн дүнгээр:<br>- Улсын төсөв: төлөвлөгөө 111,968,661.67 мянган төгрөг, гүйцэтгэл 112,080,630.3 мянган төгрөг төвлөрүүлж 100.1 хувьтай;<br>- Нийслэлийн төсөв: төлөвлөгөө 20,837,752.97 мянган төгрөг, гүйцэтгэл 19,795,865.32 мянган төгрөг төвлөрүүлж 95 хувьтай;<br>- Дүүргийн төсөв: төлөвлөгөө 301,173,664.9 мянган төгрөг, гүйцэтгэл 286,114,981.66 мянган төгрөг төвлөрүүлж 95 хувьтай;<br>Нийт дүнгээр 433,980,079.54 мянган төгрөг төвлөрүүлэхээс 417,991,477.31 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж 96.32 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. | 100% | СТСХ | Татвар | 90% |
| 3.1.3 Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр дүүргийн хэмжээнд хийгдсэн өмч хөрөнгийг эзэнжүүлж, ашиглалт хамгаалалтыг сайжруулна. | 93 | 3.3.3.1 Улс, нийслэл дүүргийн төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 65, 66 тогтоолын дагуу бүртгэж эзэнжүүлэх | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Улс, нийслэл, ДТХ, ОНХС | | Хувь | 95% | 100% | - | - | Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж дууссан төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын дагуу 1,404,346,685.88 төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг бүртгэн эзэнжүүлж ажилласан. Мөн дүүргийн төсвийн хөрөнгө болох “Хорооны барилга худалдан авах” (20 дугаар хороо) 1,390,000,000, “Хорооны цогцолбор барилга барих” (17 дугаар хороо) 2,976,000,000 төгрөгийн төсөвт өртөгт бүхий барилгыг Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгүүлэх албан бичгийг 2025 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн 03/2366 тоот албан бичгээр, “Дүүргийн авто баазын барилга”-ыг Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨААТҮГ-ын хөрөнгөд бүртгүүлэх албан бичгийг 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 03/3224 албан бичгээр тус тус хүргүүлж ажилласан. | 100% | СТСХ | | 100% |
| | 94 | 3.1.3.2 Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын үйл ажиллагааг тогтмолжуулж журмын дагуу хөрөнгийн ашиглалт, арчлалт, хамгаалалтыг сайжруулах | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Улс, нийслэл, ДТХ, ОНХС | | Хувь | 95% | 100% | - | - | Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/344 дугаартай тушаалаар батлагдсан “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг 4 удаа хуралдуулж 7 асуудлыг хэлэлцүүлж Нийслэлийн өмчийн харилцааны газарт уламжлан шийдвэрлүүлж, мөн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/437 дугаар тушаалаар "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн гишүүдийг шинэчлэн батлуулж ажилласан. | 100% | СТСХ | | 100% |
| 3.1.4 Дүүргийн төсвийн тэнцвэрт байдал, эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэн, нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн нөөц бүрдүүлэн ажиллана. | 95 | 3.1.4.1 Дүүргийн төсвийн орлого, зарлагын төсвийн төслийг боловсруулах, санал авах, тодотгох, судалгаа, тооцоо хийж, төсвийн төслийг хуулийн дагуу өргөн барьж, хэлэлцүүлэх, батлуулах, хэрэгжүүлэх | 2025-2028 | - | Дүүргийн төсөв | | Хувь | 100% | 100% | - | - | Чингэлтэй дүүргийн Засаг даргын захирамжаар төсвийн хуваарийг батлуулж, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелэлтийг хэрэгжүүлэн ажилласан. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит хуралдаанаар хэлэлцэн батлагдсан дүүргийн 2021, 2022, 2023, 2024 оны төсвийн орлого, зарлагын сар, улирлын хуваарийг боловсруулан батлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон дүүргийн төсөвт 70 байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн хяналт тавьж ажиллаж байна. Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийслэлийн Засаг даргын захирамж, бусад холбогдох бичиг баримтын хүрээнд дүүргийн төсөвт өөрчлөлт оруулж, төсвийн орлого, зарлагын сар, улирлын хуваарийг боловсруулан батлуулж ажилласан. | 100% | СТСХ | | 100% |
| 3.1.5 Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг сайжруулж, орон нутгийн төсвийн бие даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулна. | 96 | 3.1.5.1 Дүүргийн татварын хэлтсийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж, татварын орлого нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа хийж дүгнэлт гаргах, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах, орлогын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах; | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | | Хувь | 100% | 100% | - | - | 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар нийт 2348 өртэй татвар төлөгч иргэнд 31,162,909.42 мянган төгрөгийн нэхэмжлэх хүргүүлэн 2,972,909.42 мянган төгрөгийн өрийг барагдуулж, нэхэмжлэх хуудас гардуулснаас хойших хоногийн хугацаанд огт төлөлт хийгээгүй татвар төлөгчтэй утсаар холбогдон, удаа дараа өр барагдуулаагүй тохиолдолд данс битүүмжлэх ажиллагаа хийхийг сануулан ажиллаж байна. Мөн ХТМТ /3, 4/-р түвшний өртэй 424 татвар төлөгчид өрөө төлөх тухай гэрээт байгууллагаар "САНУУЛАХ" масс мессеж хүргүүлсэн. Татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд олон нийтэд цацагдаж байгаа мэдээ мэдээллийг хуваалцаж, хэлтсийн албан хаагчдаар тухай бүр түгээлгэж байгаа. Мөн ХХОАТ-н тайлан, АТБӨЯХАТ-аа төлөх тухай, Газрын төлбөрийн тухай 10 рийл, 3 постер бэлтгэн хэлтсийн фэйсбүүк, пэйж хуудсанд нийтэлсэн. Төсвийн орлогын төлөвлөгөөг сар, өссөн дүнгээрх төлөвлөгөөг биелүүлэхээр өртэй татвар төлөгчдийг өрийн үлдэгдлийн интервалаар ангилан татварын хэлтсийн нийт албан хаагчдад хуваарилан өгч өр хураах ажиллагааг шат дараатай хэрэгжүүлэн ажиллаж байна. ААНОАТ, ХХОАТ, НӨТУС АТБӨЯХАТ-ын тухай хууль болон татварын бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой 217 удаагийн мэдээ мэдээлэл, постер 24 удаагийн Хялбаршуулсан горим ашиглах зөвлөмж, Галт зэвсгийн албан татвар төлөгч иргэдэд зориулсан, Газар эзэмшигч иргэдэд зориулсан гэх мэт контентыг бэлтгэн хэлтсийн цахим хуудаст байршуулан татвар төлөгчдөд зөвлөгөө, мэдээлэл хүргүүлсэн. Хууль тогтоомж мөрдөлтийн II, III, IV /62518 татвар төлөгч/ түвшний татвар төлөгчдөд татвар хураах үйл ажиллагааг шат дараалан хэрэгжүүлэхээр Татварын ерөнхий хуулийн 55.2-д заасны дагуу 17559 татвар төлөгчид Татварын удирдлагын нэгдсэн системээр өрийн нэхэмжлэхийг хүргүүлсэн.<br>Мөн Татварын ерөнхий хуулийн 63.1.1-д заасны дагуу ХТМТ-II, III, IV хамаарах татварын өрөнд 2237 татвар төлөгчийн банкин дахь харилцах дансыг үл маргах журмаар битүүмжилж, нийтлэг үйл ажиллагааг хэрэгжүүлэв.<br>Харилцах данс хаасан-2237 татвар төлөгчид 279.3 тэрбум төгрөгийн татварын өрөнд харилцах дансны барилт хийсэн байна. | 100% | СТСХ | Татвар | 90% |
| 3.1.6 Төсвийн төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэлд тавих хяналтад төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, ил тод, нээлттэй байдлыг хангаж, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлнэ. | 97 | 3.1.6.1 Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг сайжруулж, орон нутгийн төсвийн биеэ даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулж, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэлд тавих хяналтад төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн ил тод, нээлттэй байдлыг хангах | 2025-2028 | - | Орон нутгийн төсөв | | Хувь | 100% | 100% | - | - | Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд сар бүрийн 08-ны өдрийн дотор Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн нэгдсэн мэдээ зэрэг хугацаат мэдээллийг сар, улирлын байдлаар www.shilendans.gov.mn цахим хуудсанд тухай бүр байршуулж мэдээлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100% | СТСХ | | 100% |
| | 98 | 3.1.6.2 Монгол Улсын татварын тухай болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлэх талаар дэмжиж ажиллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | | Хувь | 99% | 100% | - | - | Монгол улсын татварын тухай хууль бусад ажлын хүрээнд:<br>- “Татварын 50 хором” сэдэвт нэвтрүүлэг, шинээр бүртгэгдсэн аж ахуйн нэгж байгууллагуудад татвар төлөгчийн бүртгэл, цахим системд нэвтрэх, тоон гарын үсгийн хэрэглээ, татвар төлөх, тайлагнах, анхан шатны мэдлэг олгох зорилгоор “ZOOM” meeting-ээр 6 удаагийн сургалтад 169 татвар төлөгчийг хамруулсан.<br>- Хууль тогтоомжид орж буй нэмэлт өөрчлөлттэй холбоотой сургалтыг танхим болон цахимаар зохион байгуулах, тайланг гаргах сургалтыг 57 удаа зохион байгуулж 32 аж ахуйн нэгж, 5574 бизнес эрхлэгч хамруулсан.<br>- Төлбөрийн баримт олгодоггүй 2243 бизнес эрхлэгчдэд Татварын ерөнхий хууль, НӨАТ-ын хэрэгжилтийн талаарх дүрэм журам танилцуулах, мөн давхардсан тоогоор нийт 7200 татвар төлөгч бизнес эрхлэгчдэд нийт 10 мянга гаруй гарын авлага, брошур, тараах материалуудыг тараан ажилласан.<br>Цахимаар ирүүлсэн 20,871 тайланг хүлээн авч 100 хувь шийдвэрлэсэн Татвар төлөгчдөд зориулсан мэдээлэл 118, видео контент 65, сургалт 34 зохион байгууллаа.<br>- Жижиг сегментийн 4435, бичил сегментийн 18,720, иргэн 105,153 татвар төлөгчдөд цахимаар үйлчилгээ үзүүлж, хэлтсийн пэйж хуудас болон zoom, танхимын сургалтыг хүргэж, 2308 иргэний 2,9 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийн материал, 418 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 6,6 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийн материалыг цахимаар хүлээн авч ажилласан. | 100% | СТСХ | Татвар | 100% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.7 Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд хэмнэлттэй, хариуцлагатай, ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай зохион байгуулж ажиллана. | 99 | 3.1.7.1 Улс, Нийслэлийн төсөв, орон нутаг болон дүүргийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ашиглан хуулийн хүрээнд хэмнэлттэй, хариуцлагатай, ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай зохион байгуулж ажиллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Улс, нийслэл, дүүрэг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө | | Хувь | 90% | 100% | - | - | Дүүргийн Худалдан авах ажиллагааны Улс, Нийслэлийн төсөв, орон нутаг болон дүүргийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлж буй нийт 230 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 2025 онд хэрэгжүүлж гэрээ байгуулсан 167 , 2024-2025 он дамжин санхүүжигдэж байгаа 28, ажлын тоо хэмжээ ирээгүй 28, тендер хүлээн авч байгаа 2, , ажлын тоо хэмжээ хянуулахаар 7(тендер шалгаруулалт амжилтгүй болж буцаасан ТГУХэлтэсрүү) , эрх шилжүүлсэн буюу Юнеско болон Чингэлтэй дүүргийн ХОББДТөв рүү шилжүүлсэн 2 төсөл, арга хэмжээ байна.<br>Мөн нийт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд 26 гомдол ирснээс Сангийн яаманд 19, Монополын эсрэг газарт 7 байна. 26 гомдлын 17 гомдлыг хэмнэлтийн тухай хуулийг үндэслэн буцаасан. Нийт гомдлоос үндэслэлгүй гомдол 1, үндэслэлтэй гомдол 8 байснаас 1 гомдлын дагуу үнэлгээний хороо дахин хуралдаж шалгарагчийг өөрчилсөн, 7 гомдлын ТББ-г өөрчлөн үргэлжлүүлэн нийтэлж зохион байгуулсан болно. | 100% | ХААА | | 100% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 693,488.70 | 550,722.42 | | | | | |
| ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦ | | | | | | | | | | | | | | | | |
| 3.2. Үйлдвэрлэл, инновац, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжинэ. | | | | | | | | | | | | | | | | |
| 3.2.1 Гарааны бизнес эрхлэгч, инновац, судалгаа хөгжүүлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлж, бодлогоор дэмжинэ. | 100 | 3.2.1.1 Шилдэг Стартап залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох уралдааныг зохион байгуулж, хамрагдах залуучуудыг үе шаттай модуль сургалтыг зохион байгуулна. | 2025-2028 | 200.0 | ХЭДСан | Дэмжлэг олгосон стартап | Тоо | 50 | 60 | 50.00 | 50.00 | Дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран үйлдвэрлэл эрхлэгчдэд "Төсөл бичих аргачлал", "Төслийн санхүү"-н сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 01, 02-ны өдрүүдэд 30 үйлдвэр эрхлэгч хамруулснаас 27 үйлдвэр эрхлэгч төслөө өгч хамгаалсан үр дүнтэй байна. | 100% | ХХҮХ | ЖДҮДТ | 70% |
| 3.2.2 Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, зорилтот салбаруудад чиглүүлэх, бараа бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлд нийлүүлэх боломжийг нэмэгдүүлнэ. | 101 | 3.2.2.1 Дүүргийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дотоод гадаадын үзэсгэлэн худалдаанд хамруулан борлуулалтын орлогыг нэмэгдүүлэн ажиллана. | 2025-2028 | 80.0 | Дүүргийн төсөв | Үзэсгэлэн худалдаанд хамруулсан ЖДҮ эрхлэгчид | Тоо | 1500 | 1500 | 20.00 | 20.00 | Тайлант хугацаанд Дүүргийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дотоодод зохион байгуулагдсан 14 удаагийн үзэсгэлэн худалдаанд 347 үйлдвэр эрхлэгчдийг хамруулж, 1,164,264,000 төгрөгний борлуулалттай байсан бол гадаадад зохион байгуулагдсан 2 удаагийн үзэсгэлэн худалдаанд 15 үйлдвэр эрхлэгчдийн хамруулан 116,188,000 төгрөгний борлуулалттай ажилласан. | 100% | ХХҮХ | ЖДҮДТ | 100% |
| 3.2.3 Бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтыг бодлогоор дэмжиж, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээг төрийн худалдан авах ажиллагаанд оруулах ажлыг шат дараатай зохион байгуулна. | 102 | 3.2.3.1 Дүүргийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг худалдан авах ажиллагаанд оролцоход нь дэмжлэг үзүүлж, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэн ажиллана. | 2025-2028 | 20.0 | Дүүргийн төсөв | Хамрагдсан ЖДҮ эрхлэгчид | Тоо | 10 | 10 | 5.00 | 5.00 | Тус арга хэмжээ нь тайлант хугацаанд хэрэгжиж эхлээгүй байна. 2026 оны төлөвлөгөөнд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүнээр каталог гарган төрийн худалдан авах ажиллагаанд оролцуулахаар төлөвлөсөн. | 0% | ХХҮХ | ЖДҮДТ | 0% |
| 3.2.4 Олон улсын сайн туршлага, экспортод гаргах нөөц бололцоо, санхүүгийн байгууллагуудын эрэлт хэрэгцээг тодорхойлсон мэдээллийн санг бүрдүүлж, төрөлжсөн сургалт, бизнесийн зөвлөх үйлчилгээний ажлыг зохион байгуулна. | 103 | 3.2.4.1 Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг шинэчилсэн судалгаанд хамруулж, тухай бүр баяжилт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээллээр хангаж, цахим мэдээллийн нэгдсэн санд бүртгэж ажилласан байна. | 2025-2028 | 160.0 | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 96 | 100 | 40.00 | 40.00 | Байгууллагад бүртгэлтэй үйлдвэр эрхлэгчдээс 2025 оны жилийн эцсээр үйл ажиллагаагаа зогсоосон болон бусад дүүрэгт шилжсэн шалтгаанаар 14 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг мэдээллийн сангаас хасч, шинээр 93 үйлдвэр эрхлэгч бүртгүүлсэн. Мэдээллийн нэгдсэн санд оёдлын чиглэлээр-522, гутлын чиглэлээр-85, модон эдлэл-122, төмөр хийц-39, арьсан чиглэлийн-36, сүлжмэл эдлэлийн чиглэлээр-48, эсгий эдлэлийн-46, бэлэг дурсгалын-16, бусад чиглэлийн-137, нийт 1051 үйлдвэр эрхлэгч бүртгэлтэй байна. | 100% | ХХҮХ | ЖДҮДТ | 100% |
| 3.2.5 Жижиг, дунд үйлдвэр, өрхийн үйлдвэрлэгчдийн тодорхой салбарыг кластераар хөгжүүлнэ. | 104 | 3.2.5.1 Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч, өрхийн үйлдвэрлэгчдийн кластераар хөгжих боломжийг бүрдүүлж, дэмжих үйл ажиллагаа зохион байгуулна. | 2025-2028 | 120.0 | Дүүргийн төсөв | Кластераар хөгжих боломж | Хувь | 50 | 100 | 30.00 | 30.00 | "Гутлын эрүүл ахуйн шинж чанар, бүтэц зохион байгуулалт, технологийн тухай ойлголт" сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр ЖДҮДТ-ийн сургалтын танхимд зохион байгуулж 22 үйлдвэр эрхлэгчдийг хамруулсан. "Өөрсдөө Урлая" сэдэвт иргэдэд нээлттэй сургалтыг зохион байгуулж, 24 иргэнийг хамруулсан байна. | 100% | ХХҮХ | ЖДҮДТ | 100% |
| 3.2.6 Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд худалдан борлуулах боломжийг бий болгох чиглэлээр "Чингэлтэйд үйлдвэрлэв-2028" арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ. | 105 | 3.2.6.1 "Чингэлтэйд үйлдвэрлэв-2028" арга хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | 200.0 | Дүүргийн төсөв | Хөтөлбөрийн хэрэгжилт | Хувь | 96.4 | 25 | 50.00 | 50.00 | Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлчдийн Хурлын 2025 оны 03 дгаар сарын 28-ний өдрийн 08 дугаар тогтоолоор 'Чингэлтэйд үйлдвэрлэв-2028" арга хэмжээг батлуулсан хөтөлбөрийн хүрээнд 4 зорилтын хүрээнд 10 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100% | ХХҮХ | ЖДҮДТ | 84% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 195.00 | 195.00 | | | | | |
| ХҮНС ХУДАЛДАА, ҮЙЛДВЭР ҮЙЛЧИЛГЭЭ | | | | | | | | | | | | | | | | |
| 3.3 Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлж, хүнсний бүтээгдэхүүний бүх үе шатанд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах хяналтыг сайжруулж, дүүргийн хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангана. | | | | | | | | | | | | | | | | |
| 3.3.1 "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж, иргэдийг чанартай, эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангана. | 106 | 3.3.1.1 "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд Сар шинийн баярт зориулсан сүү, сүүн бүтээгдэхүүний өртөгтгөсөн худалдаа, төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдааг зохион байгуулж, аймаг, сумдын малчин, ногоочин иргэдийн хамруулан ажиллана. | 2025-2028 | 8.0 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагаа | Тоо | 2 | 2 | 2.0 | | Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн "Сар шинийн мэнд 2025" өргөтгөсөн худалдаа зохион байгуулах тухай А/05 дуаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн Менежерийн 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр "Сар шинийн баярт зориулсан өргөтгөсөн худалдаа зохион байгуулж, хяналт тавих тухай" удирдамж батлагдсан. Удирдамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд аймаг, сумдын 80 малчин болон дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 6 хүнсний үйлдвэр эрхлэгч нарыг хамруулсан мах, сүү, цагаан идээ болон бусад хүнсний бүтээгдэхүүний өргөтгөсөн худалдааг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 02 дугаар сарын 25-ны өдрүүдэд Тусгаар тогтнолын талбайд зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаагаар 855,350,000 (найман зуун тавин тав сая гурван зуун тавин мянга) төгрөгийн борлуулалт хийсэн байна. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн "Сар шинийн мэнд 2025" өргөтгөсөн худалдаа зохион байгуулах тухай А/05 дуаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн Менежерийн 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр "Сар шинийн баярт зориулсан өргөтгөсөн худалдаа зохион байгуулж, хяналт тавих тухай" удирдамж батлагдсан. Удирдамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд аймаг, сумдын 80 малчин болон дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 6 хүнсний үйлдвэр эрхлэгч нарыг хамруулсан мах, сүү, цагаан идээ болон бусад хүнсний бүтээгдэхүүний өргөтгөсөн худалдааг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 02 дугаар сарын 25-ны өдрүүдэд Тусгаар тогтнолын талбайд зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаагаар 855,350,000 (найман зуун тавин тав сая гурван зуун тавин мянга) төгрөгийн борлуулалт хийсэн байна. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны А/104 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Бөмбөгөр худалдааны төвийн гадна талбайд 9 асар мөн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах "Барилгачдын талбай"-д 16 асрыг тус тус байршуулан төмс, хүнсний ногооны үзэсгэлэн худалдааг 2025 оны 08 дугаар сарын 06-наас 09 дүгээр сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаагаар 8.224 кг хүнсний ногоо худалдаалагдаж нийт 43 сая 596 төгрөгийн борлуулалт хийгдсэн байна. | 100% | ХХҮХ | НХХААГ | 100% |
| 3.3.2 Хүнсний ногоо, жимс жимсгэнэ хадгалах ахуйн зориулалттай загвар зоорийг төр-хувийн хэвшлийн түншлэлийг түшиглэн нийтийн эзэмшлийн газарт байгуулна. | 107 | 3.3.2.1 Жимс, хүнсний ногоо хадгалах ахуйн зориулалттай зоорь барих боломжит байршлыг судлан, загвар зоорийг төр-хувийн хэвшлийн түншлэлийг түшиглэн нийтийн эзэмшлийн газарт байгуулна. | 2025-2028 | 160.0 | Дүүргийн төсөв | Зоорь | Тоо | 0 | 1 | 10.0 | | Жимс, хүнсний ногоо хадгалах ахуйн зориулалттай зоорь барих боломжит байршлын судалгааг төр, хувийн хэвшилтэй хамтран гаргуулахаар ажиллаж байна. | 100% | ХХҮХ | НХХААГ, НМЭГ | 30% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.3 Мал, амьтны гоц халдварт шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандалт-шинжилгээ хийх, оношлох ажлыг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ. | 108 | 3.3.3.1 Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Гэрийн тэжээвэр амьтдын тооллогыг зохион байгуулж, ариутгал хийж вакцинд хамруулна. | 2025-2028 | 16.0 | Дүүргийн төсөв | Ариутгал хийсэн талбайн хэмжээ | м2 | 1500 | 1500 | 4.00 | 9.00 | Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь Нийслэлийн Мал эмнэлгийн газар, мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлдэг "Сод хан эмнэлэг"-тэй Дүүргийн нутаг дэвсгэрт мал амьтны гоц халдварт болон халдварт өвчин гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор жил бүр гурвалсан гэрээ байгуулан хамтран ажилладаг. Үүний хүрээнд хорогдсон мал амьтны сэг зэмийг цуглуулж устгах, зоорь, агуулах, цех, хүнсний зах, худалдааны төвүүдэд ариутгал, халдваргүйтлийн ажлыг хийсэн. Мөн мал хадгалах зоорь, агуулах, лангууны орчин (850 м2), мах ангилан хадгалах байр, бууз, баншны цех (1210 м2), дайвар бүтээгдэхүүн худалдаалах цэг, толгой шийр хуйхлах цэг (445 м2), мал амьтны түүхий эдийн хаягдал сэг зэм (700 м2), нийтий эзэмшлийн талбай буюу нийт 3205 м2 талбайд ариутгал, халдваргүйтлийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна. | 100% | ХХҮХ | Статистикийн хэлтэс, Дүүргийн Мал эмнэлэгийн "Содхон" ХХК | 100% |
| 3.3.4 Хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулна. | 109 | 3.3.4.1 Хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжид хяналт хийж, хэрэгжилтийг хангана. | 2025-2028 | 4.0 | Дүүргийн төсөв | Хяналт шалгалтын ажлын хэрэгжилт | Хувь | 0 | 100 | 1.0 | | Нийслэлийн Хүнс Хөдөө Аж Ахуйн газрын хяналтын хэлтсийн 2025 оны 08 дугаар сарын 14-ны 06/29 дугаар Нийслэлийн эрүүл мэндийн газрын хяналтын хэлтсийн 2025 оны 08 дугаар сарын 14 өдрийн 10-13/ 095 дугаарт хамтарсан хяналт шалгалтын удирдамжийн дагуу 2025 оны 08 сарын 19 өдөр төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг 2 дугаар хороонд байрлах зах, худалдааны төвүүдэд зохион байгуулж ажилласан. | 100% | ХХҮХ | НХХААГ | 100% |
| 3.3.5 Мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд махны техникийн зохицуулалтыг нэвтрүүлнэ. | 110 | 3.3.5.1 Засгийн газрын "Мах махан бүтээгдэхүүний техникийн зохицуулалт батлах тухай" тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийг арга зүйгээр хангаж, хяналт хийж ажиллана. | 2025-2028 | 12.0 | Дүүргийн төсөв | Тогтоолын хэрэгжилт | Хувь | 0 | 100 | 3.0 | | Нийслэлийн Засаг даргын А/116 дугаартай захирамж, дүүргийн Засаг даргын А/14 дүгээр захирамжийн хүрээнд Нийслэлийн мал эмнэлгийн газар, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон Нийслэлийн Цагдаагийн Удирдах газартай хамтран “Мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт”-ыг хангах, хадгалах, нөөцөлж хадгалж буй махны чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, махны тоо хэмжээг тогтоох хяналт шалгалтын ажлыг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй иргэн аж ахуйн нэгж байгууллагуудад 2025 оны 02 дугаар сарын 03-аас 06-ний өдрүүдэд зохион байгуулсан.<br>Мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, махны агуулахын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 15 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахад дараах алдаа дутагдлууд байв. Үүнд:<br>-Мах хадгалах агуулах нь техникийн зохицуулалтад нийцээгүй,<br>-Махны хадгалалт хамгаалалт алдагдсан,<br>-Ажлын байранд шаардагдах бичиг баримт байхгүй,<br>-Ажилчид нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдаагүй зэрэг зөрчил дутагдлуудыг илрүүлж үүрэг чиглэл өгч ажилласан. | 100% | ХХҮХ | НМЭГ | 100% |
| 3.3.6 Хүнсний ногооны хадгалалт, борлуулалт, түгээлтийн сүлжээнд ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг хангуулж, хэрэглэгчдэд чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | 111 | 3.3.6.1 Хүнсний ногооны хадгалалт, борлуулалт, түгээлтийн сүлжээнд ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг хангуулахад хяналт хийнэ. | 2025-2028 | 4.0 | Дүүргийн төсөв | Эрүүл ахуйн шаардлага хангуулсан иргэн, ААН | Тоо | 67 | 70 | 1.0 | | Нийслэлийн Хүнс Хөдөө Аж Ахуйн газрын Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын улсын байцаагчтай хамтран Ерөнхий менежерийн 2025 оны А/104 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Бөмбөгөр худалдааны төвийн гадна талбайд 9 асар мөн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах "Барилгачдын талбай"-д 16 асрыг тус тус байршуулан төмс, хүнсний ногооны үзэсгэлэнд оролцож буй иргэдийн худалдаалж буй төмс, хүнсний ногооноос дээж авч шинжилгээ хийж гарал үслийн гэрчилгээнд хяналтын ажлыг тавиж ажилласан. | 100% | ХХҮХ | НХХААГ | 100% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 21.00 | 9.00 | | | | | |
| **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ** | | | | | | | | | | | | | | | | |
| **3.4 Жуулчдын ая тухтай аялах, зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | | |
| 3.4.1 Жуулчдад зориулсан соёлын болон тусгай сонирхлын аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, аяллын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгоно. | 112 | 3.4.1.1 Зочлох үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд жуулчдад зориулсан монгол ахуйг сурталчилсан өглөөний цай арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана. | 2025-2028 | 8.0 | Дүүргийн төсөв | Зохион байгуулсан арга хэмжээ | Тоо | 0 | 1 | - | - | Төлөвлөгдсөн арга хэмжээг Нийслэлийн аялал жуулчлалын газартай хамтран 2026 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулахаар төлөвлөсөн. | 70% | ХХҮХ | НАЖГ | 30% |
| 3.4.2 Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлал, өрхийн үйлдвэрлэгч нарын төрөлжсөн явуулын үйлчилгээг бий болгож, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллана. | 113 | 3.4.2.1 Өрхийн үйлдвэрлэгч нарын үйл ажиллагааг дэмжин төрөлжсөн явуулын үйлчилгээний цэг бий болгон ажиллана. | 2025-2028 | 60.0 | Дүүргийн төсөв | Явуулын үйлчилгээний цэг | Тоо | 15 | 2 | - | - | Дүүргийн иргэдийг дэмжих зорилгоор улирлын чанартай түр, сүүдрэвчтэй худалдаа, үйлчилгээ болон явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах хүсэлтийг хүлээн авч дүүргийн Засаг даргын 2025 оны 06 сарын 16-ны өдрийн дугаар А/221 захирамж батлагдсан. Захимрамжийн хүрээнд 1-24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 15 байршилд түргэн хоолны үйлчилгээ, 32 цэгт түр сүүдрэвчтэй худалдаа, үйлчилгээг дэмжин ажилласан. | 100% | ХХҮХ | Дүүргийн ЖДҮДТ | 100% |
| 3.4.3 Чингэлтэй хайрхан, Зүрх уулыг түшиглэн иргэдийн алхах, ая тухтай амарч зугаалах, аялал жуулчлалын орчин нөхцөлийг бүрдүүлнэ. | 114 | 3.4.3.1 Төр хувийн хэвшлэлийн түншлэлээр Хайрхан хөгжлийн төв УТҮГ түшиглэн залуучуудын сонирхол "Extreme sport" болох "Zip line"-ийг үйлчилгээг нэвтрүүлнэ. | 2025-2028 | 400.0 | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 0 | 100 | - | - | Чингэлтэй дүүргийн 2025 оны төсөвт суугдаагүй тул санхүүжилт шийдэгдээгүй. 2026 оны төсөвт санхүүжилтийг тусгахаар саналыг хүргүүлсэн. 2025 онд Good neibors олон улсын байгууллагын дэмжилгээр 500м явган хүний зам хийсэн. | 100% | НХХ | Хайрхан хөгжлийн төв УТҮГ, хороо | 30% |
| | 115 | 3.4.3.2 Чингэлтэй хайрхан, Зүрх уулыг түшиглэн иргэдийн цэвэр агаарт амарч, алхалт хийхэд тохиромжтой зам байгуулж, орчныг сайжруулна. | 2025-2028 | 3,868.0 | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 0 | 100 | 3,868.00 | - | Иргэдийн цэвэр агаарт амарч зугаалах боломжийг бүрдүүлэх зорилгоор Чингэлтэй эцсийн буудлаас Зүрх уулын фитнес хүртэлх авто зам, гэрэлтүүлгийн ажил (23 дугаар хороо)-ыг дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжилтийг шийдвэрлэн авто замын багц дээр "Нано экологи" ХХК, гэрэлтүүлгийн багц дээр "Ньюглобал" ХХК шалгаран 2025 оны 10 дугаар сарын 31-нээс 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. /Санхүүжилт 2026 онд он дамжин хийгдэнэ./ | 30% | ТГУХ | ХХҮХ | 30% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 3,868.00 | | | | | | |
| **ДӨРӨВ: НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | | | | | |
| **БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ НӨХӨН СЭРГЭЭЛТ** | | | | | | | | | | | | | | | | |
| **4.1 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги төлөвлөгөө, “Улаанбаатар хотын цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөө”-тэй уялдуулан нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | | |
| 4.1.1 Айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хашаандаа мод тарих, ногоон байгууламж байгуулах санал санаачилгыг дэмжин урамшуулж, иргэд, хувийн хэвшлийн оролцоотойгоор ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ. | 116 | 4.1.1.1 Мод тарих үндэсний хөдөлгөөнийг үргэлжлүүлж хавар намрын мод тарилтын аянд айл өрхүүдийг хамруулж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ. | 2025-2028 | 0 | Дүүргийн төсөв | Нэмэгдүүлсэн ногоон байгууламжийн хэмжээ | м2 | 0 | 500 | 225.08 | 225.08 | Гэр хорооллын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр 615 өрх хашаандаа 3415 ширхэг мод тарьж, 6830м2 ногоон байгууламж нэмэгдүүлсэн. Арчилгааны талаар Зөвлөх эрдэмтэн Монгол улсын Байгаль орчны гавьяат ажилтан, Академич, Биологийн ухааны доктор (Ph.d) Б.Чимэд нийт 5 удаагийн сургалт, заавар зөвлөмж өгч ажилласан ба ойжуулагч, цэцэрлэгчнээр 2 сургагч багш бэлтгэж ажилласан. | 100% | ХСТНААХ | Төр, хувийн хэвшил | 100% |
| 4.1.2 Хотын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, өнгө үзэмжийг сайжруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 117 | 4.1.2.1 Дүүргийн 1-6 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, өнгө үзэмжийг сайжруулах, нөхөн тарилт хийх ажлыг жил бүр үе шаттай хэрэгжүүлнэ. | 2025-2028 | 0 | Дүүргийн төсөв | Нэмэгдүүлсэн ногоон байгууламжийн хэмжээ | м2 | 160,000 | 164,000 | 469.83 | 469.83 | Хотын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, өнгө үзэмжийг сайжруулах чиглэлээр нийт 4 байршилд 4085м2 ногоон байгууламжийг нэмэгдүүлэн ажилласан. Үүнд:<br>1. Энхтайваны өргөн чөлөө, Цэцэг төвийн уулзвараас Баруун дөрвөн замын уулзвар хүртэлх 1,3 км үргэлжлэх 11 сектор бүхий авто зам дагуух 1385м2 карма зогсоолуудыг хааж тохижуулан нийт 2400 м2 зүлэг, нарс 66 ширхэг, гацуур 53 ширхэг, хайлаас 9960 ширхэг буюу 664 у/м ургамлан хашлага тарьсан.<br>2. 5 дугаар хороо, Оранж төвийн урд талд 1300м2 талбайд 30 ширхэг нарс, 3700 ширхэг хайлаас тарьж тохижуулсан.<br>3. 5 дугаар хороо, Гэсэр сүмийн баруун талаас Сити авто сервис хүртэл 900м2 талбайд 180м2 зүлэг 30 ширхэг гацуур тарьсан.<br>4. 2 дугаар хороо, баруун 4 замын уулзварын хойд талын 500м2 талбайд 30 ширэг агч мод, 30 ширхэг голт бор, 1500 ширхэг нэг наст мандлын цэцэг тус тус тарьсан. | 100% | ХСТНААХ | Төр, хувийн хэвшил | 30% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.3 Хүүхэд залуучууд, ахмад настнуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх бичил цэцэрлэгт хүрээлэнг хороо бүрд шинээр байгуулна. | 118 | 4.1.3.1 Бичил цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэнг үе шаттайгаар шинээр бий болгон нэмэгдүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Шинээр байгуулсан бичил цэцэрлэгт хүрээлэн | Тоо | 83 | 3 | 49.40 | 49.40 | Тус дүүргийн 5 дугаар хороо, Оранж төвийн урд талд 30 ширхэг нарс, 3700 ширхэг хайлаас, 2 дугаар хороо, Баруун 4 замын уулзварын хойд талд 30 ширхэг агч, 30 ширхэг голт бор, 1500 ширхэг нэг наст мандлын цэцэг тарьж тус тус бичил цэцэрлэг шинээр бий болгосон.<br>Мөн 9 дүгээр хороо, Баянбүрдийн тойргийн баруун хойд талын шороон талбайг тохижуулж 3500 ширхэг хайлаас, 30 ширхэг гацуур, 30 ширхэг агч, 15 ширхэг нарс мод тарьж, 180 м2 талбайг зүлэгжүүлэн бичил цэцэрлэгт хүрээлэн шинээр бий болгож арчилгааны ажлын төсвийг 2026 оны төсвийн төсөлд тусгуулахаар санал хүргүүлсэн. | 100% | ХСТНААХ | ТГУХ | 90% |
| 4.1.4 Дүүргийн иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, эрүүл, аюулгүй, эрсдэлгүй, тав тухтай орчныг бүрдүүлэх чиглэлээр "Тохижилттой (Тохилог) Чингэлтэй-2028" арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ. | 119 | 4.1.4.1 Иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулж ногоон байгууламж, тохижилтын ажлыг үе шаттай нэмэгдүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 100 | 25 | 974.00 | 974.00 | Дүүргийн 1 дүгээр хороо, Монтел худалдааны төвийн зөвшөөрөлгүй өргөтгөлийн барилга болон бетонон хашааг буулгаж, газар чөлөөлсөн байршилд тохижилтын ажлыг дүүргийн төсвийн хөрөнгөөр Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨААТҮГ-аар хийж гүйцэтгүүлэн автомашингүй гудамж болгон тохижуулсан.<br>Мөн 3 дугаар хороо, Улсын их дэлгүүрийн зүүн хойд талын зөвшөөрөлгүй үйлчилгээний цэгүүдийг буулгаж, газар чөлөөлсөн байршилд явган хүний байгалийн чулуун зам болон тохижилтын ажлыг дүүргийн төсвийн хөрөнгөөр Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨААТҮГ-аар хийж гүйцэтгүүлсэн.<br>Улсын төсвийн хөрөнгөөр дүүргийн 13, 15, 24-р хороо, Гэр хорооллын бүсийн 3 байршилд 3х3 сагсан бөмбөгийн стандарт талбай, хүүхдийн тоглоом, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж бүхий иргэд, хүүхэд, ахмадуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх талбай шинээр бий болгон ажилласан. | 100% | ТНААХ | ТГУХ | 84% |
| 4.1.5 Байгаль орчноо хамгаалах, хүрээлэн буй орчинд ээлтэй иргэн бий болгох чиглэлээр хүүхэд, багачууд, өсвөр үе, залуучуудад чиглэсэн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулна. | 120 | 4.1.5.1 ЕБС-ын сурагчид болон залуучуудад чиглэсэн байгальд ээлтэй иргэн байх тухай сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Сургалт, нөлөөллийн ажил | Тоо | 0 | 2 | - | - | "Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн", 2025 оны хавар болон намрын улирлын бүх нийтээр мод тарих, арчлах арга хэмжээтэй уялдуулан дүүргийн төрийн өмчийн сургууль, цэцэрлэгүүд болон хашаандаа мод тарьдаг өрхэд экологийн боловсрол олгох чиглэлээр Зөвлөх эрдэмтэн Монгол улсын Байгаль орчны гавьяат ажилтан, Академич, биологийн ухааны доктор нийт 5 удаагийн сургалт, заавар зөвлөмж өгч ажилласан. Энэхүү сургалтаар тарьц суулгац тарьж ургуулах, усалгаа болон бусад арчилгааны ажлын талаар мэдлэг олгож гэр хорооллын 25 өрхөд 4 төрлийн 1300 ширхэг модны тарьц өгсөн . | 100% | ХСТНААХ | НХХ | 30% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 1,718.3 | 1,718.3 | | | | | |
| **ХӨРСНИЙ БОХИРДОЛ, ХОГ ХАЯГДАЛ** | | | | | | | | | | | | | | | | |
| **4.2 Хөрсний бохирдлыг бууруулах ажлыг цогц хэлбэрээр авч хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | | |
| 4.2.1 Хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд нүхэн жорлонгийн тоог багасгах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. | 121 | 4.2.1.1 Дүүргийн гэр хорооллын 7-24 дүгээр хороодын нийт нүхэн жорлонгийн тоо хэмжээг бууруулах, сайжруулах чиглэлээр Улс, нийслэлээс хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээг зохион байгуулан ажиллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Улсын төсөв | Бууруулсан нүхэн жорлон | Тоо | 80,000 | 1,000 | 6,500.00 | 6,131.00 | Гэр хорооллын айл өрхийн жорлон, бохирын цооногийг буулгах ажлын хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төсвөөр дүүргийн 16 дугаар хорооны Согоотын 28-40 дүгээр гудамжны 222 айл өрхийг цэвэр бохир усны инженерийн шугам хоолойд холбох ажлыг хэрэгжүүлж эхлээд байна. Ажлын гүйцэтгэгчээр Хүрд ХХК шалгарч ажлын явц 30 хувьтай хэрэгжиж байна. Тус ажил нь 2027 он хүртэл хэрэгжих бөгөөд төсөл хэрэгжсэнээр гэр хорооллын 222 нүхэн жорлон, 222 бохирын цооног буух юм.<br>Сэлбэ дэд төвийн дахин төлөвлөлтийн хүрээнд газар чөлөөлөлт хийгдсэн 1683 нэгж талбарт барилгын түр хашаа босгож, 1067 нэгж талбарын үлдсэн жорлон, бохирын цооногийг буулгаж, ариутгал хийсэн. | 100% | ХСТНААХ | Улс, нийслэл, | 30% |
| 4.2.2 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн бохирдол ихтэй байршлуудад ариутгал халдваргүйтгэлийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 122 | 4.2.2.1 Гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлонг, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн бохирдол ихтэй байршил, шар усны үерийн дараах болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулан мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлнэ. | 2025-2028 | 800.0 | Дүүргийн төсөв, Засаг даргын нөөц хөрөнгө | Ариутгал, халдваргүйтэл хийсэн талбайн хэмжээ | м2 | 0 | | 200.00 | 137.00 | Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, явган хүний зам, автобусны буудал, хогийн сав, түц нүүлгэсэн, хашаа хайс буулгасан бохирдол ихтэй байршлуудад нийт 66,034 м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийн ажлыг сард 1-2 удаа хийж байна. Мөн бүх нийтийн их цэвэрлэгээний ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 10-13-ны өдрүүд, 08 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд Би Би грийн роус ХХК-тай гэрээ байгуулан 127,565 м2 гудамж, явган хүний зам, автозамын хашлага, нийтийн эзэмшлийн талбай, 2034 м2 талбай бүхий 20 ширхэг ил задгай хогийн сав, 1200 м2 талбай бүхий 12 ширхэг ТҮЦ, 12,800 м2 талбай бүхий хуучин барилгын суурь, замын хажуугийн хогтой талбайд жавелин, хлор агуулсан халдваргүйтгэгчийг усан шахуурга болон гар шүршигч ашиглан хэрэгжүүлсэн.<br>Сэлбэ дэд төвийн дахин төлөвлөлтийн хүрээнд газар чөлөөлөлт хийгдсэн 1683 нэгж талбарт барилгын түр хашаа босгож, 1067 нэгж талбарын үлдсэн жорлон, бохирын цооногт ариутгалын бодис ашиглан ухаж гаргах замаар ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлсэн. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын хяналтаар дүүргийн нутаг дэвсгэр дэх 17 дугаар сургууль орчим, 32-ын тойрог дахь авто засварын газрын ойролцоо, Хүчит шонхор зах орчимд Стандарт хэмжил зүйн газрын нийслэлийн итгэмжлэгдсэн лабораторийн 25-1022, 25-1233 дугаартай сорилын дүнгийн нян судлалын үзүүлэлтээр нитрат зөвшөөрөгдөх дээд хэмжээ 1.7-оос 5.2 дахин их гарсан тул дээрх байршлуудад ойр орчмын газрын хөрс, гэр хорооллын нүхэн жорлон, саарал усны цооногуудад нийтдээ 6259 нүхэн жорлон, 69220 м2 талбайг мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийлгэсэн. | 100% | ХСТНААХ | Хувийн хэшлийн ААНБ | 100% |
| 4.2.3 Хог хаягдал тээвэрлэх, дахин боловсруулах, худалдан авах цогц менежментийг үе шаттай хэрэгжүүлж, өндөр хөгжилтэй орнууд болон орон нутгийн сайн туршлагыг судлан хэрэгжүүлнэ. | 123 | 4.2.3.1 Дүүргийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах ажлыг шаттайгаар нэмэгдүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Төр, хувийн хэвшил | Хэрэгжилт | Хувь | 20 | 30 | - | - | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн 16, 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт нийт 2ш Ногоон булан буюу хог шахагч төхөөрөмжийг суурилуулж, үүсмэл хогийг багасгах, хог ачилтын үр дүнг сайжруулах ажлыг хэрэгжүүлсэн. | 100% | ХСТНААХ | Төр, хувийн хэвшлийн байгууллага | 100% |
| | 124 | 4.2.3.1 Дүүргийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах, ангилсан хог хаягдлыг тээвэрлэх тусгай зориулалтын техник хэрэгслийг нэвтрүүлэх зэрэг парк шинэчлэлтийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Нийслэлийн төсөв | Шинэчлэгдсэн техник хэрэгслийн тоо | Тоо | 130 | 2 | Батлагдсан төсвийн хүрээнд | 600.00 | Дүүргийн гэрээт хог тээврийн гүйцэтгэгч компани Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК нь нийслэлийн төсвийн хөрөнгөөр 7 тусгай зориулалтын техник, автомашин авч парк шинэчлэлт хийсэн. | 100% | ХСТНААХ | Хог тээвэрлэгч байгууллагууд | 100% |
| 4.2.4 "Ухаалаг хогийн сав"-ыг дүүргийн хэмжээнд үе шаттайгаар нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. | 125 | 4.2.4.1 Дүүргийн төвийн хороо болох 1-6 дугаар хороодын байшин хороолол дунд болон гэр хороолол, зуслангийн бүсийн хог тээвэрлэлтийн машин очих боломжгүй өндөрлөг байршил, хог хаягдал ихээр үүсдэг байршлуудад "Ухаалаг хогийн сав"-ыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө | Ухаалаг хогийн сав | Тоо | 4 | 26 | 2,800.00 | 1,500.00 | Төвийн 1-6 дугаар хороодын нутаг дэвсгэрт нийт 8 байршилд 26 ширхэг Ухаалаг хогийн савыг суурилуулах ажлыг зохион байгуулж, 100% хэрэгжүүлсэн. Тус хороодын айл өрхүүдэд чипийг тараан өгч, хог ачилтыг хогийн савнаас ирэх мэдээллийн дагуу ажиллаж эхэлсэн. Мөн дахин дээрх төвийн болон 1,2,3,4,10 хороодод 8 байршилд 24 ширхэг Ухаалаг хогийн савыг суурилуулж 100 хувь хүлээж авсанаар дүүргийн хэмжээнд нийт 50 ширхэг ухаалаг хогийн сав ажиллаж байна. / Үлдэгдэл Санхүүжилт 2026 онд он дамжин хийгдэнэ./ | 100% | ХСТНААХ | Төр, хувийн хэвшлийн байгууллага, Хог тээвэрлэгч байгууллага | 100% |
| 4.2.5 Хог тээвэрлэлтийн давтамжийг нэмэгдүүлж, гэр хорооллын бүсэд шөнийн тээвэрлэлтийг нэвтрүүлнэ. | 126 | 4.2.5.1 Дүүргийн гэр хорооллын 7-24 дүгээр хороодын нутаг дэвсгэрт шөнийн хог тээвэрлэлтийг хороо хэсэг, байршил тус бүрээр гарган үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Шинээр нэмэгдүүлсэн хог тээвэрлэлтийн байршил | Тоо | 87 | 5 | - | - | Дүүргийн гэр хорооллын 7-24 дүгээр хороодын нутаг дэвсгэрт шөнийн хог тээвэрлэлтийг хороо хэсэг, байршил тус бүрээр гарган үе шаттайгаар нэмэгдүүлсэн. | 100% | ТНААХ | Хог тээвэрлэгч байгууллагууд | 70% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.6 Дахин боловсруулсан буюу саарал усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ. | 127 | 4.2.6.1 Дахин боловсруулсан буюу саарал усыг дахин ашиглах үйл ажиллагааг сурталчлан ажиллана. | 2025-2028 | 12.0 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагаа | Тоо | 3 | 4 | - | - | Дүүргийн нутаг нутаг дэвсгэрт авто угаалгын чиглэлээр 28 авто угаалга үйл ажиллагаа явуулж байгаагаас 2 авто угаалга түр хугацаанд ажиллахгүй, 8 авто угаалга зөөврийн ус ашиглаж байна. УСУГ-тай цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээтэй 14 машин угаалга, ОСНААУГ-тай гэрээтэй 1 машин угаалга, цэвэр ус, бохир ус зөөврөөр хэргэлдэг 6 машин угаалга байгаагаас хэрэглэсэн усаа цэвэршүүлэн дахин ашиглах тоног төхөөрөмжтэй 3 машин угаалга үйл ажиллагаа явуулж байна. Дүүргийн 4 дүгээр хорооны "Эко авто" угаалгын саарал усыг дахин ашиглах үйл ажиллагааг сурталчлан ажиллаж байна. | 100% | ХХҮХ | ХСТНААХ, ННТГ | 70% |
| 4.2.7 Аюултай хог хаягдлын талаарх мэдлэг, боловсрол олгох сургалтыг хүүхэд залуучууд, иргэд, аж ахуйн нэгжүүдэд зохион байгуулж, ангилж устгах ажлыг хэрэгжүүлнэ. | 128 | 4.2.7.1 Авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг авто засварын аюултай хог хаягдал нийлүүлдэг байгууллагатай гэрээ байгуулж, аюултай хог хаягдлын стандартыг сурталчлан ажиллана. | 2025-2028 | 24.0 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагаа | Тоо | 0 | 5 | - | - | UCS 1703A:2022 "Аюултай хог хаягдлын менежмент" батлагдсан стандартыг сурталчлах ажлын хүрээнд Нийслэлийн нийтийн тээвэр бодлогын газартай хамтран авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 31 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөлд 2025 оны 09 дүгээр сарын 10-ний өдөр сургалт зохион байгуулав. Тус сургалтаар аюултай хог хаягдлыг ангилах, тээвэрлэх, хадгалах, устгах талаар мэдээлэл өгч ажилласан. | 100% | ХХҮХ | ХСТНААХ, ННТГ | 100% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 1,709.00 | 8,231.00 | | | | | |
| **АГААРЫН БОХИРДОЛ** | | | | | | | | | | | | | | | | |
| **4.3 Агаар, орчин бохирдуулагч эх үүсвэрийг бууруулж, байгальд ээлтэй хэрэглээг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | | |
| 4.3.1 Гэр хорооллын айл өрхийн дулааны хангамжийг бусад эх үүсвэрт (төвлөрсөн дулаан, хий, сэргээгдэх эрчим хүч, цахилгаан болон бусад) үе шаттай шилжүүлэн, хатуу түлшний хэрэглээг бууруулж, амины сууцны дулаан алдагдлыг багасгахад иргэд, олон нийтийн үүрэг оролцоог нэмэгдүүлнэ. | 129 | 4.3.1.1 Гэр хорооллын айл өрхийн амьдарч буй сууцны дулаан алдагдлын шинжилгээг үе шаттай хийлгэж, дулаан алдагдлыг бууруулах зөвлөмж, мэдээлэл өгч, нөлөөллийн аян зохион байгуулна. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Нийслэлийн төсөв | Хамрагдсан айл өрх | Тоо | 100 | 200 | 11,464.00 | 8,024.00 | Нийслэлийн Засаг даргын А/482 дугаар захирамж, НЗД-ын А/1038 захирамж, ЧДЗД-ын А/268, А/270 дугаар захирамжуудаар ЧД-ийн агаарын чанарыг сайжруулах бүсийн 7, 9, 10, 11, 12, 13, 15, 16, 20, 21, 22 дугаар хороодод нийт 2077 байшин сууцны дулаалга 85 хувь, 1001 гэр сууцны дулаалга хийгдэж, 100 хувьтай хэрэгжиж дууссан. | 100% | ХСТНААХ | 7-24 дүгээр хороод | 100% |
| 4.3.2 Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд яндангийн тоог бууруулж, хүлэмжийн хийн ялгаралтыг багасгах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, агаарын бохирдлыг бууруулна. | 130 | 4.3.2.1 Гэр хорооллын айл өрхүүдэд сэргээгдэх эрчим хүчинд түшиглэсэн халаалтын шийдлийг хувийн хэвшил, олон улсын байгууллагатай хамтран үе шаттай хэрэгжүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв, төр, хувийн хэвшил, | Хамрагдсан айл өрх | Тоо | 2 | 50 | - | - | Гэр хорооллын айл өрхүүдэд сэргээгдэх эрчим хүчинд түшиглэсэн халаалтын шийдлийг хувийн хэвшил, олон улсын байгууллагатай хамтран үе шаттай хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн 15, 16, 20, 21, 22 дугаар хороонд Нарны илч төслийг хэрэгжүүлж, НҮБХХ-тэй хамтран гэр хорооллын 80 хүртэлх айл өрхөд сэргээгдэх эрчим хүчинд түшиглэсэн халаалтын төхөөрөмж суурилуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн дүүргийн 16, 17, 22 дугаар хороодод 300 айл өрхөд монгол гэр, байшингийн нүүрс түлдэг зуухыг эрчим хүчний хэмнэлттэй агаар-агаарын дулааны насосоор сольж, байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх "Heat pump" төслийн ажлыг НҮБХХ болон Голомт банктай хамтран хэрэгжүүлсэн. | 100% | ХСТНААХ | НҮБХХ | 100% |
| | 131 | 4.3.2.2 Хатуу түлшний хэрэглээнээс татгалзаж, халаалт, дулаан хангамжийн системд эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагад дэмжлэг үзүүлж, сайн туршлагыг түгээнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Нийслэл, дүүргийн төсөв | Дэвшилтэт технологи нэвтрүүлсэн айл өрх | Тоо | - | 5 | 2,659.00 | 2,659.00 | Хийн түлшний хэрэглээнд шилжих 3815 өрхөд Таван толгой түлш ХХК-аас дэвшилтэт технологи бүхий хийн зуухаар хангах ажлыг НЗДТГ-тай хамтран хэрэгжүүлж, хийн түлшээр хангах, цэнэглэх цэгүүдийг ажиллуулах, түлш борлуулах цэгт ажиллах борлуулагчийг сонгон шалгаруулах, цэгийн байршлыг газар дээр нь тодорхойлж ажиллаж байна. | 100% | НЗДТГ, ЧДЗДТГ | Олон улсын байгууллага төсөл хөтөлбөр | 100% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 14,123.0 | 10,683.0 | | | | | |
| **ТАВ: ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | | | | | | | | | |
| **ЗАСАГЛАЛЫН ШИНЭЧЛЭЛТ** | | | | | | | | | | | | | | | | |
| **5.1. Хүний эрхийг дээдэлсэн, ёс зүйн хэм хэмжээг баримталж, авлигаас ангид, ил тод, үр нөлөөтэй, цахимжсан хариуцлагатай, мэргэшсэн тогтвортой засаглалын бодлогыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | | |
| 5.1.1 Төрийн албаны үйл ажиллагаа, бүтээмж, чанарын удирдлагын нэгдсэн систем, хяналт хариуцлагын тогтолцоог шинэ шатанд гаргаж, төрийн албан хаагчийн ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах зорилгоор "Хүний нөөц, нийгмийн баталгаа-2028" арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ. | 132 | 5.1.1.1 "Хүний нөөц, нийгмийн баталгаа-2028" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | | Дүүргийн төсөв | Хөтөлбөрийн хэрэгжилт | Хувь | 100 | 100 | 255.00 | 231.29 | Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 17 дугаар тогтоолоор "Хүний нөөц, нийгмийн баталгаа-2028" арга хэмжээг баталсан. Тус арга хэмжээ нь хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, ёс зүйн сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилготой ба зорилгын хүрээнд нийт 5 зорилт, 17 арга хэмжээг боловсруулж батлуулсан. Батлагдсан арга хэмжээний хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% | ТЗУХ | ЧДЗДТГ | 84% |
| 5.1.2 Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдын орон сууцыг барьж, ашиглалтад оруулна. | 133 | 5.1.2.1 “Дэнжийн мянга дэд төвийг түшиглэн дүүргийн Ажилчдын орон сууц барих ажлыг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв, төр хувийн хэвшлийн түншлэл | Хэрэгжилт | Хувь | 0 | 10 | 0.0 | | Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 840 айлын ажилчдын орон сууц байгуулахаар дүүргийн 9 дүгээр хорооны газар чөлөөлсөн 2,3 га газар дээр барилгын эх загвар зургийг боловсруулах шатандаа явж байгаа бөгөөд 2026 оны хавар барилгын ажлыг эхлүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. | 50% | ТГУХ | НХОГ | 30% |
| 5.1.3 Ажлын байрны дүн шинжилгээнд үндэслэн тухайн нэгжийн чиг үүрэг, ажилтны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, ажлын давхардал, хийдлийг арилгана. | 134 | 5.1.3.1 Мэргэшлийн зөвлөгч нарын бүрэлдэхүүнтэй мэргэжлийн багаар ажлын байрны дүн шинжилгээ хийлгэж, чиг үүргийн хуваарилалтыг оновчтой болгох ажлыг зохион байгуулна. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 80 | 100 | - | - | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоог шинэчлэн батлахтай холбогдуулан ажлын байрны шинжилгээ хийх, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/105 дугаар тушаалаар байгуулж, ажлын байрны шинжилгээг хийсэн. Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2025 оны 05 дугар сарын 02-ны өдрийн А/143 дугаар захирамжаар Дүүргийн удирдлага, Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталсан. Ажлын байрны шинжилгээнд үндэслэн бүх хэлтсийг ахлах мэргэжилтэнтэй болгож, ажлын ачааллыг бууруулах зорилгоор Төрийн захиргааны удирдлагын хэлтэст Хүний нөөц хариуцсан ажилтны 1 орон тоог, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах тасагт шаардлагатай зураглаачийн орон тоог, Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэст шаардлагатай 2 орон тоог, Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэст шаардлагатай 1 орон тоог, Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст шаардлагатай 1 орон тоог тус тус нэмсэн. Цаашлаад Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Захиргааны зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн болон Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Нийслэл, дүүргийн шуурхайн биелэлт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан хариуцсан мэргэжилтний чиг үүргийн давхардлыг арилгаж, архивын хэлтсийн албан хаагчдын албан тушаалын нэршлийг оновчтой болгож ажилласан. | 100% | ТЗУХ | ТАЗ | 100% |
| | 135 | 5.1.3.2 Ажлын байрны дүн шинжилгээнд үндэслэн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулна. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Бууруулсан давхардал, хийдэл | Хувь | 80 | 20 | - | - | Ажлын байрны шинжилгээ болон батлагдсан бүтцийн дагуу төрийн үйлчилгээний нийт 16 албан тушаалын тодорхойлолтыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны Б/341 дүгээр тушаалаар шинээр болон шинэчлэн баталсан. Бусад төрийн захиргааны холбогдох албан тушаалын тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулж батлуулсан. | 70% | ТЗУХ | ТАЗ | 70% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1.4 Шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, дүүргийн хөгжлийн талаарх үр ашигтай санал, санаачилгыг дэмжиж ажиллана. | 136 | 5.1.4.1 Улс, нийслэл, дүүргийн чанартай асуудлаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хороодын иргэдийн санал санаачилга, оролцоог нэмэгдүүлэхэд хяналт тавьж, хамтран ажиллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Санал, санаачилга гаргаж оролцсон иргэд | Тоо | | | - | | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандсан санал санаачилгыг хүлээн авч шийдвэрлэх цахим тогтолцоог хөгжүүлэх зорилтын хүрээнд NewChingeltei.mn цахим платформ бүрэн ажиллагаанд орсон бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 500 гаруй идэвхтэй хэрэглэгч байна. Иргэдээс нийт 460 гаруй санал, санаачилга ирүүлсэн.Үүнээс:<br>- 150 санал хүсэлтийг хариуцах албан тушаалтанд хуваарилсан<br>- 91 санал хүсэлт шийдвэрлэгдэж буй шатанд<br>- 68 санал хүсэлтийг төлөвлөгөөнд тусгахаар судалж<br>- 150 санал хүсэлтийг бүрэн шийдвэрлэсэн байна.<br>NewChingeltei.mn сайтын үйл ажиллагааг үе шаттайгаар хөгжүүлж иргэдийн санал хүсэлт шийдвэрлэх ажлыг зохион байгуулалтад оруулан хэрэгжүүлж байна. | 100% | ТГУХ | ТЗУХ | 100% |
| | 137 | 5.1.4.2 Хороодын үйл ажиллагаатай холбоотой иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч, судлан шийдвэрлэнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Өргөдөл, гомдол шийдвэрлэлт | Хувь | 100 | 100 | - | - | Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас хороодын үйл ажиллагаа, ажлын цаг ашиглалт, ёс зүйн талаар 6 хүсэлт, 3 талархал, 22 гомдол ирснээс хугацаанд нь 100% шийдвэрлэн программ хангамжаар иргэнд утсаар хариу өгч шийдвэрлэсэн. | 100% | ТЗУХ | НҮНТ | 100% |
| 5.1.5 Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, төр-иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. | 138 | 5.1.5.1 Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, АТГ болон бусад байгууллагуудтай хамтран ажиллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Үйл ажиллагаа | Тоо | 100 | 100 | - | - | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” /2023–2030 он/-ийг баритлан 2025 оны "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Авлигатай тэмцэх газрын "Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтэс"-тэй хамтран авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр Засаг даргын дэргэдэх харьяа байгууллагуудын албан хаагч нарт ***“Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь*** " сэдэвт сургалтыг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулсан.  Тус сургалтаар авлигын нийгэмд учруулах хор хөнөөл, авлига өгөх, авах гэмт хэргийн талаарх мэдээлэл өгч, авлигын эсрэг эрх зүйн актууд, албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт, төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, түргэн шуурхай хүргэхдээ авлигын нөхцөл байдал үүсгэх нөхцөл байдал гаргахгүй байх талаар мэдээлэл өгөх сургалтад 65 албан хаагчийг хамруулсан. Боловсролын хэлтэстэй хамтран хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан сургуулийн өмнөх боловсролын байгууллагын удирдлага нарт холбогдох хуульд заасны дагуу хамран сургах бус тойргийн хүүхдүүдийг элсүүлэх, элсүүлэхээр ирүүлсэн хүсэлтийг нягтлах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж ажиллах талаар чиглүүлэх сургалт, олон нийтийн мэдээллийн 2 ажлыг зохион байгуулсан. | 100% | ХЭЗХ | ЧДЗДТГ | 100% |
| 5.1.6 Засаг захиргааны анхан шатны нэгжийн үйл ажиллагаанд засаглалын шинэ хэлбэрийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэнэ. | 139 | 5.1.6.1 Төрийн хууль тогтоомж, бодлого, шийдвэр, Засгийн газар, Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг анхан шатны нэгжид хэрэгжүүлэн, "20 минутын хот" бодлогын бэлтгэл ажлыг хангуулан ажиллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Улс, нийслэл, дүүргийн төсөв | Үйл ажиллагаа | Хувь | 0 | 10 | - | - | Засгийн газар, Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга удирдан 1-24 дүгээр хороодын “Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөн”-ийг  цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан 8 удаа танхимаар, 23 удаа цахимаар /zoom/ зохион байгуулж давхардсан тоогоор 552 албан хаагчид оролцож хурлаас гарсан санал, хүсэлт, өгсөн үүрэг даалгаврын биелэлт, тайлан илтгэх хуудсыг тухай бүр хүлээн авч нэгтгэн Нийслэлийн холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласан. "20 минутын хот" бодлогоын хүрээнд 2025 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр байгууллагын бүтэц, орон тооны судалгаа, албан тушаалын ангилал, зэрэглэл, шаардлагатай техник хэрэгслийн судалгааг гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, дүүргийн 14, 18 дугаар хороонд “Сэлбэ 20 минутын хот” төслийг 2025 оны оны 05 дугаар сарын 29-өөс эхлэн хэрэгжүүлсэн.  Сэлбэ дэд төвийн газар чөлөөлөлт 90 гаруй хувьтай үргэлжилж газар чөлөөлсөн иргэдийн хашаа байшинг буулгах, барилгын үлдэгдэл хог хаягдлыг цэвэрлэх ажлууд шат дараатай хийгдэж байна.□ | 70% | ТЗУХ | ТГУХ | 70% |
| | 140 | 5.1.6.2 Нийслэл, дүүргээс зохион байгуулагдаж буй сургалт, хэлэлцүүлэгт хороодын албан хаагчид болон иргэдийн оролцоог хангаж ажиллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хамрагдсан иргэд | Тоо | 92,574 | 100,000 | - | - | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч,  дүүрэг, хорооны Засаг дарга нартай хийх уулзалтыг 2 дугаар улиралд буюу 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр, 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдөр 1-24 дүгээр хороодын Засаг дарга нар 100% хамрагдсан. Мөн дүүргийн 1-24 дүгээр хороодын  хэсгийн ахлагч, ахмадын зөвлөлийн дарга нартай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдын дарга, Засаг дарга нар 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр хүлээн авч уулзалтыг зохион байгуулан ажилласан.<br>Төрийн албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөрвүүлэх арга зүй, eDoc систем ашиглалт, баримт бичгийн стандарт сургалтыг 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдөр 1-24 дүгээр хороодын нийгмийн ажилтан, зохион байгуулагч нарт зохион байгуулсан.<br>Дүүргийн 1-24 дүгээр хороодын иргэдийн амьдарч буй хэсэг, гудамж талбайд засаж сайжруулах талаар мэдээлэх "NewChingeltei.mn" сайтын талаарх мэдээллийг иргэдэд цахимаар хүргэх ажлыг амжилттай зохион байгуулан ажиллаж байна. | 100% | ТЗУХ | УБХ | 100% |
| | 141 | 5.1.6.3 Хороодын албан ёсны цахим хаягийн үйл ажиллагааг идэвхжүүлж, иргэдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Иргэдэд цахимаар мэдээ мэдээлэл хүргэх ажлын хэрэгжилт | Хувь | 100 | 100 | - | - | Дүүргийн 1-24 дүгээр хорооны албан ёсны иргэний танхимын цахим хаягуудаар цаг үеийн шаардлагатай 774 мэдээллийг 149 мянга гаруй /суурин болон түр оршин суугч/ иргэдэд хүргэснээр 92%-ийн эерэг сэтгэгдэл, 8%-ийн сөрөг сэтгэгдлийг хүлээн авч, нийт 70 гаруй мянган удаагийн давтамжтайгаар мэдээллийг түгээж, хяналт тавьж ажилласан. | 100% | ТЗУХ | УБХ | 100% |
| 5.1.7 Хороодын "Нэг цэгийн үйлчилгээ"-ний үйл ажиллагааг тогтмолжуулан, иргэдэд төрийн үйлчилгээг “Хурдан цэг”-ээр дамжуулан түргэн, шуурхай, чирэгдэлгүй үзүүлэхэд анхаарч, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг тогтмол анхаарч ажиллана. | 142 | 5.1.7.1 Хороодын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, нэг цэгийн  үйлчилгээгээр хөнгөн шуурхай, хүнд сурталгүй, соёлтой үйлчлэх нөхцөлийг хангуулна. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хороодын үйл ажиллагааны хяналт, үнэлгээ | Хувь | 100 | 100 | - | - | Дүүргийн 1-24 дүгээр хороодын өдөр тутмын үйл ажиллагааг Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс 1-12, 13-24 дүгээр хороодоор ангилан дотоод зохион байгуулалтын хүрээнд хяналт тавьж, нэг цэгийн үйлчилгээгээр иргэдэд үйлчлэх үндсэн үүргийн биелэлтийг хангуулан мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Хороодын нэг цэгийн үйлчилгээгээр нийт 32,835 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлсэн байна. Төр засгийн бодлого шийдвэрийг анхан шатны нэгжид хүргэх чиглэлээр дээд шатны байгууллагаас ирүүлсэн 253 албан бичгийг судлан, хороодын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 116 албан бичгийг боловсруулан хороодод албан бичгээр хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин үр дүнг тооцон ажилласан. | 100% | ТЗУХ | УБХ | 100% |
| | 143 | 5.1.7.2 Дүүргийн 1-24 дүгээр хороодоос төрийн “ХУРДАН" үйлчилгээг операторын горимоор ажиллах нөхцлийг бүрдүүлэн, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангуулан ажиллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хурдан цэгийн үйл ажиллагааг тогтмолжуулах ажлын хэрэгжилт | Хувь | 0 | 100 | - | - | Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран ажиллаж төрийн үйлчилгээг цахимаар иргэдэд хүргэх, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр “ХУРДАН” киоск машин 23 хороонд, 24 хороонд улсын бүртгэлийн үйлчилгээнд бэлэн мөнгөний ПОС машин, 20 хороонд төрийн “ХУРДАН" үйлчилгээг хороодын зохион байгуулагч нараас операторын горимоор дамжуулан иргэдэд төрийн үйлчилгээг хамгийн ойроос буюу хорооны байрнаас үзүүлж  байгаа бөгөөд төрийн 43 байгууллагын 478 төрлийн үйлчилгээг нэг дороос авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Хурдан цэгийн хэвийн үйл ажиллагааг 20 хороонд бүрдүүлэн, гэрээг сунгуулсан. | 100% | ТЗУХ | УБХ | 100% |
| | 144 | 5.1.7.3 Дүүргийн 1-24 дүгээр хороодод төрийн үйлчилгээний “ГЭРЭГЭ”, “ХУРДАН” киоск машинаар үзүүлж буй улсын бүртгэлийн үйлчилгээний тоо, чанарыг сайжруулна. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Тоо, чанар нь сайжирсан улсын бүртгэлийн үйлчилгээний хэрэгжилт | Хувь | 100 | 101 | - | - | Дүүргийн 1-24 дүгээр хороодын нэг цэгийн үйлчилгээгээр нийт 35,224 иргэн үйлчлүүлсэн байна. Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, ая тухтай үзүүлэх “20 минутын хот” бодлогын хүрээнд 1-24 дүгээр хороодод төрийн “ХУРДАН “үйлчилгээ нэвтэрч хороодын зохион байгуулагч нар операторын горимоор ажиллаж байгаа бөгөөд “ГЭРЭГЭ”, “ХУРДАН” киоск хороо бүрт ажиллан иргэдэд үйлчилгээ үзүүлсэнээр түгжрэл, төвлөрөл, хүнд суртал, зардал буурах, хаанаас ч хурдан шуурхай үйлчилгээг төрийн 43 байгууллагын 478 төрлийн үйлчилгээг нэг дороос авах боломжийг бүрдүүлэн ажилласан. | 100% | ТЗУХ | УБХ | 100% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 153 | 5.2.1.5 Харилцаат хот, дүүргүүдтэй хамтын ажиллагааг тэлж өргөжүүлэх, шинээр өөр улсын хот, дүүргүүдтэй харилцаа тогтоож хамтын ажиллагаа эхлүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 30 | 100 | - | - | 1.Яйзу хотын өсвөрийн шигшээ сагсан бөмбөгийн тамирчид манай улсад хүрэлцэн ирж, дүүргийн сагсан бөмбөгийн өсвөрийн шигшээ багтай хамтарсан бэлтгэл, нөхөрсөг тоглолт хийн спортын хамтын ажиллагааг өргөжүүлсэн. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд 2025 оны 12 дугаар сард дүүргийн Теннисний багийн тамирчид Япон Улсын Яйзу хотод хамтарсан нөхөрсөг тоглолт хийхээр төлөвлөж байна. 2.Хотын дунд сургуулийн сурагчид "Сурагч солилцоо" хөтөлбөрийн хүрээнд "Монголын тухай" сэдэвт гар зургийн уралдаанд оролцож, сонгогдсон сурагчид Монгол улсад хүрэлцэн ирж, дүүрэг болон дүүргийн ерөнхий боловсролын сургуультай танилцсан. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд 2025 оны 10 дугаар сард дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 6 сурагч энэхүү хөтөлбөрт хамрагдан Япон Улсруу айлчлана. 3. Бүгд найрамдах Турк Улсын Пендик дүүрэгтэй хамтын ажиллагааны хүрээнд 1 багш, 4 сурагчийг тус дүүрэгт олон улсын сурагч солилцооны хөтөлбөрт 2025 оны 06 дугаар сард хамруулсан. 4. Бүгд найрамдах Солонгос Улсын Ёндун сумтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, тус ажлын хүрээнд улирлын ажилтан солилцох талаар харилцан тохиролцсон. 5. Хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд Бүгд найрамдах Солонгос Улсын Инчон хотын Ёнсу дүүргийн Засаг дарга, холбогдох албан хаагчдыг Монгол Улсад зочлоход хүлээн авч, Чингэлтэй дүүргийн Хүүхэд хөгжлийн төвд солонгос уран зохиолын болон хүүхдийн номнуудыг хүлээлгэн өгсөн. | 100% | ТЗУХ | | 100% |
| | 154 | 5.2.1.6 Олон улсын сургуулиудтай хамтран дүүргийн ЕБС-ийн багш нарт зориулсан хамтарсан сургалт зохион байгуулж, олон улсын сургалтын арга зүй, шилдэг туршлагыг нэвтрүүлэх тал дээр дэмжиж ажиллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 30 | 100 | - | | Бүгд найрамдах Турк Улсын Пендик дүүрэгтэй хийсэн санамж бичгийн хүрээнд 5 дугаар дунд сургуулийн 1 багш, Чингэлтэй дүүргийн гэр хороололд байрлах дунд сургуулийн 4 сурагчийг сурагч солилцооны хөтөлбөрөөр Бүгд найрамдах Турк Улсруу явуулсан. | 100% | ТЗУХ | | 90% |
| | 155 | 5.2.1.7 Дүүргийн албан хаагчдын Англи хэлний мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор албан хаагчдыг хэлний сургалтад хамруулж ажиллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 0 | 100 | - | | Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын албан хаагчдаас англи хэлний түвшин тогтоох шалгалтанд захиргааны бүх албан хаагчдыг 1 дүгээр улиралд хамруулсан. Шалгалтанд хамрагдсан албан хаагчдын 50-аас дээш хувь нь анхан шатны мэдлэг олгох сургалтанд суухаар шалгалтын дүн гарч, нэг удаагийн сургалтын 20 сая орчим төгрөг шаардахаар байгаа талаар Засаг даргын Тамгын газрын даргад мэдээллийг танилцуулсан. | 50% | ТЗУХ | | 30% |
| 5.2.2. Хамтын ажиллагаатай улс, хотуудад Монголын үндэсний өв уламжлал, зан заншил, соёлыг сурталчлах зорилгоор урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулна. | 156 | 5.2.2.1 Монгол Улсыг гадаад улсад сурталчлах ажлыг дүүргийн Боловсролтын хэлтэс, Биеийн тамир, спортын хороо болон Соёлын төвтэй хамтран зохион байгуулна. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 50 | 100 | - | | Бүгд найрмамдах Солонгос Улсын Ёндун сумтай байгуулсан санамж бичгийн хүрээнд 2025 оны 09 дүгээр сард тус улсад зохион байгуулагдсан "Нанге" 56 дахь удаагийн соёлын наадамд Чингэлтэй дүүргийн Соёлын төвийн албан хаагчид оролцож, 3 өдрийн урлагийн арга хэмжээнд уран бүтээлээрээ оролцсон. | 100% | ТЗУХ | | 100% |
| 5.2.2. Хамтын ажиллагаатай улс, хотуудад Монголын үндэсний өв уламжлал, зан заншил, соёлыг сурталчлах зорилгоор урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулна. | 157 | 5.2.2.2 Дүүргийн хүүхэд, залуучуудад зориулсан харилцаат хот, дүүргүүдтэй хамтарсан тэмцээн, бэлтгэл зэрэг спортын арга хэмжээг зохион байгуулна. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 30 | 100 | - | | Японы улсын Шижүока мужийн Яйзү хоттой хийсэн хамтын ажиллагааны хүрээнд тус хотын дунд сургуулийн сагсны багийн 12 тамирчид Чингэлтэй дүүрэгт зочилж, Чингэлтэй дүүргийн Засаг даргын дэргэдэх сагсны шигшээ багийн тамирчин хүүхдүүдтэй хамтарсан бэлтгэл хийж, нөхөрсөг тэмцээнд зохион байгуулсан. Япон Улсын Шизүока мужийн Яйзү хоттой байгуулсан санамж бичгийн хүрээнд 2025 онд сурагч солилцооны хөтөлбөрөөр зорилтот бүлгийн 6 сурагч, Боловсролын хэлтсийн мэргэжилтэн, Засаг даргын дэргэдэх ширээний теннисний өсвөрийн шигшээ багийн 10 тамирчин сурагч, дасгалжуулагч, 5 дугаар хорооны Засаг дарга, Нийтлэг үйлчилгээний газрын дарга, ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн нарын хамт тус хотод зочилж спорт, соёлын арга хэмжээ, нөхөрсөг тоглолт хийсэн. | 100% | ТЗУХ | БТСХ | 100% |
| 5.2.3. Хамтын ажиллагаатай гадаадын хот, дүүргийн хооронд "Сурагч солилцоо", ижил түвшний төрийн байгууллагын хооронд "Албан хаагчдын солилцоо"-ны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 158 | 5.2.3.1 "Албан хаагчдын солилцоо"-ны хөтөлбөрийн хүрээнд туршлага судлах, мэдлэг, ур чадвар хөгжүүлэх, хамтарсан сургалт, семинарт хамрагдуулж ажиллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 30 | 100 | - | | "Албан хаагчдын солилцоо"-ны хөтөлбөрийн хүрээнд Япон улсад 2026 онд нэг албан хаагчийг туршлага судлуулахаар төлөвлөгдсөн. | 100% | ТЗУХ | | 30% |
| 5.2.3. Хамтын ажиллагаатай гадаадын хот, дүүргийн хооронд "Сурагч солилцоо", ижил түвшний төрийн байгууллагын хооронд "Албан хаагчдын солилцоо"-ны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 159 | 5.2.3.2 Харилцаат хот/дүүргүүдийн Ерөнхий Боловсролын сургуулиудтай хамтран сурагч, багш солилцооны хөтөлбөрийн өргөжүүлж ажиллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 30 | 100 | - | | Бүгд найрамдах Турк Улсын Пендик дүүрэгтэй хийсэн санамж бичгийн хүрээнд 5 дугаар дунд сургуулийн 1 багш, Чингэлтэй дүүргийн гэр хороололд байрлах дунд сургуулийн 4 сурагчийг сурагч солилцооны хөтөлбөрөөр Бүгд найрамдах Турк Улсруу явуулсан. | 100% | ТЗУХ | БХ | 100% |
| 5.2.3. Хамтын ажиллагаатай гадаадын хот, дүүргийн хооронд "Сурагч солилцоо", ижил түвшний төрийн байгууллагын хооронд "Албан хаагчдын солилцоо"-ны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 160 | 5.2.3.2 Дүүргийн төрийн албан хаагчдыг хариуцсан ажил үүргийн хүрээнд гадаад улсад мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамрагдах, олон улсын туршлага судлах уулзалт, семинар болон арга хэмжээнд хамрагдахад дэмжиж ажиллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Гадаад, дотоодын сургалтад хамрагдсан албан хаагчид | Тоо | 15 | 20 | - | | 1.Бүгд найрмадах Вьетнамд Засаг даргын Тамгын газрын 10 албан хаагчдыг олон улсын туршлага судлах уулзалтад 2025 оны 01 дүгээр сард хамруулсан. 2.Бүгд найрмадах Хятад ард Улсаас Монгол Улсад суугаа элчин сайдын яамны дэмжлэгээр Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албаны нийт 8 албан хаагчийн Бүгд найрмдах Хятад ард Улсад 3 удаагийн мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалтанд хамруулсан. | 100% | ТЗУХ | ЧДЗДТГ | 100% |
| 5.2.3. Хамтын ажиллагаатай гадаадын хот, дүүргийн хооронд "Сурагч солилцоо", ижил түвшний төрийн байгууллагын хооронд "Албан хаагчдын солилцоо"-ны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 161 | 5.2.3.4 Дүүргийн Ерөнхий Боловсролын сургуулиудын хичээл, сурлага, урлаг, спортоор манлайлдаг тэргүүний сурагчдыг "Сурагч солилцоо" -ны хөтөлбөрт хамруулна. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Сурагч солилцооны хөтөлбөрт хамрагдсан сурагчид | Тоо | 30 | 20 | - | | Японы улсын Шижүока мужийн Яйзү хоттой хийсэн хамтын ажиллагааны хүрээнд Чингэлтэй дүүргийн гэр хороололд байрлах дунд сургуулийн зорилтот бүлэг болох хагас өнчин, амьдралын боломж тааруу өрхийн сурлагаараа тэргүүлдэг 6 сурагчийг 2025 оны 10 дугаар сард "Сурагч солилцоо"-ны хөтөлбөрт хамруулсан. | 100% | ТЗУХ | БХ | 100% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | | 252.16 | | | | | |
| **ЦАХИМ ШИЛЖИЛТ** | | | | | | | | | | | | | | | | |
| **5.3. Цахим шилжилтийн хүрээнд "Цахим Чингэлтэй-2028" арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | | |
| 5.3.1 Дүүргийн харьяа байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, аюулгүй байдлыг хангаж хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулна. | 162 | 5.3.1.1.Дүүргийн харьяа байгууллагуудын цахим албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавьж, хариуцлагыг нэмэгдүүлэх хариу арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | 2025-2028 | 10.0 | Дүүргийн төсөв | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны цахим шилжилт | Хувь | 50 | 100 | - | - | Чингэлтэй дүүргийн Онцгой комисс, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Нийт 108 байгууллагад Edoc.ulaanbaatar.mn нэгдсэн системээр нийт 20586 албан бичиг ирснээс Хариутай-1440, Хариугүй-19146, үүнээс хугацаандаа шийдвэрлэсэн-19630, хугацаа хоцроож шийдвэрлэсэн-55, судлагдаж байгаа-901, зөрчил тооцогдсон-441 албан бичиг, шийдвэрлэлтийн хувь 99.05, шийдвэрлэлтийн дундаж хоног 4.57 (хоногоор) байна.<br>Дүүргийн хэмжээнд явуулсан албан бичиг-9058 байна.<br>Дүүргийн хэмжээний 2024 оны жилийн эцэс болон 2025 оны эхний хагас жилийн нэгдсэн тайланг гаргаж удирдлагуудад танилцуулан Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсээр хянуулахаар хүргүүлсэн.<br>2024 оны жилийн дүүргийн хэмжээнд ирсэн албан бичгийн шийдвэрлэлт, зөрчлийн тайланд Хяналт-шинжилгээ үнэлгээний хэрэгжилтийн дундаж 98.6 хувь;<br>2025 оны эхний хагас жил дүүргийн хэмжээнд ирсэн албан бичгийн шийдвэрлэлт, зөрчлийн тайланд Хяналт-шинжилгээ үнэлгээний хэрэгжилтийн дундаж 95.0 хувь буюу тус тус "Бүрэн хэрэгжсэн" гэж үнэлэгдсэн.<br>-Дүүргийн Удирдах ажилтны Шуурхай хуралдаан болон Засаг даргын тамгын газрын албан хаагчдын мэдээллийн цагт нийт 8 удаа албан бичгийн шийдвэрлэлт, зөрчлийн тайланг танилцуулж, ирсэн явуулсан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж зөрчлийг бууруулах арга хэмжээ авч ажиллаж байна. | 100% | Архивын хэлтэс | ЗДТГ-ын хэлтэс, алба | 100% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.3.2 Дүүргийн харьяа байгууллагуудын Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулж, салбарын албан хаагчдын мэргэжил, арга зүйг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 163 | 5.3.2.1.Дүүргийн харьяа байгууллагуудын Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан албан хаагчдыг мэргэжил, арга зүйгээр хангах, чадавхжуулахад чиглэсэн сургалт, олон талт арга хэмжээ зохион байгуулна. | 2025-2028 | 80.0 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагаа | Тоо | 8 | 10 | - | - | Дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад 2025 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөнд 6 арга хэмжээг зохион байгуулахаар тусган Тамгын газрын даргаар 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр батлуулж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/20 дугаар тушаалаар Архивын ерөнхий газрын 2025 онд мэргэшүүлэх болон анхан шатны төлөвлөгөөт сургалтад хамрагдах 14 албан хаагчдын нэрсийг батлуулж, төлөвлөгөөнд заасан хуваарийн дагуу хамрагдаж байна.<br>2025 онд шинээр томилогдсон нийгмийн ажилтан 18 албан хаагчидад<br>Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Баримт бичгийн стандарт, Архивын баримтад “Эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийх арга зүй” сэдэвт сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулсан.Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Архивын хэлтсээс 2025 онд зохион байгуулах “Сургалтын төлөвлөгөө”-ний хүрээнд Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Баримт бичгийн стандарт, “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт”-ын дагуу Байгууллагын архивын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулах, Архивын баримтад “Эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийх арга зүй”, Цаасан болон цахим архив үүсгэх “Захирамжлалын баримт бичгийг https://arch.ulaanbaatar.mn/ “Archive Edoc” системд хөрвүүлэх ажлын дараалал” Сэдэвт нэгдсэн сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 05, 06, 12, 13-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>- “Баримт бичгийн стандарт”, “Албан хэрэг хөтлөлтийн eDoc системийн ашиглалт”, Хадгаламжийн нэгж бүрдүүлэх арга зүй сэдвийн хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 01-ний Нийслэлийн хүүхдийн 74 дүгээр цэцэрлэгийн 9 албан хаагчдад,<br>- Дүүргийн онцгой байдлын хэлтэст 2025 оны 05 дугаар сарын 07-ны “Баримт бичгийн стандарт”, “Албан хэрэг хөтлөлтийн eDoc системийн ашиглалт” сэдвээр 14 албан хаагчдад, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтад Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, 1-24 дүгээр хороодын зохион байгуулагч, нийгмийн ажилтан, Засаг даргын эрхлэх хүрээний байгууллагад давхардсан тоогоор 217 байгууллагын 437 албан хаагчид хамрагдсан байна.<br>Мөн дүүргийн Засаг даргын эрхлэх хүрээний давхардсан тоогоор 144 байгууллагын давхардсан тоогоор 655 архив, бичиг хэрэг хариуцсан албан хаагчдад архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, дүрэм, журмын хүрээнд мэргэжил, арга зүйн, заавар зөвлөгөөг өгсөн байна. | 100% | Архивын хэлтэс | Харьяа байгууллага | 100% |
| 5.3.3 Дүүрэг дэх Төрийн архив болон хөмрөг үүсгэгч байгууллагуудын архивд хадгалагдаж буй цаасан суурьт баримтыг цахим хэлбэрт шилжүүлнэ. | 164 | 5.3.3.1.Дүүргийн хөмрөг үүсгэгч байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн цаасан суурьт баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, захирамжлалын баримтыг цахимжуулах ажлыг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | 120.0 | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 20 | 20 | - | - | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.6, хүрээнд “Захирамжлалын баримт бичгийн цахим нөхөн бүрдүүлэлт хийх хуваарь”-ийн дагуу https://arch.ulaanbaatar.mn/ программын Archive eDoc” системд дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын 102 байгууллагын 216 хадгаламжийн нэгжийн 117,99 баримтын 19,968 хуудас баримтад батлан шалгах ажлыг хийж цахимжуулсан. | 100% | Архивын хэлтэс | Харьяа байгууллага | 100% |
| 5.3.4 Дүүргийн хэмжээнд кибер аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог нэвтрүүлнэ. | 165 | 5.3.4.1 Засаг даргын Тамгын газрын серверийн өрөөнд стандартад нийцсэн тоног төхөөрөмж суурилуулах, албан хаагчдын компьютерт антивирус программ суулгах, цахим архивын баримт бүрдүүлэхэд шаардлагатай төхөөрөмж байрлуулж хяналт тавьж ажиллана. | 2025-2028 | 200.0 | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 10 | 20 | - | - | Засаг даргын Тамгын газрын серверийн өрөөнд шаардагдах тоног төхөөрөмжийн судалгааг хийж байна. Мөн мэдээлэл технологи хариуцсан хоёр мэргэжилтэн серверийн өрөөний хэвийн ажиллагааг 14 хоногт нэг удаа тогтмол шалгаж, хяналт тавин ажиллаж байна.<br>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын компьютерт албан ёсны лицензтэй вирусийн эсрэг програм суулгах ажил үргэлжилж байна. Энэ хүрээнд эхний ээлжинд 30 албан хаагчийн компьютерт антивирус програм суулгасан байна.<br>Мөн кибер аюулгүй байдлыг бүрдүүлэх зорилгоор компьютерийн сүлжээ болон интернэт орчинд мэдээллийн урсгалыг хянаж, хамгаалдаг firewall системийг нэвтрүүлэх ажил үргэлжилж байна. Энэ хүрээнд өнгөрсөн 6, 7 дугаар сард ○"Юнивишн" ХХК-тай хоёр удаагийн уулзалт хийсэн. Одоогоор firewall аюулгүйн системийг нэвтрүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна. | 100% | ХМОНХТ | Харьяа байгууллага | 100% |
| 5.3.5 Салбар архивын үйл ажиллагааг өргөжүүлж, иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх архивын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 166 | 5.3.5.1.Салбар архивын шаардлагыг хангуулж, Архивын сан хөмрөгт нөхөн баяжилт хийж, төрийн архивын баримтаас иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр лавлагаа баримтын хуулбар олгоно. | 2025-2028 | 129.2 | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 90 | 10 | - | 102.85 | Дүүргийн мэдээлэл харилцаа холбооны технологийн дэд бүтцийг хөгжүүлж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулж, иргэд олон нийтийн санал хүсэлтэд тулгуурлан мэдээллийн урсгалыг сайжруулах, цахим технологид түшиглэн төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын цаг хугацаа, зардлыг хэмнэж, бүтээмжийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэхэд ажлын хүрээнд Цахим Чингэлтэй-2028” арга хэмжээг боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 21-ний Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 19 дүгээр тогтоолоор батлуулсан. Тус арга хэмжээнд Салбар архив байгуулах нөхцөлийг бүрдүүлж, архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх зорилтын хүрээнд 3 зорилт 20 арга хэмжээний хүрээнд ажиллаж байна. Энэхүү арга хэмжээний хүрээнд Дүүргийн архивын сан хөмрөгт хадгалагдаж буй 1962-2022 оны 89 хөмрөгийн цаасан болон цахим баримтад иж бүрэн тооллогыг 2025 оны 04 дүгээр сарын 03-аас 05 дугаар сарын 01-ний өдрүүдэд хийж цахимжуулах шаардлагатай баримтын судалгааг гарган ажилласан. Тооллогын үр дүнд<br>Цаасан суурьт:Дүүргийн архивд хадгалагдаж байгаа 88 хөмрөгийн 1962-2022 оны 12,575 хадгаламжийн нэгжийн 539,770 хуудас,<br>Цахимаар: “Archive edoc” системд 89 хөмрөгийн 1961-2024 оны 2949 хадгаламжийн нэгжийн 119,985 баримтын 230,223 хуудас 199,39.5 kb баримтыг тоолсон байна<br>Эхний ээлжид цахимжуулах шаардлагатай Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн “Б маягт”-ын 179 хадгаламжийн нэгжийн 2147 хуудас баримтын жагсаалт, байгууллагын төлөвлөгөө, тайлан, зураг төслийн баримтын судалгааг тус тус гаргаж цахимд шилжүүлэх бэлтгэл ажлыг хангасан<br>Цахим архив үүсгэхэд шаардлагатай процессор, дэлгэц, А3 хэвлэгч, хувилагч, Сканер, Зөөврийн хард, сервер, firewall зэрэг 37,850,000 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдсан. | 100% | Архивын хэлтэс | Харьяа байгууллага | 100% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | - | 102.85 | | | | | |
| **БАТЛАН ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА** | | | | | | | | | | | | | | | | |
| **5.4. Батлан хамгаалах бодлого үйл ажиллагааг иргэдийн оролцоотой сурталчлан, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, эх орноо батлан хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | | |
| | 167 | 5.4.1.1. Орон нутгийн хамгаалалтын үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, нөөцийн чадавхийг нэмэгдүүлнэ. | 2025-2028 | 80.0 | Улсын төсөв | Арга хэмжээ | Тоо | 1 | 1 | 15.00 | 8.64 | Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 1-3-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний Тусгай хүчний командлал, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Зэвсэгт хүчний 311 дүгээр ангиудтай хамтран зохион байгуулж ажилласан. | 100% | ЦШ | НЗДТГ-ын Цэргийн штаб | 100% |
| | 168 | 5.4.1.2. Дайчилгааны төлөвлөлт, төлөвлөгөөт арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, сургалтуудыг зохион байгуулна. | 2025-2028 | 140.0 | Улсын төсөв | Хэрэгжилт | Хувь | 100 | 100 | 30.00 | | Нийслэлийн Засаг даргаар батлагдсан “Чингэлтэй дүүргийн Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлж, Зэвсэгт хүчний анги, байгууллагуудыг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”-ний дагуу хүн, техникийн тодотголыг батлагдсан хуваарийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулсан. | 100% | ЦШ | НЗДТГ-ын Цэргийн штаб | 100% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.4.1 Орон нутгийн хамгаалалтын бэлтгэл, дайчилгааны бэлэн байдлыг нэмэгдүүлж, төрийн байгууллагууд болон аж ахуйн нэгжийн гүйцэтгэх үүрэг, ажлын уялдаа холбоог хангаж ажиллана. | 169 | 5.4.1.3. Цэргийн бүртгэл, 1, 2 дугаар ээлжийн цэрэг халах, татах ажиллагааг зохион байгуулах, халагдсан дайчдыг ажлын байр, сургалт, дамжаанд зуучилна. | 2025-2028 | 210.0 | Улсын төсөв | Хэрэгжилт | Хувь | 100 | 100 | 50.00 | 59.84 | Дүүргийн хэмжээнд 2025 оны Цэргийн бүртгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 22-ны өдрүүдэд явуулсан. Батлан хамгаалах сайдын хугацаат цэргийн алба, цэрэг халалт, татлагын ажлын зохион байгуулалтыг сайжруулах тухай албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх, цэргийн насны залуучуудын эх оронч сэтгэлгээг нэмэгдүүлэх, цэрэг татлагын хяналтын тоон даалгаврын биелэлтийг нэмэгдүүлэх зорилгоор “Чингэлтэй дүүрэгт 2025 оны ээлжит цэрэг халалт, татлагын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулж явуулах төлөвлөгөө”-г нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргаар хянуулан, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/435, дүүргийн Засаг даргын А/130 дугаар захирамжаар дүүргийн хэмжээнд 2025 оны нэгдүгээр ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлагыг 2025 оны 05 дугаар сарын 2-4-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус дүүргийн Цэрэг татлагын товчоо дээд байгууллагаас ирсэн тоон даалгаврыг 100%-тай гүйцэтгэсэн. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1315, дүүргийн Засаг даргын А/326 дугаар захирамжийг үндэслэн дүүргийн хэмжээнд 2025 оны хоёрдугаар ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлагыг 2025 оны 10 дугаар сарын 17, 18, 19-ний өдрүүдэд зохион байгуулсан. | 100% | ЦШ | 1-24 дүгээр хороо | 100% |
| 5.4.2 Иргэдэд эх оронч үзэл төлөвшүүлэх, Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудад сурталчлах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлнэ. | 170 | 5.4.2.1. Дүүргийн нутаг дэвсгэрт батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана. | 2025-2028 | 15.0 | Улсын төсөв | Хэрэгжилт | Хувь | 100 | 100 | 3.50 | 975.00 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын баталсан “Хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөө”, дүүргийн Засаг даргын 2024 оны А/01 дүгээр захирамж, удирдамжийн дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Сонгуулийн Ерөнхий хороо, Ерөнхий боловсролын 39 дүгээр сургууль, Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо, Номин Тав ХХК, Тавин Ус ХХК-ны ажилчдад батлан хамгаалах хууль  тогтоомж, цэргийн үүргийн биелэлтийн хэрэгжилтийг зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Тус байгууллагын хүний нөөцийн ажилчидтай 2025 оны 01 дүгээр сарын 22-ний өдөр “Батлан хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт явуулах” тухай сургалтыг зохион байгуулсан. Тус шалгалтад төлөвлөгөөний дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Сонгуулийн Ерөнхий хороо, Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо, Тавин Ус ХХК-ны албан хаагчдыг бүрэн хамруулж, батлан хамгаалах хуулийн дагуу цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол шаардлага хангасан иргэдэд мөнгөн төлбөр тогтоож, ажлын байранд нь төрийн батлан хамгаалах үйлчилгээг хүргэсэн. Нийслэлийн Ерөнхий Боловсролын 39 дүгээр сургууль, Номин Тав ХХК нь хуваарийн дагуу шалгуулаагүй байгаа ба тухайн байгууллагуудад албан бичгээр алба хаагчдаа хяналт шалгалтад хамруулах шаардлагыг хүргүүлсэн. Мөн Батлан хамгаалахын сайдын шийдвэрээр Аж үйлдвэр, Эрдэс баялгын яаманд 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хяналт-шалгалтын ажлыг явуулсан. | 100% | ЦШ | НЗДТГ-ын Цэргийн штабын Хуулийн баг | 100% |
| | 171 | 5.4.2.2. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх, иргэдийн эх оронч үзлийг нэмэгдүүлнэ. | 2025-2028 | 80.0 | Улсын төсөв | Хэрэгжилт | Хувь | 100 | 100 | 20.00 | 20.00 | Дүүргийн Засаг даргын 2025 оны А/47 дугаар “Иргэн-цэргийн харилцааны өдөрлөгийг зохион байгуулах тухай” захирамж, хөрөнгө гаргах тухай ЗДТГ-ын даргын 2025 оны А/44 дүгээр тушаал, Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 104 жилийн ойн төлөвлөгөөг боловсруулан холбогдох албан тушаалтнуудаар хянуулан батлуулсан. Төлөвлөгөөт 16 арга хэмжээг 2025 оны 3 дугаар сарын 1-30-ны өдөр зохион байгуулсан. | 100% | ЦШ | НХХ, БХ | 100% |
| 5.4.3 Өсвөр үе, хүүхэд залуучуудын эх орноо батлан хамгаалах хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг үе шаттайгаар зохион байгуулна. | 172 | 5.4.3.1. Дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг зохион байгуулж явуулна | 2025-2028 | 100.0 | Улсын төсөв | Хэрэгжилт | Хувь | 100 | 100 | 25.00 | 13.92 | Дүүргийн Засаг даргын 2025 оны А/60 дугаар захирамжийг батлуулж, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн өмчит ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлсэн. Тэмцээний урьдчилсан техникийн зөвлөгөөний хурлыг 2025 оны 03 дугаар сарын 26, үндсэн техникийн зөвлөгөөний хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр дүүргийн хурлын танхимд зохион байгуулсан.  Дүүргийн Засаг даргын нэрэмжит Цэрэг-спортын “Дөл-2025” тэмцээнийг 04 дүгээр сарын 11-ний өдөр Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан. Тэмцээнд оролцож тэргүүлсэн шилдгүүдэд шагнал гардуулах ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр дүүргийн “Тусгаар тогтнолын талбай”-д зохион байгуулж, тэргүүлсэн тасгуудын шилдэг сурагчдаар тасаг бүрдүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит Улсын аварга шалгаруулах “Дөл” тэмцээнд амжилттай оролцуулж, Тусгай байранд шалгарсан. | 100% | ЦШ | НХХ, БХ | 100% |
| | 173 | 5.4.3.2. Өсвөр үе хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх 1 дүгээр шатны арга хэмжээг зохион байгуулна. | 2025-2028 | 35.0 | Улсын төсөв | Хэрэгжилт | Хувь | 100 | 100 | 17.50 | 3.90 | Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилсан бидний бахархал арга хэмжээ, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас санаачлан хэрэгжүүлж буй “Бид эх орны ирээдүй” хөтөлбөр, дүүргийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Эх оронч цэрэг-2028” арга хэмжээний хүрээнд Үндэсний Батлан хамгаалахын Их сургууль, Зэвсэгт хүчний 189 дүгээр ангитай хамтран ерөнхий боловсролын 5, 23, 24, 39, 50 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчдад 2025 оны 02 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгууллаа. Мөн хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр ерөнхий боловсролын 17, 49, 61 дүгээр сургуулийн 250 ахлах ангийн сурагчдыг Монгол цэргийн музейн шинээр дэлгэгдсэн үзмэрүүдийг үзүүлэх, Үндэсний Батлан хамгаалахын Их сургуулийн үйл ажиллагаатай танилцуулах тойрон аялалд хамруулсан. Уг хөтөлбөрт дүүргийн ерөнхий боловсролын 8 сургуулийн 1200 гаруй сурагчид хамрагдсан. | 100% | ЦШ | НХХ, БХ | 100% |
| | 174 | 5.4.3.3. Өсвөр үе хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх тогтолцоог бэхжүүлэх 2 дугаар шатны арга хэмжээг зохион байгуулна. | 2025-2028 | 45.0 | Улсын төсөв | Хэрэгжилт | Хувь | 100 | - | - | | Өсвөр үе хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх тогтолцоог бэхжүүлэх 2 дугаар шатны арга хэмжээ нь 2027, 2028 онд хэрэгжинэ. | 0% | ЦШ | НХХ, БХ | ХТХБ |
| 5.4.4 Цэрэг татлагын хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор өсвөр үе, залуучуудад эх орноо батлан хамгаалах хүсэл эрмэлзлийг төлөвшүүлж, “Эх оронч цэрэг-2028” арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ. | 175 | 5.4.4.1. “Эх оронч цэрэг-2028” хөтөлбөрийг боловсруулж, 1 дүгээр шатны хэрэгжилтийг хангана. | 2025-2028 | 70.0 | Улсын төсөв | Хэрэгжилт | Хувь | 100 | 100 | 34.00 | | Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Эх оронч цэрэг-2028” арга хэмжээг тусгуулж, дүүргийн ИТХ-ын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр болох ээлжит хурлаар хэлэлцүүлж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 01 дүгээр тогтоолоор батлуулсан. "Эх оронч цэрэг-2028" арга хэмжээний 2025 онд хэрэгжихээр төлөвлөгдсөн 10 арга хэмжээнээс 5 үйл ажиллагаа  зохион байгуулагдаж 50 хувийн биелэлттэй байна. Хэрэгжсэн 5 үйл ажиллагаа “Эх оронч цэрэг-2028” арга хэмжээ батлагдахаас өмнө буюу Монгол цэргийн өдөр Зэвсэгт хүчний 104 жилийн ойг тохиолдуулан явагдсан. Үлдсэн хэрэгжих 5 үйл ажиллагаа Монгол Улсын Засгийн газар 2025 оны 06 дугаар сараас төрийн байгууллагуудыг хэмнэлтийн горимд шилжүүлсэнтэй холбогдуулан 2026 онд нөхөн явуулахаар болон хойшлогдсон. Мөн дээрх 5 арга хэмжээг 2026 онд явуулахаар 2026 оны төлөвлөгөөнд нэмэлтээр тусгасан. | 30% | ЦШ | НХХ, БХ | 50% |
| | 176 | 5.4.4.2. “Эх оронч цэрэг-2028” хөтөлбөрийн 2 дугаар шатны хэрэгжилтийг хангана. | 2025-2028 | 80.0 | Улсын төсөв | Хэрэгжилт | Хувь | 100 | - | - | | “Эх оронч цэрэг-2028” хөтөлбөрийн 2 дугаар шатны хэрэгжилт 2027, 2028 онд хэрэгжинэ. | 0 | ЦШ | НХХ, БХ | ХТХБ |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 195.00 | 1,081.30 | | | | | |
| **ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА** | | | | | | | | | | | | | | | | |
| **5.5. Онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлж, аюулт үзэгдэл, ослоос аврах ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | | |
| 5.5.1 Шинэ гал унтраах ангийн барилгын ажлыг дуусган ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тогтмолжуулна. | 177 | 5.5.1.1 Шинэ гал унтраах ангийн барилгыг хүлээн авч ашиглалтад оруулж үйл ажиллагааг эхлүүлнэ. | 2025-2028 | 5,200.0 | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 30 | 100 | 3,200.00 | 3,100.00 | Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 43 дугаар тогтоолоор дүүргийн 21 дүгээр хороонд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр ГТУА-х анги байгуулахаар зураг төсвийг шийдвэрлэн 2024 онд 2 тэрбум, 2025 оны 14 дүгээр тогтоолоор 3,2 тэрбум нийт төсөвт өртөг 5,2 тэрбум төгрөгөөр барилгын ажлыг эхлүүлсэн. 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Улсын комисст хүлээн авсан. Тус шинэ гал унтраах, аврах ангийн үйл ажиллагааг эхлүүлэх төлөвлөгөөтэй орон тооны бүтцийг Онцгой байдлын ерөнхий газраас баталж төсвийг суулгасан. Шинэ ангийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай техник тоног төхөөрөмж, тавилга эд хэрэгслийг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | 70% | ОБХ | ХЭЗХ | 70% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.5.2.Онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чадавхийг сайжруулж, инновацыг ашиглах замаар гамшгийн бэлэн байдлыг дээшлүүлнэ. | 178 | 5.5.2.1 Гал унтраах автомашин цэнэглэх боломжтой худагийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Нэмэгдүүлсэн худгийн байршил | Тоо | 0 | 2 | - | - | Гал түймэр унтраах ажиллагааны үед гал унтраах автомашинуудыг тасралтгүй усаар хангах, усны эх үүсвэрүүдийн ашиглалтын бэлэн байдлыг хангах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, болзошгүй гал түймрийн аюул, хохирлыг бууруулах, гал унтраах зориулалтын автомашинууд ус авах боломжтой ус түгээх цэгүүдийн судалгаанд тодотгол хийж, тэдгээрийн тоог үе шаттай нэмэгдүүлэх, засвар үйлчилгээг тогтмол хийх зэрэг ажил, арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Онцгой байдлын газар, Ус сувгийн удирдах газартай хамтрах санамж бичиг байгуулсан. | 100% | ОБХ | ХЭЗХ | 70% |
| | 179 | 5.5.2.2 Гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх үед иргэдийн амь насыг аврах яаралтай түргэн тусламжийн амьсгалын аппаратыг албандаа нэвтрүүлж ашиглана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Амьсгалын аппарат | Тоо | 0 | 2 | - | - | Төсвийн хязгаартай нөхцөл байдлаас шалтгаалаад гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх үед иргэдийн амь насыг аврах яаралтай түргэн тусламжийн амьсгалын аппаратыг албандаа нэвтрүүлэх ажил одоогоор хийгдээгүй байна. | 0% | ОБХ | ХЭЗХ | 0% |
| | 180 | 5.5.2.3 Гамшгаас хамгаалах техник тоног төхөөрөмжийн чадавхийг сайжруулж, нэмэгдүүлэн бэлэн байдлыг хангаж ажиллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Бэлэн байдал | Хувь | 80 | 90 | - | 15.00 | Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2025 оны “Гол, усны ослын аюулаас урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/243 дугаар захирамжаар тус хэлтэст усны цув 9 ширхэг, усны гутал 9 ширхэг, холын тусгалтай гар чийдэн 2 ширхэг, EVO II Pro V2 Rugged Bundle загварын дроны 4 ш баттерей, Osmo pocket 3 загварын 1 ш камер нийт 9,119,000 төгрөгийн хувцас,төхөөрөмжийг шийдвэрлэн хүлээлгэн өгсөн. | 100% | ОБХ | ХЭЗХ | 100% |
| 5.5.3 Гал унтраах ангид ашиглагдах үндсэн болон шуурхай албаны техник хэрэгслийг сайжруулах замаар гал унтраах үйл ажиллагааг түргэн шуурхай зохион байгуулж, иргэдийн амь нас, эд хөрөнгийг авран хамгаална. | 181 | 5.5.3.1 Орон сууцны хороодод хог хаягдлаас үүссэн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр гал унтраах усан хангамжийг суурилуулах ажлыг зохион байгуулна. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Суурилуулсан усан хангамжийн байршил | Тоо | 0 | 20 | - | - | Чингэлтэй дүүргийн 1-6 дугаар хороодод хогийн сувгийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ухаалаг хогийн савийг суурьлуулсан. | 100% | ОБХ | ХЭЗХ | 30% |
| | 182 | 5.5.3.2 Гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийг дүүргийн хэмжээнд зохион байгуулна. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Арга хэмжээ | Тоо | 11 | 11 | - | - | Гал түймэр, ой хээрийн түймэр, үер усны ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн хэмжээнд Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2025 оны Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх “Сэргийлье-сэрэмжлье II” нэгдсэн арга хэмжээ өдөрлөгийг 3 удаа зохион байгуулсан. | 100% | ОБХ | ХЭЗХ | 100% |
| | 183 | 5.5.3.3 Гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгт хамрагдах иргэдийн тоо, оролцоог хангаж ажиллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хамрагдсан иргэд | Тоо | 12,000 | 12,000 | - | - | Гал түймэр, ой,хээрийн түймэр, үер усны ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгдсэн арга хэмжээ өдөрлөгийг 3 удаа зохион байгуулж 3000 гаруй иргэдийг хамруулан зохион байгуулж урьдчилан сэргийлэх материалыг тарааж ажилласан. | 100% | ОБХ | ХЭЗХ | 100% |
| | 184 | 5.5.3.4 Дүүргийн хэмжээнд Гамшиг аюулт үзэгдэл, Гал түймэр унтраах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж мэргэжлийн удирдлагаар хангаж ажилллана. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 100 | 100 | - | - | Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн алба хаагчид нийт 80 дуудлагаар үүрэг гүйцэтгэсэнээс анги унтрааж ажилласан-58, иргэд унтраасан-12, өөрөө унтарсан-9, худал-1 дуудлагтай байв. Нийт 16 цаг 22 минут ажиллаж, 158.9 тонн гал унтраах бодис зарцуулан, 259 ширхэг амьсгалын бие даасан төхөөрөмж ашигласан. аварсан хүн-209, аварсан хөрөнгө-58 тэрбум 230 сая, 1153.04 л шатахуун зарцуулан техникийн алдаа дутагдал гаргалгүй унтрааж ажилласан. | 100% | ОБХ | ХЭЗХ | 100% |
| 5.5.4 Хороодын гамшгийн үеийн бэлэн байдал, урьдчилан сэргийлэх чадавхийг нэмэгдүүлж, гамшгаас хамгаалах иргэдийн сайн дурын бүлгийг сургаж бэлтгэнэ. | 185 | 5.5.4.1 Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулна. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Сургалт | Тоо | 250 | 200 | - | - | Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг тайлант хугацаанд 35 удаа 189 иргэн, ажилтан алтан алба хаагчдад танхимаар зохион байгуулан ажилласан | 100% | ОБХ | ХЭЗХ | 100% |
| | 186 | 5.5.4.2 Дүүргийн Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэгтэй хамтран хороодод сургалт зохион байгуулна. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Сургалт | Тоо | 21 | 20 | - | - | Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм норм, стандартуудыг сурталчлах, гамшиг осол гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах, Нийслэлийн Онцгой байдлын газар, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн даргын баталсан удирдамж, хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр дүүргийн 4 дүгээр цэцэрлэгийн 23 багш ажилтан, 5 дугаар цэцэрлэгийн 29 багш ажилтанд “Ой хээрийн түймэр, өнжмөл өвс, ахуйн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн ашиглалт” сэдвээр танхимын сургалт зохион байгуулж нийт 52 багш ажилтан хамрагдаж, тайлант хугацаанд "Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг"-ээс нийт 7 хорооны 149 ажилтан, 40 иргэнд гал түймэр, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх танхимын сургалтыг зохион байгуулсан. | 100% | ОБХ | ХЭЗХ | 100% |
| | 187 | 5.5.4.3 Дүүргийн ЗДТГ-ын хууль эрх зүйн хэлтэстэй хамтран Гамшгаас хамгаалах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Хөтөлбөрийн хэрэгжилт | Хувь | 100 | 100 | - | - | Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсээс Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах-2028” арга хэмжээг 5 зорилтын хүрээнд 14 арга хэмжээтэйгээр төлөвлөж дүүргийн хууль эрх зүйн хэлтсээр хянуулан дүүргийн хурлын хороогоор хэлэлцүүлж Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн “Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах-2028 арга хэмжээ батлах тухай” 18 дугаар тогтоолыг баталж 2025 онд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>“Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах-2028 арга хэмжээний хэрэгжилтийн тайланг улирал, хагас бүтэн жилээр гарган дүүргийн Засаг даргын Тамгын газрын хууль эрх зүйн хэлтэст хүргүүлж ажилласан. Дэд хөтөлбөрийн биелэлт 2025 оны жилийн эцсийн байдлаар 100%-тай хэрэгжсэн байна. | 100% | ОБХ | ХЭЗХ | 90% |
| 5.5.5 Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, газ болон тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдлын стандартыг мөрдүүлж хяналтыг сайжруулна. | 188 | 5.5.5.1 Дүргийн нутаг дэвсгэрт байрлах Шатахуун түгээх станцуудын галын аюулгүй байдлыг хангуулах хяналт шалгалтыг зохион байгуулна. | 2025-2028 | 4.0 | Дүүргийн төсөв | Хяналт, шалгалтад хамрагдсан станц | Тоо | 75 | 75 | - | - | Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 10 Шатахуун түгээх станцын барилга байгууламжид хяналт шалгалт зохион байгуулж Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 3, мэдэгдэл 1-г бичиж холбогдох эрх бүхий албан тушаалтан нарт хүргүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. | 100% | ОБХ | ХЭЗХ | 100% |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 3,200.00 | 3,115.00 | | | | | |
| **5.6 Иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | | |
| 5.6.1 Хууль, тогтоомжийг иргэдэд сурталчлах, оролцоог дэмжих олон талт арга хэмжээг тогтмол зохион байгуулна. | 189 | 5.6.1.1 Хууль, тогтоомжийг иргэдэд сурталчлах, оролцоог дэмжих олон талт арга хэмжээг тогтмол зохион байгуулж, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлнэ. | 2025-2028 | 65.2 | Дүүргийн төсөв | Арга хэмжээ | Тоо | 16 | 16 | - | - | Дүүргийн Засаг дарга, Тамгын газрын даргын хуулиар олгосон эрх хэмжээний хүрээний асуудлаар иргэдэд 29 удаагийн зөвлөгөө мэдээлэл, шинээр батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд 2 удаагийн сургалтаар 95 иргэн, 102 албан хаагч нарт болон “Хөлсөөр ажиллах гэрээ”-ний биелэлт, явцыг дүгнэх ажлын хүрээнд 3 удаагийн сургалт, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан.<br>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар нутгийн захиргааны байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор “Хөлсөөр ажиллах гэрээ”-ний биелэлтийг дүгнэх ажлын хүрээнд 1-24 дүгээр хороо, Замын цагдаагийн хэлтэс 3 нийт 27 “Олон нийтийн байцаагч” нарт “Эргүүлийн үүрэг гүйцэтгэхэд анхаарах асуудал” сэдвээр 2 удаагийн сургалтыг зохион байгуулан өдөр тутмын эргүүлийн үүргийн талаарх мэдээллийг цахим хаягаар нэгтгэн үр дүнг “Цагдаагийн газар”-т сар бүр илтгэх хуудсаар танилцуулан хамтран ажиллаж байна.<br>Дүүргийн хэмжээнд гэнэтийн гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр “Хөлсөөр ажиллах гэрээ”-ний биелэлтийн явц, үр дүнг сайжруулах ажлын хүрээнд “Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг”-ийн гишүүдэд 1 удаагийн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулан сар бүр гэрээний биелэлтийг дүгнэж, зохих журмын дагуу урамшуулал олгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | 100% | ХЭЗХ | Төрийн болон, Төрийн бус байгууллага | 100% |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.6.2 Ил тод байдлыг сайжруулан хүнд суртал, чирэгдлийг бууруулж, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлнэ. | 190 | 5.6.2.1 Дүүргийн Засаг даргын захирамжлалын баримт бичгийг нийслэлийн болон дүүргийн цахим сайтад байршуулна. | 2025-2028 | - | - | Цахим сайтад байршуулах ажлын хэрэгжилт | Хувь | 100 | 100 | - | - | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор дүүргийн Засаг даргын хуулиар олгосон бүрэн эрх, хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, төрөөс үзүүлж буй үйлчилгээ, зохион байгуулалтын чиглэлээр гарсан шийдвэрийг иргэд, олон нийтэд сурталчлах чиглэлийн дагуу холбогдох хуульд зааснаар ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан Нийслэлийн Засаг даргын эрхлэх хүрээний цахим хуудас www.ublegal.mn, дүүргийн цахим хуудас www.chingeltei.gov.mn сайтад нийт 165 захирамж байршуулан ажилласан.<br>Мөн дүүргийн Засаг даргын Тамгын газрын хуулиар хүлээсэн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх, сурталчлах, иргэдэд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл шуурхай хүргэн ажиллах байнгын тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд Тамгын газрын албан ёсны цахим хуудасны "Эрх зүйн хөтөч" мэдээллийн хуудсаар хууль тогтоомжийн сурталчилгааны сонирхолтой, ойлгомжтой, хүртээмжтэй арга хэлбэрийг сонгон дүүргийн Тамгын газрын info@chingelteigov.mn цахим хуудсанд Авлигатай тэмцэх арга хэмжээ, Цахилгаан болон утаат тамхины хэрэглээ зэрэг 6 удаагийн мэдээллийг зурган фостер хэлбэрээр бэлтгэн байршуулахад иргэдээс нийт 1568 удаагийн хандалттай байна. | 100% | ХЭЗХ | | 100% |
| 5.6.3 Дүүргийн "Камерын хяналтын төв"-ийн программ хангамжийг хөгжүүлж, яаралтай түргэн тусламж, гал түймэр, гамшиг осол, цагдаагийн байгууллагын яаралтай дуудлагыг шуурхай хүлээн авч, нөхцөл байдлыг алсын зайнаас хянах тогтолцоог бий болгоно. | 191 | 5.6.3.1 Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчинд суурилуулсан хяналтын камерыг нэгдсэн сүлжээнд холбох, хяналт тавих чиг үүрэг бүхий "Теле камерын хяналтын дэд төв"-ийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулна. | 2025-2028 | Батлагдсан төсвийн хүрээнд | Дүүргийн төсөв | Яаралтай түргэн тусламж, гал түймэр, гамшиг осол, цагдаагийн байгууллагын яаралтай дуудлагыг хүлээн авах ажлын хэрэгжилт | Хувь | 100 | 100 | - | - | Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан "Амар тайван-Чингэлтэй 2028" арга хэмжээний хүрээнд иргэдийн эрх зүйн мэдлэг, чадвар нэмэгдүүлэх чиглэлээр нийт 82 удаагийн сургалтаар 6591 иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулан ажилласан. Мөн тус дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Чингэлтэй дүүргийн Теле камерын хяналтын дэд төв" байгуулагдан засварлалт, суурилуулалт шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэн бүрэн ашиглалтад оруулан хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 572 цэгт 2633 камер суурилуулан теле хяналтын нэгдсэн сүлжээнд холбож 24 цагаар хяналт тавьж ажиллаж цагдаагийн байгууллагын яаралтай дуудлагыг хүлээн авах ажлын нөхцөлийг сайжруулан ажиллаж байна. | 100% | ХЭЗХ | ЦГ | 100% |
| 5.6.4 Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна. | 192 | 5.6.4.1 Цахим орчин дахь гэмт хэрэг, цахим орчин дахь гүтгэлэг, доромжлол, цахим орон зай дахь хүний эрхийн талаар олон талт арга хэмжээ зохион байгуулна. | 2025-2028 | 20 | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 100 | 100 | - | - | Нийслэлийн ерөнхий боловсролын 5, 50, 23, 24, 149 дүгээр сургуулийн ахлах (9-12) ангийн сурагчдад болон Улаанбаатар дээд сургууль, Соёл урлагийн их сургуулийн оюутан нарт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, донтох эмгэг (архи, тамхи, цахим болон мөрийтэй тоглоом, дэлгэцийн донтолт)-ийн хор уршиг, урьдчилан сэргийлэх арга зам, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, буруу зуршлаас татгалзах хандлагад төлөвшүүлэх зорилгоор "Мондэм" төрийн бус байгууллагатай хамтран ***"Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ойлголт, нөхцөл байдал, хууль эрх зүй, хор уршиг, урьдчилан сэргийлэх арга зам", "Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх", "Теллеграмм платформ ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх", "Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам", "Хар тамхи, мансууруулах бодисын хор уршиг" "Хүүхэд хамгаалах тухай хууль" "Үе тэнгийн дээрэлхэл", "Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг"сэдвээр"*** ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 857 сурагч, их, дээд сургуулийн нийт 406 оюутануудад 7 удаагийн сургалт, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Тус Цагдаагийн газраас дүүргийн "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл"-тэй хамтран ***"Телеграмм залилангаас урьдчилан сэргийлэх"*** чиглэлээр 2 минут 23 секундын видео бэлтгэн төрийн байгууллагын цахим фэйсбүүк мэдээллийн сувгаар байршуулахад иргэдээс 3678 удаагийн хандалттай байна. Тайлант хугацаанд мэдээллийн "ТВ 25" дугаар суваг телевиз нийгмийн хариуцлагын хүрээнд тус цагдаагийн газартай хамтран ***"Хүүхдийг цахим орчны гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх"*** чиглэлээр хамтран 3 удаагийн хүүхдийн нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэсэн. | 100% | ХЭЗХ | ЦГ | 100% |
| 5.6.5 Насанд хүрээгүй хүүхдэд электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглох, сургуулийн орчинд утаат болон электрон тамхины хэрэглээнд хатуу хяналт тавих, хорт зуршлаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. | 193 | 5.6.5.1 Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран электрон тамхины хор уршиг, эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөөний талаар ойлголт, мэдээлэл өгөх сургалт, нөлөөллийн арга хэмжээг насны онцлогт тохируулан олон талт арга хэмжээ зохион байгуулна. | 2025-2028 | 22.0 | Дүүргийн төсөв | Хэрэгжилт | Хувь | 100 | 100 | - | - | Насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа, электрон болон утаат тамхи худалдах, борлуулахыг хуулиар хатуу хориглох, төрийн болон хувийн хэвшилийн байгууллагын ажилтан, албан хаагчдад Тамхины хяналтын тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих тухай хуулийн талаар мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт, мэдээллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах, хариуцсан нутаг дэвсгэрт согтууруулах ундааны зүйл худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж байгууллагад давхардсан тоогоор 231 мэдэгдэл хүргүүлэн ажилласан. Хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор "Теле-хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага" /MNS6423:2019/ стандартыг хангасан хяналтын камерыг 3 цэгт шинээр байршуулах хүсэлтийг хүргүүлэн хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэн 86 удаагийн зөрчил, мэдээллийн дуудлагаар шалгаж, мэдэглэлийн биелэлтийн үр дүнд хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр ажилласан. Тайлант хугацаанд зөрчил, мэдээллийн дуудлагаар ангилж, өмнөх оны энэ үетэй харьцуулахад: хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, мэдээлэл 1981 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр буюу 0.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн шинжтэй нийт 11008 гомдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1766 нэгж буюу 16 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 49,3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,8 хувиар өссөн үзүүлэлттэй байна<br>Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран ерөнхий боловсролын сургуулийн сурагч, эцэг, эх, асран хамгаалагч, төрийн албан хаагчдад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийг таниулах, хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 сургуулийн 685 эцэг эх, асран хамгаалагч нарт сургалт зохион байгуулан ажилласан.<br>Нийслэл хотод шөнийн цагаар гудамж талбайд /томоохон баар, цэнгээний газар, бүлэг бөөгнөрөл цуглардаг эмзэг цэг байршилд/-д явган эргүүл ажиллуулах, чиглэлээр өгсөн үүргийн хүрээнд тус хэлтсээс хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг, шөнийн цэнгээний газар архи согтууруулан ундаагаар үйлчилдэг аж ахуй нэгж байгууллага, түүний гадна орчин болон нийтийн эзэмшлийн гудамж талбайд согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, "Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль"-ийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр үүрэг гүйцэтгэх алба хаагч нарыг томилгоожуулж, хуваарь томилгоог тухай бүр "Хэв журмын хэлтэс"-т хүргүүлэн ажиллаж байна. Үүрэг гүйцэтгэх алба хаагчдын албаны дүрэмт хувцас, нэг бүрийн тусгай хэрэгсэлд дэмжлэг үзүүлэн, мэргэжил, арга зүйн зөвлөмжийг танилцуулан ажиллаж байна. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагууд 21 насанд хүрээгүй иргэнд согтууруулах ундаа худалдан борлуулахгүй байх, хүүхдийн дэргэд утаат тамхи татахгүй байх мөн хариуцсан нутаг дэвсгэрт шөнийн цагаар үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр 3 төрлийн видео, 3 төрлийн постер бэлтгэж тус газрын фейсбүүк цахим хаяг, "Зөгий.мн", "Хүлэг.мн" мэдээний сайтуудад байршуулан олон мэдээллийн арга хэлбэрээр нөлөөллийн арга хэмжээг төлөвлөн зохион байгуулан ажилласан. | 100% | ХЭЗХ | ЦГ | 100% |
| 5.6.6 Архи согтууруулах ундаа, хар тамхи, мансууруулах бодис, утаат болон электрон тамхины хор нөлөөг ойлгуулах, хэрэглэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр өсвөр насны хүүхэд, залуучууд, олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажил, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 194 | 5.6.6.1 "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх" сургалт болон бусдыг хамгаалах талаар нөлөөллийн олон талт арга хэмжээ зохион байгуулна. | 2025-2028 | 40.0 | Дүүргийн төсөв | Арга хэмжээ | Тоо | 1 | 2 | - | - | Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар, Дүүргийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтарсан ***"Анзаар-2"*** арга хэмжээний хүрээнд ЕБС-ийн 39, 57, 61, 72, 17, 117, 49 дүгээр сургуулийн 9-12 ангийн 1840 сурагч, 460 эцэг эх, асран хамгаалагчид ***"Мансууруулах, эм сэтэгцэд нөлөөлөх бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх, Электрон тамхины хор уршиг"*** сэдвүүдээр сургалт зохион байгуулан хамтран ажилласан. Мөн хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд еөрнхий боловсролын сургуулийн орчид утаат тамхи худалдан борлуулж байсан 5 зөрчил илрүүлэн холбогдох хуулийн хариуцлагыг тооцон энэ талаарх мэдээллийг Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэст тухай бүр мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна. | 100% | ХЭЗХ | ЦГ | **100%** |
| Шаардлагатай хөрөнгө | | | | | | | | | | 0.0 | 0 | | | | | |
| **Нэгдсэн дүн (хувь)** | | | | | | | | | | | | | | | | **82%** |